

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТ, МЭДЭЭЛЭЛ
СУРТАЛЧИЛГААНЫ ҮНДЭСНИЙ ТӨВ**

хууль дээдлэх ёс

№ 2

*Улаанбаатар хот
2003 он*

ЭРХЭМ УНШИГЧ ТАНАА

Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ, сургалт, мэдээлэл, сурталчилгааны Үндэсний төв /ХЗҮТ/-өөс эрхлэн гаргаж байгаа хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгаа, онол, практикийн улирал тутмын хэвлэл "Хууль дээдлэх ёс" сэтгүүлийн хоёрдахь дугаар таны гарч очлоо. Энэ сэтгүүлийг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах нийт байгууллагад ажиллагчид, төрийн болон төрийн бус байгууллага /Иргэний нийгмийн ба бизнесийн байгууллага г.м/ -ын хуулийн зөвлөх, эрдэмтэн судлаачид, хууль зүйн их, дээд сургуулийн багш, оюутан нарт зориулж байна.

Сэтгүүлд дараахь тогтмол булан байнга гарч уншигч, хэрэглэгчдэд гарын авлага болгох зорилго агуулж, сонирхсон судлаач эрдэмтэд, хуульчид хэн бүхэнтэй хамтран ажиллаж, таны бүтээл түүрвильгээ хэвлэхэд бэлэн байна.

- Үндсэн хууль ба Төрийн байгуулалтын хууль тогтоомж,
- Иргэний хууль тогтоомж,
- Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй
- Криминологи
- Шүүх эрх мэдэл,
- Прокурорын хяналт,
- Эрх зүйн ўлгычилгээ, хууль зүйн зөвлөгөө /өмгөөлөл, нотариат/
- Дугаарын зочин /Хуульчидтай хийсэн ярилцлагага нийтлэл/

"Хууль дээдлэх ёс" сэтгүүлээр таны оюуны мэлмий гэгээрч, хууль зүйн мэдлэг зузаарч, мэдээлэл аввижих болтугай гэж өрөөгөөд таны захиалгад манай сэтгүүл багтана гэдэгт найдаж буйгаа уламжилъя.

"Хууль дээдлэх ёс"

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИ

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

- | | |
|---------------|--|
| Ц.Бат-Орших | - Сэлтүүлийн ерөнхий эрхлэгч |
| А.Доржготов | - Улсын Дээд Шүүхийн шүүгч |
| Н.Ганбаяр | - Шүүхийн срөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга |
| Б.Цэрэнбалтав | - Улсын срөнхий прокурорын орлогч |
| Б.Балган | - ХЗДХЯ-ны Терийн захиргаа, удирдлагын газрын дарга |
| Ж.Амарсангаа | - Хууль зүйн үндэсний төвийн захирал |
| Ж.Энхнасан | - Хууль зүйн үндэсний төвийн Захиргааны хэлтсийн дарга |
| Т.Мэндсайхан | - Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн сургалтын төвийн эрхлэгч |
| Э.Лхагвасүрэн | - Үндсэн хуудийн Цэцийн ажилтан |
| П.Цэцгээ | - Улсын Дээд Шүүхийн Судлаагааны төвийн захирал |
| А.Энхжав | - Иргэний бүртгэд мэдээллийн улсын төвийн дарга |
| Ж.Сайнжаргал | - ЦЕГ-ын Тамгын газрын дарга |
| Б.Пүрвөнэм | - Монголын Өмгөөлөгчдийн холбооны срөнхийлөгч |
| А.Оюунчимэг | - Монголын Нотариатчдын танхимын срөнхийлөгч |
| Г.Сумьяа | - Сэлтүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга |

ЭНЭ ДУГААРТ

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

- Монгол улсад захиргааны хэргийн шүүх байгуулах асуудал 7
Улсын Их Хурлын Тамгын газрын хуулийн хэлтсийн зөвлөх Н.Тунгалаг
- Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа 15
ХЗҮТ-ийн Териийн байгуулалтын хууль тогтоомжийн секторын ЭША Н.Отгончимэг
- ✓ Монгол Улсын эрх зүйн шинэцгэл 22
Өмгөөлөгч Иммануэль Гебхардт /ХБНГУ/
- ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх зөвхөн Үндсэн хуульдаа захирагдана 39
Үндсэн хуулийн Цэцийн ажилтан Э.Лхагвасүрэн

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

- ✓ Англи-Саксоны эрх зүй дэх хөрөнгийн барьцааны ойлголт, төрөл, баталгаажуулалт 45
ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн секторын ЭША магистр Ж. Баттуяа

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

- Чөлөөт бүсийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал 54
Олон улсын эрх зүйч А.Энх-Амгалан
- ✓ Харьцуулсан эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба конвергенци 59
Хууль зүйн үндэсний төвийн Олон улсын секторын ЭША Б.Гун билэг

КРИМИНОЛОГИ

- Криминологийн судлагааны найдвартай байдал, түүнийг дээшлүүлэх арга зам 65
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Г.Эрдэнэбат
- Монгол улсад терроризмтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх зарим асуудал 70
Хууль зүйн магистр Л.Батдолгор

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

- Шүүн таслах ажиллагаанд прокурор яллах үүрэгтэй оролцдог 74
Нийслэлийн прокурорын хяналтын прокурор Е.Сагсай

ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

- Барын Нэгдсэн Холбооны үндсэн шинж /Монголын хуульчдад загвар болгох нь/ 78
АНУ-ын Азийн эрх зүйн институтын захирал Жой Спурлок
- Нотариат иргэний эрхийг хамгаалдаг 87
Монголын Нотариатын танхимиын мэдээллийн албаны ажилтан П.Огтонжаргал

ДУГААРЫН ЗОЧИН

90

- Хуульчдын дундаас тэрсан анхны академич
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал, академич С.Нарангэрэлтэй хийсэн ярилцлага

ШИНЭ НОМ, СОНИН, СЭТГҮҮЛ

95

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

МОНГОЛ УЛСАД ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ БАЙГУУЛАХ АСУУДАЛ

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтсийн
зөвлөх Н.Тунгалаг

Монгол Улсад Захиргааны хэргийн шүүх байгуулахын чухлыг энэ чиглэлийн судалгаа хийдэг олон эрдэмтэн хүлээн зөвшөөрч байгаа билээ. Жишиг нь доктор Б.Чимид “Засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагаанаас болж зөрчигдсэн эрхээ хамгаалуулахаар иргэдийн гаргасан гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэдэг тийм шүүхийн дэд тогтолцоог бий болгох төлөвшүүлэх явдал мен.” “Захиргааны шүүхийн мэн чанар” Монголын тэр, эрх зүй сэвтүүл, 1999 он №2, Б.Чимид “Үндсэн хуулийн үзэл баримтлал” 2002 он, 132 дахь тал/ доктор Б.Мандахбилэг “Тэр нь хүний эрх, эрх чөлөөг хөнддөг ёс журам өрөөсөө захиргааны шүүхтэй байхыг шаардаж байна.”

Ийнхүү захиргааны хэргийн шүүх байгуулах нь шүүх засаглалыг бэхжүүлж, түүний үйл ажиллагааг шуурхай, үр ашигтай болгох иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг хянгах эрх зүйн механизмыг боловсронгуй болгох гол нехцэл болж байна.

Орчин үед ОХУ болон бусад оронд уг асуудлыг онолын төвшинд энэ институтыг хоёр хувилбар авч үзэж байна. Нэгд, захиргааны тусгайлсан шүүх байгуулах, хоёрт, ердийн болон дээд шатны шуухүүдийн бүрэлдэхүүнд төрөлжсен шүүх байгуулах явдал мен.

Монголын нехцелд захиргааны хэргийн шүүхийн “Германы загвар” тухайлбал шүүхийн системд захиргааны хэрэг хянан шийдвэрлэдэг бие даасан салаа буй болгох өөрөөр хэлбэрээ захиргааны хэрэг хянан шийдвэрлэх төрөлжсен шүүхтэй байх нь тохиromжтой байна. Тийм учраас гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд шүүхийн хяналтыг төрийн захиргааны байгууллага, эсхүл өрдийн шүүхийн харьяаллын бус бие даасан эрх хэмжээ бүхий байгууллага хэрэгжүүлнэ.

Захиргааны хэргийн шүүхийн хэлбэр бол шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны төрөлжсен салаа мэн бөгөөд гүйцэтгэх засаглалын, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, нийтийн эрх зүйн төрөл бурийн институтын үйл ажиллагаа, нийтийн засаглалд шүүхээс тавих хяналтыг хэрэгжүүлэгч нь болж байна. Захиргааны хэргийн шүүхэд иргэн, хуулийн этгээдээс төрийн болон орон нутгийн байгууллага, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанд гомдол, нэхэмжлэл гаргаж буй маргаан болно.

Монгол Улсад захиргааны хэргийн шүүх байгуулах явдал дараах үндсэн шалтгаантай билээ. Үүнд:

1. Эрх зүйт төрийн стандартад нийцсэн шүүхийн тогтолцоог хангах зарчим, хэм хэмжээг Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан.

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

Үндсэн хуулийн оршилд эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгохоор заасан. Эрх зүйт терийн үед шүүх засаглал нь хууль тогтоох ба гүйцэтгэх засаглалын нэгэн адил терийн засаглалын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг билээ. Гүйцэтгэх засаглалын байгууллага чиг үүргээ хууль тогтоох засаглалаас тогтоож өгсөн хүрээнд хэрэгжүүлж байдал бөгөөд улмаар шүүх засаглал баталгаа болж байна. Терийн онцгой үйл ажиллагаа болох шүүх засаглалыг хэрэгжүүлэхэд хууль хэрэглэх, зохицуулах, эрх хамгаалах элемент илэрч, иргэн бур хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэйн бодит болон эрх зүйн үндсийг тодорхойлж байна. Тийм учраас шүүх засаглал нь оновчтой бутацтай, шаардлагатай бол төрөлжэн байж болох юм. Эрх зүйт терийн нэг гол шинж бол иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг хангах чадахуйц захиргааны шүүх бүрэлдэн тогтсон явдал билээ. Францын эрдэмтэн Ж.Шевалье "эрх зүйт тер түүхэн хөгжлийн явцдаа хуулиар удирдуулж, хуулиар хязгаарлуулсан засаг мэн болно" гэжээ.

Манай улсад одоог хүртэл иргэн болон терийн захиргааны байгууллага хоёрын хооронд гарсан маргааны хянан шийдвэрлэдэг хараат бус шүүх байхгүй байгаа нь шүүхийн системийг бүрдүүлэхэд хэт явцуу, ардчилсан бус байдлаар хандаж байгаагийн тод жишээ болно. Захиргааны хэргийн шүүхийн асуудал Монгол орны эрх зүйн системийн бодит нехцел болж байхад энэ асуудалд хууль тогтоох засаглалаас хангалтгүй анхаарч ирлээ.

"Социализм"-ын үед манай оронд энэ асуудлыг гүйцэтгэх засаглалын байгууллагын шийдвэрээр зохицуулж иржээ. Жишээ нь "Гомдол маргаалдааныг эзлийн дараагаар таслан барагдуулах журмын тухай" Сайд нарын Зөвлөлийн 1945 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 80 дугаар тогтоолоор, "Терийн байгууллагаас хөдөлмөрчдийн өргөдөл, гомдол, мэдээллийг авч шийдвэрлэх зөвхөө"-ыг Сайд нарын Зөвлөлийн 1957 оны 209 дүгээр тогтоолоор, "Иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах шийдвэрлэх" журмыг Сайд нарын Зөвлөлийн 1973 оны 250 дугаар тогтоолоор тус тус баталсан байна.

Монголын шүүхийн системийг олон улсын эрх зүйн стандартад нийцүүлэх шаардлага

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх байгууллага байгаа эсэх нь үндэсний шүүхийн систем олон улсын тэр, эрх зүйн стандартад нийцэж байгаа эсахийн нэг гол үзүүлэлт байдал бөгөөд тухайлбал эрх зүйн бүх субъектэд үр ашигтай, шударга шүүхээр хангуулах болопцоотойг илэрхийлж байгаа билээ. Үндэсний шүүхийн систем нь аливаа иргэн, хуулийн этгээдээс шүүхэд хандах эрхийг нь хангах, эрх чөлөө, хууль есны ашиг сонирхол нь зөрчигдсөн хэн ч хуульд заасны дагуу үр ашигтай, түргэн, найдвартайгаар шүүхэд хандаж хамгаалуулах эрхтэй байхын баталгаа болж байна. Иргэн бүр маргаанаа шийдвэрлүүлэх зорилгоор шууд шүүгчид хандах бөгөөд уг шүүгч нь бие даасан хараат бус байх зарчим дээр үндэслэгдсэн байх тохиолдолд шүүхийн систем үр ашигтай үйлчилж байна гэж үзнэ. Захиргааны хэргийн шүүх байхгүй байгаа явдал шүүхээр хамгаалуулах хүний эрхийг хязгаарлаж байгаагийн нэг илрэл юм.

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

Монголын шүүхийн системийг боловсронгуй болгох, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх мэргэшсэн шүүхийн боловсон хүчинтэй болох шаардлагав

Тус оронд захиргааны үр ашигтай системийг байгуулах үйл явц ережиж улмаар төрийн албыг хөгжүүлэн бэхжүүлэх хууль тогтоомж боловсронгуй болж байгаагийн зэрэгцээ гүйцэтгэх засаглалын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой үүссэн маргааныг хянан шийдвэрлэх үүрэг бүхий мэргэшсэн шүүхтэй болох шаардлагатай байна. Жишээ нь захиргааны байгууллага, албан тушаалтны оновчтой бус үйл ажиллагааны үр дунгийн улмаас, эсхүл гаргасан шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүүн талаара болон иргэний эрх, эрх чөлөөг хамгаалахаар захиргааны хэрэг хянан шийдвэрлэх үүрэг бүхий төрөлжсөн шүүх байгуулах нь тухайн салбартай холбоотой хэргийг шуурхай хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой билээ.

Ардчилсан шүүхийн системийг бурдуулэх нь дэлхий нийтийн стандартад нийцэж, тухайн төрлийн хэргийг мэргэшсэн шүүхээр хянан шийдвэрлүүлэхэд илүү үр дүнтэй чанартай, шударга шийдвэр таргахад нөвлөөн. Ийнхүү төрөлжсөн шүүх байгуулах үзэл баримтлал нь шүүх нь зөвхөн хуульд заасан үндэслээр байгуулагдана гэсэн шүүхийн нэгдмэл системийн зарчим зорчигдэхгүй байгаа юм.

Иргэний, эсхүл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхдээ шүүгч нь иргэний болон эрүүгийн материаллаг эрх зүйг заавад мэдэх үүрэгтэй. Энэ үүднээс ердийн шүүхүүд шүүгч нараа эрүү болон иргэний хэргийн чиглэлээр мэргэшүүлдэг байна. Үүнээс үзэхэд захиргааны шинэ хууль тогтоомж бүрэлдэн тогтох, захиргааны /нийтийн/ эрх зүй бүхэлдээ шиночилгэдэг байгаа оноогийн нөхцөлд захиргааны хэргийг мэргэшсэн шүүгч, шүүх хянан шийдвэрлэж байх шаардлагатай урган гарч байна.

Иргэн, захиргааны байгууллага хоёрын хооронд үүссэн маргааны хянан шийдвэрлэж байгаа шүүгч удирдлагын эрх зүй, захиргааны практик, захиргааны хууль тогтоомжийг нарийвполн мэдэж байх ёстой. Өнөөдөр үйлчилж байгаа захиргааны хууль тогтоомжийн систем маш түвэгтэй байгаа. Жишээ нь практик дээр санхүүгийн болон татварын эзэрээтийн маргаан, эрүүл мэндийн, цагдаагийн, гавлийн байгууллага, газар зохион байгуулалт, ариун цэврийн хяналтын үйл ажиллагаатай холбоотой маргаан олон тоогоор гарах болов.

Хувь хүний эрх зүйн баталгааг өргөжүүлж, иргэний эрх, эрх чөлөөг хангана

Иргэн болон захиргааны байгууллага хоёрын хооронд үүссэн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй төрөлжсөн шүүх байгуулах нь захиргааны эрх зүй болон удирдлагын процесст хувь хүний эрх зүйн баталгааг өргөжүүлэх үзэл санаатай нийцэж байгаа билээ. Иргэдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг найдвартай хамгаалах явдал нь шүүхийг цоо шинэ төвшинд өөрөөр хэлбэл гүйцэтгэх засаглал, төрийн болон орон нутгийн байгууллагын зүгээс хүний эрхийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг эсэргүүцхээ чадвартай систем болгон хөгжүүлэх шаардлагатай байна.

Манай оронд хүний эрхийн үзэл санаа монголын хөрөнгөн дээр бүрэлдэн тогтох, тэдгээрийг сахин хамгаалах явдлыг хангах объектив

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

үндэс нь тун удаашралтай бүрэлдэж байгаа гэсэн дүгнэлт хийхэд хүргээд байгаа билээ. Мен хүний эрх, эрх чөлөөг ханган бэхжүүлж байгаа хууль тогтоомжийн баазыг хөгжүүлахэд тодорхой чиглэл дутагдаж байна. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан хүний өргөн эрх, эрх чөлөө нь хуульчлан бэхжүүлэгдсэн ёс тэдий боломж мен. Тэдгээрийг бодит харг болгохи тулд одоогоор хараахан байгуулагдаж амжаагүй байгаа тодорхой нөхцөл, баталгаа шаардлагатай билээ. Эдгээр баталгаа, эрх зүйн хэрэгслийн дотор захиргааны шүүхийн механизм чухал байр суурь залэх ёстой.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасны дагуу иргэн хүн Монгол Улсын хууль, олон улсын гарзэнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсэн гэж үзвэл эрхээ хамгаалулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж заасан билээ. Улмаар териин байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон тэдгээрийн албан тушаалтиас гаргасан шийдвэр, үйлдэл хүний эрх, эрх чөлөөг зөрчиж байна гэж үзвэл шүүхэд гомдлоо гаргах болно. 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн Иргэний эрхийг хохироосон териин захиргааны байгууллага, албан тушаалтын хууль бус үйл ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах журмын тухай хууль баталж хүний эрхийг шүүхэд хамгаалах механизм буй болгох анхны оролдлогыг хуульчилж өгсөн билээ. Гэвч нэгдүүзээрт, энэ хуулийг хэрэгжүүлэх механизм нь тодорхой бус, хоёрдугаарт, "социализм"-ын түүхэн уламжлалт ёсоор манай иргэд дээр дурдсан асуудлаар шүүхэд гомдлоо гаргахгүй, харин "дарга", "намын үүрт" гомдлоо гаргадаг тогтсон зарчимтай байв. Гуравдугаарт, хүн амаас шүүхэд хандах хандлага енеедрийг хүртэл итгэл дүүрэн биш байсан. Иймд териин байгууллага, албан тушаалтын үйл ажиллагаатай холбогдсон гомдлоо иргэд шүүхэд гаргахаа хүсэхгүй байгаа явдалдаа биш харин энэ журмаар нэхэмжлэл гаргах нөхцөл бүрэн хэмжээгээр бурдзэгүй байгаад оршиж байгаа билээ. Иргэний хэргийн бүтцэд сонгуулийн эрхийг хамгаалах, иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн хэм хэмжээний акт, шийдвэр, үйлдэлтэй холбоотой хэрэг цөөн тоогоор ч гэсэн зохих байр суурь эзлэх боллоо.

Захиргааны процесс, захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг батлах журмын тухай хууль тогтоомжийг боловсруулах талаар

Захиргааны шүүх байгуулах асуудалтай холбоотойгоор захиргааны процесс болон хэм хэмжээ тогтоосон захиргааны актыг боловсруулах, батлах, захиргааны тэрэл байгуулах, захиргааны төрөл бүрийн үйлдэл хийх, захиргааны арга хэмжээ төлөвлөх, удирдлагын хүрээнд төрөл бүрийн ажил явуулах зэрэг асуудлыг хуульчлан тогтоож егех шаардлагатай байна.

Зах зээл хөгжсөн олон оронд удирдлагын тухай төрөлжсөн хууль, захиргааны хүрээн дэх хянан шийдвэрлэх үйл ажиллагааны тухай зэрэг хууль үйлчилдэг байна. Монгол Улсад удирдлагын салбар дахь энэхүү харьцаа эрх зүйн стандартад дөхж байна. Тухайлбал энэ хүрээний асуудлыг жигдлэн зохицуулах нэг оролдлого бол 1997 онд Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль батлан мөрдүүлж, 2001 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн хуулиар шинчлэн найруулжээ. Захиргааны удирдлагын шийдвэр боловсруулах, дагаж мөрдүүлэх, өөрчлөх журмыг зохицуулсан эрх зүйн акт манайд одоо хүртэл байхгүй байгаа нь Монголын захиргааны хууль тогтоомж, захиргааны эрх зүй "хөгжеегүй" байгаагийн нэг тод илрэл билээ.

Иймд захирганы процесийн хүрээн дэх хууль тогтоох үйл ажиллагааны гол чиглэл бол захиргааны удирдлагын / процедурыг зохицуулсан хуулийг юуны түрүүнд батлах шаардлагатай байна.

Захиргааны албан тушаалтан, териин болон орон нутгийн байгууллагын албан хаагчийн үйл ажиллагаанд мөрдөгдхөх захирганы процедурыг хуульчлан зохицуулах нь хуулийн зерчлийг арилгахад тус дехем болох бөгөөд албан тушаалтан захиргааны эрх зүйн статусаас хэрэгжүүлэхдээ веервэрийн хэлбэл түүнд олгогдсон эрх хэмжээнийгээ хүрээнд байх, териин байгууллагын бүрэн эрхийг зерчихгүй байхад туслаццаа үзүүлнэ. Олон орцон захиргааны процедурын хэм хэмжээг агуулсан хууль тогтоомжийг бөгөөд тэдээр хуулиар маргаантай болон маргаантай бус процедурыг зохицуулдаг байна. Хэрэв эдгээр захиргааны процедурын хүрээн дэх үйлдэл, гаргасан захиргааны шийдвэр нь иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн бол иргэн, хуулийн этгээд нь тухайн үйлдэл, захиргааны шийдвэрийн талаарх гомдолоо дээд шатны захиргааны байгууллагад гаргана: Зарим орцон захиргааны журмаар гомдолоо гаргаж, уг шийдвэрийг нь зөвшөөрөгүй тохиолдолд шүүхэд гомдолоо гаргах боломжтойг журамлан тогтоодог байна.

Иймд удирдлагын процессын талаархи хууль тогтоомж нь захиргааны байгууллага, албан тушаалтнаас хууль зөрчин гаргасан шийдвэр, эс үйлдэхүйн талаар шүүхэд гомдолоо гаргах иргэний эрхийг хэрэгжүүлэх журам нарийвчлан тогтоодог.

Териин болон орон нутгийн захирганы удирдлагын шинчлэлийн талаар

Зах зээлийн здийн засаг хөгжин гүнзгийрэх тутам иргэдээс төр / териин болон орон нутгийн байгууллага / болон нийтийн эрх зүйн бүх институттэд тавих шаардлага улам бүр есөж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “эрүү, иргэн, захиргааны зэрэг дагнасан шүүх байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагааг шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.” гэсэн заалтыг иш үндэс болгож Улсын Их Хурал 1998 оны 1 дүгээр сарын 22-нд “Монгол Улсын эрх зүйн шинэцгэлийн хетэлбэр” баталж түүнд шүүн таслах ажлын төрлөөр дагнасан шүүх байгуулахаар эрх зүйн үндсийг бүрдүүлэхийг заасан нь нэг алхам урагшаа болсон байна. Улмаар 2002 оны 7 дугаар сарын 4-нд батлагдсан Шүүхийн тухай хуульд дагнасан шүүхийн асуудлыг зохицуулсан явалд шүүхийн тогтолцоо, системд захиргааны хэргийн шүүх байгуулахаар үзэл баримтлалын үргэлжлэл болсон билээ.

Шүүхээс иргэн болон гүйцэтгэх засаглалын байгууллага, албан тушаалтан нарын хооронд үссэн маргааныг хянан шийдвэрлэх тоо есөх хандлагатай байна. Тухайлбал, шүүхийн статистик судалгаанаас үзэхэд бүх шатны шүүхээс шийдвэрлэсэн иргэний хэргийн тоо 2000 онд 21 717 байснаа 2001 онд 23252 болж есセン үүний дотор гомдолоор үссэн хэргийн тоо 2000 онд 130 гаруй байснаа 2001 онд 170 гаруй болж нэмэгджээ.

Орчин үеийн нийгэм-здийн засгийн амьдралын бэрхшээлтэй байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа зэргээс шалтгаалж иргэд нийтийн эрх зүйн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

гомдлоо шүүхэд гаргахаа яарахгүй байгаа бөгөөд харин захирагааны байгууллагад гомдлоо гаргаж байгаа нь илүү зохимжтой, хялбар гэж үзэж байдагт нарийн учир оршиж байна. Урт удаан хугацааны турш үргэлжлэх шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаа хүн бухэнд хундрэлтэй, ялангуяа захирагааны байгууллагын шийдвэр батлагдаж иргэний хувьд тааламжгүй эрх зүйн үр дагавар нэгэнт үсэн бий болсон байдал. Эрх чөлөөт, ардчилсан нийгэмд, эрх зүйт төрд амьдарч байгаа иргэн терийн захирагааны байгууллагаас гаргасан эрхийг нь зөрчинж буй шийдвэр, үйлдлийн талаар зайлшгүй мэдэрч байх үүрэгтэй.

Хууль хэрэгжүүлэх явдал нь эрх зүйн акт гаргах болон тодорхой үйлдэл гүйцэтгэснээр илэрч тэдгээр нь хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх шийдвэр болж байна. Эрх зүйн акт нь баримт бичгийн хэлбэртэй байхад үйлдэл нь тийм хэлбэр агуулаагүй байж болно. Гэхдээ ихэнхи тохиолдолд хууль хэрэгжүүлэх үйлдэл нь гол төлөв баримтжсан хэлбэртэй байдаг.

1993 оны 5 дугаар сарын 6-ны өдөр баталсан Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3-т терийн захирагааны төв болон нутгийн захирагааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж буй эсэхад хяналт тавих тухай, мен хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 3-т терийн захирагааны байгууллагын шийдвэрийн хууль зүйн үндэслэлийн хяналтыг хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтак байна. Энэ асуудлын нарийвчлан зохицуулалт зорилгоор Засгийн газрын 1993 оны 162, 1997 оны 178 дугаар тогтооюу Монгол Улсын Сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг хянаж буртгэх журыг тус тус батлан мөрдүүлсэн юм.

Хууль зүйн асуудал эрхэлсэн терийн захирагааны төв байгууллага нь нутгийн болон терийн захирагааны байгууллагын хэм хэмжээ тогтоосон тушаал, шийдвэрийг авч хянадаг срон тооны нэг тушмэлтэй байнаас одоо үгүй болгож, хуулийн тесэл боловсруулах ажлын хавсарга болгон хувиргасан нь ажил цалгардуулах болжээ. Одоогийн байдлаар улсын бүртгэлд 1991 оноос хойших хугацааг хамарсан нийтээр дагаж мөрдүүлэхээр яам, Засгийн газрын агентлагаас гаргасан нийт1900 гаруй эрх зүйн акт бүртгэгдсэн тооцоотой байна. Эдгээр актаас хууль тогтоомж зөрчсөний улмаас дээд шатны байгууллагаар / Засгийн газраар/ хүчингүй болгуулсан тохиолдол ердөө л 1-2 байх жишээтэй.

Захирагааны шүүх байгуулж, захирагааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны асуудлыг хуульчлан тооглоо нь терийн албаны систем тухайлбал, терийн болон орон нутгийн байгууллагын хүрээнд авилгалтай тэмцэхэд чухал хөшүүрэг болно. Авилгал үүсэх нэг гол үндэс нь зохицуулан захирамжлах эрхийн акт болон хэм хэмжээ тогтоосон эрхийн бусад актыг боловсруулах, батлан гаргах асуудлыг журамлан тогтоосон хууль тогтоомж боловсронгуй бус байгаа юм. Авилгалын талаар албан тушаалтнууд байнга ярьдаг, гэхдээ энэ үзэгдэлтэй тэмцэх талаар 2002 онд баталсан Эрүүгийн хуульд авилгалтай холбоотой зүйл ангийг тодруулсан, Улсын Их хурлаас авилгалтай тэмцэх хөтөлбөр гаргасныг эс тооцвол үр нелөөтэй, хууль зүйн арга хэмжээ авагдахгүй л байна.

Авилгальд илүү өртөгдхөх боломжтой байгууллагын талаар судалгаа авахад гааль, татвар, цагдаагийн байгууллагын ажилтнууд хэмээн нэрлэсэн байдал. Дээр дурдсан болон захирагааны бусад байгууллага,

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

албан тушавалтын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий захиргааны хэргийн шүүх байгуулагдсан тохиолдолд иргэнээс шүүхэд итгэлийг нэмэгдүүлж, зөрчигдсэн эрхээ хамгаaluлахаар тухайн шүүхэд хандах хусалт нэмэгдэх болно. Эцсийн дунд захиргааны шүүхтэй болсон явдал нь териин болон орон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтнаас үргээ билэулүүслэхийнхээ төлөө шан харамх нэхэз явдлыг багасгахад чухал нелее үзүүлнэ. Захиргааны шүүх нь авилгал дэлгэрэх боломжийг багасгахад туслах хүчин зүйл мөн. Учир нь нийтийн эрх зүйн байгууллагын хууль бус үйл ажиллагаатай холбоотой иргэн, хуулийн этгээдийн гомдлыг авч хэлэлцэхдээ захиргааны хэргийн шүүх нь авилгалын эх сурвалжийг олж тогтооход чухал нелее үзүүлнэ.

Захиргааны хэргийн шүүх байгуулах болон захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн төслийн явцын талаар

Захиргааны хэргийн шүүх байгуулах асуудлыг шийдвэрлэхдээ хууль тогтоогч нь захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа / захиргааны процесси/- ны тухай хуулийг батлан мөрдүүлэх шаардлагатай байна. Учир нь захиргааны процессиийн хэм хэмжээ нь иргэний процессиийн хэм хэмжээнээс ялгаатай байдаг. Иргэний субъектив нийтийн эрх зүйн эрхийг хамгаалах зорилго бүхий иргэн болон нийтийн засаглалын хооронд үссэн маргааныг хянан шийдвэрлэх хэлбэр болохын хувьд захиргааны хэрг хянан шийдвэрлэх ажиллагааны гол зорилт бол нийтийн засаглал болон түүний албан тушаалтнаас зөрчсөн иргэний эрх, эрх чөлөөг саргээх, дэг журмыг хангах, нийтийн удирдлагын тогтоосон дэгдэлмийг хангах, териин болон орон нутгийн байгууллагын албан тушаалтны дураараа авирлах явдалтай тэмцэх явдал билээ. Иргэний процессиийн гол зорилт бол иргэний хувийн амьдралын хүрээн дэх харилцааг хууль ёсны журамд оруулах явдал болно.

2002 оны 1 дүгээр сарын 10-нд баталсан "Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай" хуулийн гомдлоор авч хэлэлцэх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн 14 дүгээр бүлэгт гомдлоор авч хэлэлцэх хэрг, гомдлыг шүүхээр хэлэлцэх, шүүхийн шийдвэр гэсэн заалтыг агуулсан байна.

Захиргааны хэрг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн байр суурь идэвхитэй байх шаардлагатай. Захиргааны акт, удирдлагын шийдвэрийг олох, захиргааны байгууллага, териин албан тушаалтнаас иргэн эрх, эрх чөлөөг зөрчсөн шийдвэр, үйл ажиллагаа явуулсан нөхцөл байдлыг тодруулах зэрэг үйл ажиллагаа нь бие давасан хараат, хөндлөнгийн шүүхээр гүйцэтгэх нь зүйтэй байна. Захиргааны байгууллагын шийдвэр, үйлдэл нь хууль бус байгааг иргэн нотлох үүрэг хулээхгүй. Түүнийг захиргааны хэргийн шүүх гүйцэтгэх ёстой. Аливаа шийдвэр, үйлдлийн талаар иргэн нь териин захиргааны байгууллагатай эрх тэгш байдлаар ярилцах, маргалдах боломжкүй байдаг билээ. Захиргааны хэргийн шүүх байгуулах явдал нь гүйцэтгэх засаглалын субъектуудээс хүний эрх, эрх чөлөөнд илүү анхааралтай хандах бололцоо бүрдүүлнэ.

1998 оноос хойш Засгийн газар, Улсын дээд шүүхтэй хамтран Захиргааны хэрг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар энэ хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг 2001 оны 9 дүгээр

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

сард хийж ээсийн хэлэлцүүлэгт шилжүүлсэн. Гэвч одоог хүртэл энэ хуулийн тесел батлагдаагүй байна.

Энэ хуулийн төслийн дагуу захиргааны байгууллага, захиргааны албан тушаалтан, захиргааны акт, эс үйлдэхүй гэдэгт тодорхойлолт өгч, захиргааны байгууллага, албан тушаалтын гаргасан захиргааны хууль бус акт, эсхүл эс үйлдэхүй нь иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл энэ тухай гомдлоо иргэн тухайн захиргааны байгууллага, албан тушаалтныг харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд гаргаж шийдвэрлүүлах журмыг тодорхойлж, дараах шийдвэрийн аль нэгийг гаргахаар заасан болно. Үүнд:

- захиргааны акт нь илт хууль бус болохыг хулаэн зөвшөөрсөн,
- маргаан бүхий захиргааны акт нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох,
- захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол захиргааны зохих актыг гаргахыг тухайн байгууллага, албан тушаалтанд даалгах.

Мен хуулийн теслэд захиргааны хэргийг хянан шийдвэрлэхэд хэргийн ач холбогдол бүхий нотлоу баримтыг цуглуулах, тухайн захиргааны акт болон эс үйлдэхүй нь хууль бус, эсхүл иргэний хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчсөн эсэх талаар нотлох үүргийг захиргааны хэргийн шүүх хүлээнэ.

Монгол Улсад аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь анхан шатны шүүх байж, улмаар Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхим аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх анхан шатны журмаар шийдвэрлэсэн хэргийг давж заалдах шатны журмаар, Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн танхим давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэсэн болон анхан шатны шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэхээр тогтоох нь илүү зохимжтой байна.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙГ УРЬДЧИЛАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

ХЭҮТ-ийн Төрийн байгуулалтын хууль тогтоомжийн
секторын ЭША Н.Отгончимэг

Захиргааны байгууллагын үйл ажиллагааны гол шинж бол өдөр тутмын, тасралтгүй, байнгын байдагт оршино. Иймээс тэнд л тэр ба иргэний эрх, үүрэг, ашиг сонирхлын огтолцолыг хамгийн их байдаг. Энэ харилцаанд захиргааны актыг батлан гаргаж байгаа тал давуу эрхтэй байх учир түүний үйл ажиллагаан дахь хөндлөнгийн хяналт чухал юм. (Гэхдээ тухайн хяналт нь төрийн эрх мэдлийн саласаа мөчирүүдийн бие даасан, тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр явагдах ёстойг тэмдэглэх нь зүйтэй.) Тэгэхээр захиргааны хэргийн шүүх бол захиргааны акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх арга зам төдийгүй захиргааны байгууллагын үйл ажиллагааны хууль зүйн үндэслэлд хяналт тавих хэргэсэл болох юм.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас үзвэл иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэх захиргааны акттай холбоотой гомдол, нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаа үндсэн хоёр хэсэгт хуваагдаж байна.


1. Гомдлыг захиргааны байгууллагаас хянан шийдвэрлэх ажиллагаа
2. Нэхэмжлэлийг шүүхээс хянан шийдвэрлэх ажиллагаа

Захиргааны хэргийн шүүхээс нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь дээд шатны захиргааны байгууллагад тухайн гомдлыг хянан шийдвэрлэсэн ажиллагаатай шууд уялдаа холбоотой. Учир нь захиргааны хэргийн шүүхэд үндсэндээ дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг давж нэхэмжлэл гаргах юм.

Иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтны захиргааны акт түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл тухайн байгууллага, албан тушаалтныг шууд харьалах дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гомдлоо гаргана. (харьалах дээд шатны байгууллага, албан тушаалтан байхгүй тохиолдолд шууд захиргааны хэргийн шүүхэд хандана)

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

Захиргааны байгууллагад гомдол гаргах субъект



Гомдол нь төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар ирээдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зорчигдсон гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлт юм.

Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргах гомдол нь дараахь шаардлага хангасан байна. Үүнд:

- ✓ үнэн зөв байна;

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

- ✓ төрийн албан ёсны хэлээр гаргана. Төрийн албан ёсны хэл мэдэхгүй бол төрөлх хэлээрээ гаргаж болно;
- ✓ бичгээр гаргасан өргөдөл, гомдолд оршин суугаа газрын буюу шуудангийн хаягаа бичих, гарын үсэг зурсан байх. Хамтран гаргасан өргөдөл, гомдолд бүгд гарын үсэг зурах эсхүл төлөөлөгч гарын үсэг зурж, төлөөлөх эрхээ нотлох баримт бичгийг хавсаргах.

Дээд шатны байгууллага, албан тушаалтан гомдлыг хүлээн аваад дараах ажиллагаа явуулна:

- Гомдлыг тусгай бүртгэлд бүртгэх
- Бүртгэсэн гомдлыг түүнийг шийдвэрлэх албан тушаалтанд едерт нь багтаан шилжүүлэх
- Гомдлыг албан тушаалтан шууд хүлээн авч болно
- Гомдолд тавигдах шаардлагыг биелүүлээгүй бол уг шаардлагыг хангахыг мэдэгдэж, түүнийг өргөдөл гомдол гаргагчид З хоногийн дотор буцвана.
- Захиргааны акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах
- Гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, шаардлагатай бол эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдэд хэрэг шийдвэрлэх он, сар, едер, газрыг мэдэгдэж, уг ажиллагаанд хүснэгтээр байлцуулах.

Урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь хууль зүйн процесс болохын хувьд зохих байдлаар хэлбэржсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагааны талаар тэмдэглэл хөтөлнө. Тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:

- 1) шийдвэр гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг, албан тушаалтны овог, зэгийн нэр, нэр
- 2) шийдвэр гаргасан, хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа явуулсан он, сар, едер, газар
- 3) гомдол гаргагч, хариуцагч, бусад оролцогчын овог, зэгийн болон өөрийн нэр
- 4) гомдлын агуулга, шаардлага
- 5) шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг, бусад нотлох баримт
- 6) тэмдэглэл хөтөлсөн болон гомдлыг шийдвэрлэсэн албан тушаалтан, захиргааны байгууллагын эрх баригчийн гарын үсэг.

Ийнхүү дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан гомдлын дагуу хэргийг хянан үзээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргах юм. Үүнд:

1. Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх
2. Маргаан бүхий захиргааны акт нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бухэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох



ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

- Захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус эсүйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зэрчсөн бол захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгах

Захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрсөн шийдвэрийг гарцах тохиолдлуудыг хуулинд тусгасан байх бөгөөд тэдгээрийг дэлгэрүүлэн авч узье.

1. Утга агуулгын илэрхий алдаатай акт: Захиргааны акт утга агуулгын хувьд илэрхий алдаатай гэдэг нь хоёр байдлаар илрэн гарч болох юм. Нэгдүгээрт, найруулга ба хэл зүйн хувьд акт нь түүнийг гаргах болсон шалтгаан, зорилгод үйлчилж чадахгүй буюу нийцхгүй байгаа хоёрдугаарт, утга агуулга нь бурхэг, эсвэл хоёрдмол утгатай байгаа. Захиргааны актад найруулга, хэл зүйн алдаа тохиолдохыг угүйсгэх аргагүй. Тэдгээрийг тэр бүр анхааралдаа авч үзээд байх ч шаардлагагүй. Харин гапцуу тухайн утга агуулгын алдаа нь захиргааны актын сэдэл, зорилтыг хангаж чадахгүй хэмжээнд хурсэн бол түүнийг утга агуулгын илэрхий алдаатай гэж үзэх улмаар илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрч болох юм. Ингэхдээ захиргааны акт нь ямагт нийгмийн тусын тулд, нийтлэг ашиг сонирхлыг хангах зорилгод үйлчилсэн байх шаардлагатай. Хоёр дахь тохиолдлын хувьд, захиргааны актын утга агуулгын бурхэг, хоёрдмол байдлын улмаас талуудын хооронд маргаан үүссэн бол актыг утга агуулгын алдаатай гэж үзэн илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрхөн нь зүйтэй. Утга агуулгын бурхэг хоёрдмол байдал нь хууль зүйн нэр томъёог буруу ойлгож хэрэглэх, олон салаа утгатай уг, хэллэгийг аль утгаар нь хэрэглэх байгааг тайлбарлаагүйгээс үүдэлтэй байдааг.

2. Бичгийн хэлбэрээр гаргасан захиргааны актыг батлан гаргасан байгууллага албан тушаалтан тодорхойгүй: захиргааны актад тавигдах нэг гол шаардлага бол батлан гаргасан этгээд тодорхой бай явдал юм. Бичгээр гаргасан захиргааны акт нь баримт бичгийн бурдэл хэсгүүдийг хангасан байж цааш хүчин төгөлдөр үйлчлэх боломжтой. Энэ шаардлаагыг хангаагүй бол тухайн захиргааны актыг илт хууль бус гэж үзэн.

3. Захиргааны акт гаргах эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан: акт гаргах эрх хэмжээгүй гэдэг нь акт гаргах захиргааны байгууллага, албан тушаалтны эрх хэмжээг негеэ нь шилжүүлэн (хууль бусаар) хэрэгжүүлсэн, эсвэл тухайн чиглэлийн асуудлыг шийдвэрлэх эрх хэмжээгээ хэтрүүлсэн, эцэст нь өрөөс эрх хэмжээ олгогдоогүй захиргааны байгууллага, албан тушаалтан акт батлан гаргасан зэрэг хэлбэрээр илрэн гарна. Захиргааны акт гаргах эрх хэмжээгүй тогтооно гэдэг нь нэг эрх зүйн хэмжээг негеэвтэй нь харьцуулан судалж, жишин шалгана гэсэн уг мөн.

4. Захиргааны актыг гүйцэтгэх субъект тодорхой бус: захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргах акт ямагт тодорхой хууль ёсны зорилго, сэдэл, шалтгаан агуулсан байна. Захиргааны актад тавигдаж буй зорилго нь түүний хэрэгжилтээс шууд хамааралтай. Тухайн актыг хэрэгжүүлж гүйцэтгэх субъект тодорхой бус байгаа гэдэг нь захиргааны актыг аливаа шалтгаан, шаардлагагүй гаргасныг харуулах юм.

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

Иймд гүйцэтгэх субъект тодорхойгүй нь захиргааны актыг илт хууль бус гэж үзэх үндэслэл болно.

5. Хууль бус үйлдэл, эс үйлдэхүй гүйцэтгэхийг шаардсан: Тухайн актыг биелүүлэх субъектээс гүйцэтгэвэл хууль зүйн зохих хариуцлага хүлээх үйлдэл, эс үйлдэхүй хийхийг шаардсан захиргааны акт нь илт хууль бус байна.

6. Нийтийн ёс зүйн хэм хэмжээг илт зөрчсен: Эрх зүйн хэм хэмжээнээс ёс зүйн хэм хэмжээний гол ялгагдах шинж бол бичмэл бус байдагт оршдог. Ёс зүйн хэм хэмжээ төрөөс хуульчлагдаж, бичмэл халбэртэй болох уед эрх зүйн хэм хэмжээ болон хувирдаг. Нийтийн ёс зүйн хэм хэмжээнэй энэ шинж нь түүнийг бодит байдлаар хүлээн авч, тодорхой асуудлуудыг шийдвэрлэхэд харгалзан үзэхэд зарим бэрхшээл учруулж болох талтай. Гэхдээ "ёс зүй нь хууль зөрчихийг шаардаа ёстгүй, эрх зүйн нь веерийн хэм хэмжээндээ ёс зүйн зарчимд нийцээгүй асуудлыг хуульчлах ёстгүй" гэсэн томъёоллыг баримтлан үзвэл нийтийн ёс зүйн хэм хэмжээг тодорхойлохын тулд эрх зүйн хэм хэмжээнээс тэдийлон холдоод байх шаардлагагүй юм. Нийтийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсен гэдгийг тогтоохын тулд юуны түрүүнд ёс суртхуун, ард түмний зан заншилийн үнэт зүйлсийн үүднээс хандаж, улмаар "сайн" ба "муу" гэдэг хоёр шалгуурыг зэрэгцүүлэн тавыж эргэцүүлэх нь зүйтэй.

7. Захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй: захиргааны байгууллага, албан тушаалтан нийтийг засагласан үйл ажиллагаага ямагт хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлнэ. Бүрэн эрх олгогдоогүй аливаа нэг үйл ажиллагаа тэр дундаа захиргааны акт гаргах ажиллагаа хууль бус юм. Иймд эрх зүйн үндэслэл байгаагүй гэдэг захиргааны акт гаргах талаараа хууль тогтоомжид огт заагаагүй байх буюу холбогдох хууль тогтоомжийг баталж гаргаагүй, эсхүл эрх зүйн зохих үндэслэлийг захиргааны актад тусгаагүй байхыг ойлгоно.

8. Захиргааны акт гаргах хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн: захиргааны зарим төрлийн актыг гаргахад хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон байх ба тэрхүү хугацааг зөрчиж гаргасан захиргааны акт илт хууль бус байна.

9. Захиргааны акт өөр бусад байдлаар холбогдох хууль зөрчсен: дээрх тохиолдолоос гадна бусад байдлаар холбогдох хуулийг зөрчсен актууд нь илт хууль бус байна.

Маргаан бүхий захиргааны акт иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчsen нь тогтоогдсон бол захирганы байгууллага, албан тушаалтан уг актыг хүчин төгөлдөр үйлчилж байва, эсхүл ирээдүйд хүчин төгөлдөр болох эсэхээс үл хамааран бүхэлд нь буюу холбогдох хэсгийг хүчингүй болгосон шийдвэр гаргана.

Дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан дараахь тохиолдолд захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллага, албан тушаалтанд даалгана.

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

- захиргааны акт гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан шийдвэр байгаа бол түүнийг хүчингүй болгож, захиргааны акт гаргах
- захиргааны байгууллага, албан тушаалтны эс үйлдэхүйн улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсэн нь тогтоогдсон.

Хуулийн заалтуудыг зөв ойлгон, веерийн тохиолдолд нехцлүүдэд хөрвүүлэн хэрэглэх нь зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо сэргээн тогтоолгоо гаргасан нэхэмжлэл хангагдаа боломж бурдэнэ гэсэн уг юм. Негee талаар хуулийн дагуу гаргасан нэхэмжлэл нь шүүхийн үйл ажиллагаваа болон иргэнд өөрт нь цаг хугацааны хэмнэлттэй байж, зардал, чирэгдэл, хүндрэл үүсгэхгүй байх ач холбогдолтой.

Үрьдчилан хянан шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналтийн

Иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллага, албан тушаалтнаар гомдлоо шийдвэрлүүлэх явцад тэнцвэргүй харилцаанд орох буюу захиргааны байгууллага, албан тушаалтны эрх хэмжээний давуу байдалтай байдаг. Энэ нехцелд гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавих хяналти чухал юм.

Иргэдээс терийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд зааснаар терийн байгууллага, албан тушаалтан гомдлын талаар дараах үүрэг хулзэнэ. Үүнд:

- 1) иргэдээс өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэх нехцелийг бүрэн хангах;
- 2) харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдлыг зававал хүлзэн авах;
- 3) өргөдөл, гомдолд дурдсан асуудал бурийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй шийдвэрлэх;
- 4) өргөдөл, гомдлыг хугацаанд нь барагдуулах;
- 5) өргөдөл, гомдолд дурдсан тэр, байгууллага, хувь хүний нууцыг хадгалах;
- 6) өргөдөл, гомдолд үндэслэл бүхий хариу өгөх;
- 7) веерийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэхгүй байх.

Эдгээр үүргийн хэрэгжилтэд хяналт тавих нэг арга зам бол биелүүлээгүй тохиолдолд холбогдох этгээдээс хариуцлага хүлээлгэх явдал юм.

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

Сахилгын шийтгэлийг эрх бүхий албан тушаалтан дараахь тохиолдолд ногдуулна. Үүнд:

- харьяаллын дагуу ирсэн гомдлыг завал хүлээн аваагүй;
- гомдлыг хугацаанд нь барагдуулаагүй;
- гомдолыг үндэслэл бүхий хариу өгөгүй;
- өөрийн эрх хэмжээнд хамаарах гомдлыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн;
- амаар биечлэн гаргасан гомдлыг түүнийг хүлээн авах үүрэг бүхий ажилтан тэмдэглэн авч, буртгэзгүй;
- гомдлыг түүнд холбогдож байгаа албан тушаалтанд өөрт нь шилжүүлсэн.

Дараахь тохиолдолд шуугч 1000-15000 төгрөгөөр торгох шийтгэлийг ногдуулахаар хуульчилсан. Үүнд:

- Гомдолд дурдсан төр, байгууллага, хувь хүний нууцыг задруулсан;
- Гомдлыг хуульд заасан 30 хоногийн хугацаанд шийдвэрлэзгүй;
- Гомдлын талаар гарсан шийдвэрийг холбогдох этгээд биелүүлэзгүй.

Хуульд заасан эдгээр механизмыг ашиглан зөрчигдсөн эрхээ сэргээлгэх нь иргэд, хуулийн этгээдийн хувьд нарийн төвөгтэй биш, энгийн санаадана. Гагцүү захиргааны байгууллага, албан тушаалтын үүргийн биелэлтэд хяналт тавих бодитой хэрэгсэл болгох эсэх нь тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, шүүгчээс төдийгүй иргэн, хуулийн этгээдээс ихээхэн шалтгаалах юм.

Ашигласан ном

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
2. Захиргааны хэргэ хянан шийдвэрлэх тухай хууль. 2002
3. Ч.Нямсурэн. Эрх зүй, төрийн өрөнхий онол. УБ., 2001
4. Ричард Поупкин, Аврум Стролл. Гүн ухаан. УБ., 1998
5. Ю.Н. Старилов. Административная юстиция. М., 2001
6. Под.ред. А.Н.Козырина. Административное право зарубежных стран. М., 1996
7. Ж.Ведель. Административное право Франции. М., 1973
8. Справочник по вопросам проверки законов и постановлений-рекомендаций по конституционному и единообразному оформлению правовых предписаний. Федеральное Министерство Юстиции ФРГ. М., 1995
9. С.Жанцан. Шүүх засаглал. УБ., 1999
10. Административное право Франции.. М., 1998

МОНГОЛ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ

Өмссөөлөгч Иммануэль Гебхардт /ХБНГУ/

Монгол улс далхийн хоёр их гурэн болох Хятад, Орос хоёрын дунд оршдог хэдий ч далхий нийтийн анхааралын төвд байдаггүй нь харамсалтай. Хэдийгээр Монгол улс хүн амын тоогоор цөөн боловч стратегийн ихээхэн ач холбогдол бүхий томоохон нутаг дэвсгэртэй. Шилжилтийн оруулад явагдах байгаа ўйл явцыг судлах, шинжлэх үүднээс Монгол ихээхэн сонирхол татдаг. Шилжилтийн ўйл явц ернэж буй орууудын дотроос арчилал, здийн засгийн шинэтгэлийг ийм зоримог хэрэгжүүлж буй орон бараг байхгүй. Бур 1991 он гэхэд л Монгол улс Дэлхийн худалдааны байгууллагад элсэх аргедлэв гаргахаа байсан.

Эрх зүйн шинэтгэл ч гэсэн эрт эхлэж чухал хуулиудаа батласан. Ингэснээрээ Монгол улс шинэтгэлийн хувьд хоёр хэршееесэе олон талаар түрүүлдэг. Үүнийг хэмжихиээ хэмжүүр нь шүүх, хуулийн байгууллагын бие даасан, хараат бус байдал, социализмын үзэс үүдэлтэй хяналтын механизмууд нь өөрчлөгджэх чадсан эсэхээр тодорхойлогдоно. Энэ өгүүлэлд монголын эрх зүйн шинэтгэлийн явц хэр хурдацтай байгааг тодорхойлохыг оролдсон юм. Үүнээс гадна энэхүү хууль, эрх зүйн тогтолцоо нь здийн засгийн амьдралд шаардлагатай эрх зүйн баталгаат орчныг бурдүүлж чадаж байгаа эсэхийг мэн судална.

Гарчиг

- I. Монголын эрх зүйн шинэтгэлийн үндэс
 1. Монгол улс дахь шилжилтийн ўйл явц
 2. Эрх зүйн шинэтгэлийн өнөөгийн байдал
- II. Шүүхийн тогтолцоо
 1. Ерөнхий зүйл
 2. Үндсэн хуулийн зарчим
 3. Шүүхийн санхүүжилт
 4. Шүүхийн ерөнхий зөвлөл
 5. Эрх зүйн боловсрол
- III. Шүүх
 1. Шүүхийн тогтолцоо
 2. Үндсэн хуулийн шүүх
 3. Ердийн шүүх
 - a) Улсын дээд шүүх
 - b) Аймгийн шүүхүүд
 - c) Сум, сум дундын болон дүүргийн шүүхүүд
 4. Шүүүн таслах ажиллагааны үе шатууд болон шүүх бүрэлдэхүүн
 5. Тамгын хэлтэс
 6. Шүүхийн шийдвэр
 7. Шийдвэр гүйцэтгэл
- IV. Шүүгчид
 1. Шүүгчийн ёс зүй
 2. Шүүгчийн хараат бус байдал
 3. Шүүгчийн сургалт
 4. Тангарагтаны шүүгч /Иргэдийн төлөөлөгч/ болон шүүхийн туслах
- V. Прокурор

VI. Нотариатч, өмгэелегч

1. Нотариатч
2. Өмгэелегч

VII. Хууль, эрх зүйн шинэтгэлийн өнөөгийн байдалд өвөх үнэлэлт

1. Хуулийн байгууллагуудын дотоод зохион байгуулалт, бүтцийн асуудал
2. Эдийн засгийн тогтвортой хөгжилд эрх зүйн тогтолцоо нөлөөлөх нь

Дүгнэлт

I. МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛИЙН ҮНДЭС

1. Монгол улс дахь шилжилтийн үйл явц

Монгол улс нь 1989 оны өөрчлөлт, шинэчлэл хүртэл Зөвлөлт холбоот улсын нэгэн дагуул улс, эдийн засаг болоод улс төрийн хараат байдал нь зүүн европын орнуудтай харьцуулахад илүү их хүчтэй байсан. Монголын улс төрийн хийгээд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо нь зөвлөлтийн загварт яв цав нийцэж байсан. Улс ардын аж ахуйн гол тулгууруд нь хедее аж ахуй, хедее аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалт болон ашигт малтам алпорлолт зараг байв. 1989 оныг хүртэл ЗХУ-ын хүчтэй нөлөөлөлд байсан нь Хятадтай харьцах харьцаанд нь сергеер нөлөөлсөн. Монгол улсын тадаад худалдааны 93% нь 1988 онд тухайлбал СО-MECON-орнуудтай хийгдэж байжээ.

1989 оны намар өрнөсөн том хэмжээний жагсаал, цугланаанд нь улс төр, эдийн засгийн шинэтгэлийг эхлүүлснээр Монгол улс ардчилсан эрх зүйт төрийг төлөвшүүлэх болон зах зээлийн эдийн засгийн зарчимд тулгуурласан эдийн засгийн тогтолцоо бүрдүүлэх замд орсон. 1990 онд парламентын анхны чөлөөт сонгууль явагдсан бөгөөд шинэтгэлийн үйл явц нь эхэндээ хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд ордог байсан бусад орнуудтай нэгэн адил Монгол улсын эдийн засгийн чадвхид сергеер нөлөөлсөн юм. Үндэсний нийт бүтээгдэхүүн болон үйлдвэрлэл 1991 онд өмнөх онтой харьцуулахад 10-12 хувнаар буурсан ба энэ нь мөнгөний ханшийн уналтыг дагуулсан. Түүнчилэн инфляцийн түвшин 1992 онд 325 хувь болж дээд цэгтээ хүрч, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний хэмжээ их хэмжээгээр буурсан байна. Хятадад "социалист зах зээлийн эдийн засаг"-т шилжсан шиг "шилжилтийн шок"-гүйгээр түргэн шилжилт хийх оролдлого нь зөвхөн хедее аж ахуйн салбарт л хэрэгжсэн юм.

Гэвч хэсэг хугацааны дараагаар монголын эдийн засагт есвэх хандлага ажиглагдаж эхэлсэн. 1995 онд эдийн засгийн есслэл 6 хувьтай гарсан хэдий ч 1997 оны дэлхийн зах зээл дээрхи зэсийн үнийн уналт болон Азийн хямарлын үр дагаварууд нь эргээд эдийн засгийн есслэлийг тогтвортгий болгож эхэлсэн байна. 1996 - 2000 оны хооронд Ардчилсан Холбоо анх удаа парламентад олонхи болж, өөрийн Засгийн газраа байгуулан ажилласан бол харин 1989 он хүртэл улс төрд цорын ганцавар байсан МАХН анх удаагаа серег хүчин болсон юм. 1996 - 1998 онд Ардчилсан нам Монгол улсыг 1997 онд Далхийн Худалдааны Байгууллагад элсүүлэх эзргээр их хэмжээний шинэтгэлийг өрнүүлсэн боловч 1998 - 2000 онд хээл

хахуулийн асуудалд ихээхэн холбогдсон байна. 2000 оны сигуулиар Засгийн газраа бүрдүүлэх эрх авч, олонхи болсон MAXH шинэтгэлийн ўйл хэргийг үргэлжлүүлсэн. Өмч хувьчлалын асуудлаар л гэхэд Монгол улс хамгийн түргэн шуурхай хэрэгжүүлж буй орны тоонд ордог. Түүнчлан эдийн засгийн шинэтгэлийн процесс ихээхэн урагшилсан, ардчилсан өөрчлөлт, шинэчлэлтийн хувьд үлгэр жишээ орон гэж үзж болно. Үүнийг мен сонгуулиас үүдэн засгийн газар нь олон удаа солигдсон баримт ч харуулна.

Гэвч ядуурлыг бууруулах ўйл хэрэгт дорвитой үр дүн гарахгүй л байна. Хоёр өвөл дараалан (2000 - 2002 он) учирсан байгалийн гамшиг болох зуднаар олон малчид малаа алдаж, ядуурал хүрээгээс улам их тэлсээр байгаа нь мэдрэгджэй байна. Үүнийг дагаад жижиг гэмт хэрэг, биеэ үнэлэх явдал ч ихсэж байна. Хедеэ орон нутгийн эрчим хүчиний асуудал муу хэвээр байгаа. Үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн 2002 оны эхний улиралд 45 сая амдоллар байсан нь өмнөх оныхтой харьцууллахад 10,6 хувиар есцен байна. Үйлдвэрлэлийн гол чиглэлүүд нь мен л ашигт малтмал олборлолт, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний боловсруулалт болон эрчим хүчиний салбар юм. Түүхий эд, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн нь монголын голлох экспортын төрөлд ордог. 2002 оны эхний улирлын байдлаар экспортын нийт хэмжээ 70,6 сая амдоллар байхад импортын нийт хэмжээ 114,9 сая амдоллар байна. Үйлчилгээний салбарт есслэг гарч байна гэсэн тооцоо байдаг. Түүнчлэн худалдаа, аялал жуулчлал нь есслэг гарах салбарууд мен гэж үзж болно.

2. Эрх зүйн шинэтгэлийн өнөөгийн байдал

Монгол нь эрх зүйн үүсэл, хөгжлийн хувьд эртний түүхтэй. XIII зуунд Чингис хаан өөрийгөө агуу байлан дагуулагч гэдгээ төдийгүй, ухаалаг терийн удирдагч болохдоо нотолсон. 1229 онд баталсан Их засаг хууль нь монголчуудын анхны боловч нийлээд өргөн хүрэг хамарч чадсан хууль байсан бөгөөд тэрхүү агуу гүрний олон үндэстэн, ястныг зохих хэмжээнд хатуу сахилга баттай захирагчад нийцсэн эрх зүйн тогтолцоог бурдруулж чадсан байdag. 1921 оноос буюу зөвлөлтийн загварын эрх зүйн систем Монголд бий болсон үеэс 1940 он хүртэлхи үеийг хувьсгал болоод ардчиллын эрх зүй эргэлт буцалтуйг тогтоносон. 1989 оны шинэтгэлээс өмнөх үеийн шүүх, хуулийн байгууллагын тогтолцоо нь 1978 оны Шүүхийн тухай хууль болон Дээд шүүхийг хуулийн дээд байгууллага гэж нарлсан боловч хараат бус байдлыг нь бүрэн хангваагүй 1960 оны Үндсэн хууль зэрэгт тулгуурласан байдаг. Өөрчлөлт, шинэчлэлтийн эх 1991 онд гэхэд эдийн засгийн шинэ тогтолцоог бий болгохын тулд Улсын Их хурлаас Төв болон арилжааны банкны шинэ хууль, Дампуурлын тухай анхны хууль, Нехерлэл, компанийн тухай хууль, Хөдөлмерийн болон Өмч хувьчлалын зэрэг хуулиудыг баталсан байна. Мен УИХ-аас шинэ Үндсэн хуулийг боловсруулж энэ нь 1992 оны 2-р сарын 12-нд хучин төгөлдөр болсон. Үүзэрээ Монгол улоо өөрийгөө ардчилсан эрх зүйт улс болохдоо тунхагласан юм. 1992 оноос хойш Чөлөөт өрсөлдөөний тухай /1993/, Оюуны өмчийн тухай /1993/, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай /1993/, Патентийн тухай /1993/, Үнэт цасны тухай /1994/, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /1994/, Иргэний хууль /1995/, Нехерлэл, компанийн тухай хууль /1995/, Дампуурлын тухай хууль /1997/ болон татварын тухай олон хууль батлагдсан.

2002 оны 1-р сард Улсын Их хурлаас баталсан иргэн, эрүүгийн багц хуулиуд ихээхэн ач холбогдолтой. 2002 оны 9-р сарын 1-нд Иргэний, ИХШХШТ, Эрүүгийн, ЭБШ болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай шинэ хуулиуд үйлчилж эхлилээ. Эдгээр хуулийн ихээхэн хэсэг нь шинэтгэлийн эхний шатанд хэдийнээс хуульчлагдсан байсан ч нэг цаг хугацаанд боловсруулагдаагүй байсан тул уялдаа холбоо нь муу байсан бөгөөд энэхүү дутагдлыг дээрх багц хуулиар арилгасан. Мен шинэтгэлийн эхэнд баталсан зарим хуулиуд нь эдийн засгийн амьдралд нийцэхээ больсон. Тэр үеийн хууль тогтоомжид төвлөрсөн төвлөвлөгөөт здийн засгийн үеийн хяналтын механизмууд зарим хэсэгт нь хадгалагдаж байв. Шинэ зохицуулалтууд нь харин энэ 10 жилийн хугацаанд олж авсан туршилгададаа тулгуурласан бөгөөд энэхүү шинэтгэл нь Монголын эрх зүйн тогтолцоонд хүчтэй нөлөөлөх нь дамжигүйт. Үнд шүүхийн тогтолцоо ч мөн хамаарна. Эдгээр хуулийг нарийвчлан тайлбарлаад хэрэгжүүлж эхэлсэн цагт Монгол улс өөрийнхөө шинэтгэлийн зорилгод нэг томоохон алхам ойртсон байх болно.

II. ШҮҮХИЙН ТОГТОЛЦОО

1. Ерөнхий зүйл

Бүр 1926, 1927 онуудад монголд зөвлөлтийн загвараар шүүх байгуулагдсан байна. 1927 оны 1-р сарын 1-нд Ардын дээд шүүх ажлаа эхэлж, 1930 онд Ерөнхий прокурорын газар байгуулагдсанар Монгол улсад шүүхийн систем бүрэлдэн бий болжээ. Шүүхийн өнөөгийн тогтолцоо нь Үндсэн хуулийн цэцээс гадна гурван шатны шүүхтэй: (1) Улсын дээд шүүх, (2) аймаг, нийслэлийн шүүх, (3) сум, сум дундын болон дүүргийн шүүхүүд. Шүүхийн тогтолцооны бусад бүрэлдэхүүн хэсгүүд болох прокурор, өмгөөлөх, нотариат бий. Монголын шүүхийн тогтолцоонд нилзэд үүрэгтэй оролцдог бусад байгууллагууд бол Хууль зүйн /одоо дотоод хэргийн асуудлаа давхар эрхэлж байгаа/ явам Шүүхийн ерөнхий зөвлөл юм.

1992 оны Үндсэн хуулиас гадна Үндсэн хуулийн цэцийн тухай хууль /1992/, Шүүхийн тухай хууль /1993/, Прокурорын тухай хууль /1993/, Өмгөөллийн тухай хууль /1994/, Нотариатын тухай хууль /1985/, 2002 оны Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай болон ИХШХШТ, ЭБШ зэрэг хуулиуд нь шүүхийн тогтолцоо болон хуулийн байгууллагуудын хувьд эрх зүйн чухал ач холбогдолтой юм. Одоогоор монголд 349 шүүгч байна. Шинэ хуулиуд хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээр 50 шүүгч шинээр томилохоор төвлөлж байгаа. Үүнээс гадна 376 прокурор, ойролцоогор 1000 өмгөөлөгч, 300 орчим нотариатч байна. 2001 онд шүүхээр 15653 шүүтдэгчтэй нийт 11080 эрүүгийн хэрэг хэлэлцэж, 9880 тогтоолоор нийт 13581 шүүгдэгчийг ялласан байна. Шүүхийн таслан шийдвэрлэх тогтоонын 76,7% нь хорих ял, 22,3% нь мэнген торгууль ногдуулсан бөгөөд 3,8% нь засан хүмүүжүүлэх ажил хийгэхээр шийдвэрлэсэн байна. Өмнөх онтой харьцуулахад эрүүгийн хэргийн тоо 3,8 хувиар, таслан шийдвэрлэлт 4,6 хувиар буурсан байна. 2001 онд иргэний хэрэг 33522 орж ирснээс 23252-ыг шийдвэрлэж 7143 хэргийг хэргсахгүй болгосон, эсвэл буцаасан байна. 2000 онтой харьцуулахад иргэний хэргийн тоо 7,1 хувиар есвен дунтэй байна.

3. Үндсэн хуулийн зарчим

1992 оны 1-р сарын 13-нд батлагдаж 1992 оны 2-р сарын 12-нд хүчин төгөлдөр болсон Монгол Улсын Үндсэн хууль нь шүүхийн тогтолцооны хувьд ач холбогдол бүхий олон тооны зохицуулалтыг агуулсан байна. Үндсэн хуулийн 2-р булагт хүний үндсэн эрхүүдийг бичсан байх бөгөөд үүнд хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зэрэг зарчмыг тусгасан байдаг. Монгол улсын иргэн өөрийнхөө эрхийг зөрчигдсөн гэм үзвэл шүүхэд хандах эрхтэй. Үндсэн хуулийн 3-р булагт 4 дахь хэсэгт шүүх эрх мэдлийг гапцхүү, шүүх хэрэгжүүлэх, шүүгчийн хараат бус байдал болон шүүн таслах ажиллагааг нээлттэй явуулж зэрэг үндсэн зарчмуудыг баталгаажуулсан. Энэхүү хэсэгт мөн ШЕЗ болон Прокурорын байгууллагын үндсийг зохицуулсан байдаг. Сонирхолтой нь Үндсэн хуулийн шүүхийн талаар Үндсэн хуулийн 5-р булагт зохицуулсан байдаг. Эзүүгийн хэргийн хувьд яллагдагчийг өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэгт өвөхийг шаардахийг хориглодог бөгөөд гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож болохгүй.

4. Шүүхүүдийн санхүүжилт

Улсын Дээд Шүүх /УДШ/ нь нийт шүүхүүдийн төсөв, аж ахуйн асуудлыг хариуцдаг. Шүүхийн төсвийг шинэчлэн тогтоохын тулд Шүүхийн Ерөнхий Зөвлөлт /ШЕЗ/ шүүх тус бүрээс шинаа төсвийн саналыг цуглуулан УДШ-д уламжилдаг. Хууль Зүйн Яамны /ХЗЯ/ хувьд шүүхийн төсвийн асуудалд шууд үзүүлэх нелее, оролцоо байдаггүй. Энэ нь шүүх засаглалын бие даасан, хараат бус байдалд гүйцэтгэх засаглалын нелееөн оруулахгүй байх зарчмытай нийцэж байдаг билээ. Гэсэн хэдий ч авилгал Монгол улсад мэдэгдэхүйцүү үүргээг байгаа төдийгүй, харамсалтай нь тэр дундаа авилгальн тохиолдлууд хууль зүйн салбарыг илрэсээр байгаа юм. Үүний нэг жишиээ бол Монгол Улсын Хууль зүйн өмнөх сайд 1999 онд хээл хахуулийн хэрэгзэр шийтгэгдэж байсан ядал юм.

5. Шүүхийн Ерөнхий Зөвлөлт

Хууль зүйн салбарын бие давасан, хараат бус байдлыг бэхжүүлэх үүднээс 1992 оны Үндсэн хуулиар Шүүхийн Ерөнхий Зөвлөлт /ШЕЗ/-ийг байгуулжээ. Уг зөвлөл нь 12 гишүүдээс бурддэг бөгөөд үүнд; УДШ-ийн дарга, /ерөнхий шүүгч/, Улсын ерөнхий прокурор, Хууль зүйн сайд, Ерөнхийлөгч болон УИХ-аас томилогдсон Ерөнхий нарийн бичийн дарга, УДШ-ээс тодорхой хэргүүдэд сонгогдсон 6 шүүгч, эдгээрийн 2 нь дээд шүүхээс, 2 нь аймаг болон нийслэлийн шүүхүүдээс, 2 нь дүүргийн болон сум, сум дундын шүүхүүдээс ордог. Одоогийн байдааар ШЕЗ-ийн даргын албыг Хууль зүйн сайд гүйцэтгэдэг. Гэхдээ энэхүү удирдлагын асуудлыг өөрчилхөөр яригдаж байна. Шүүхийн байгууллагын тухай хуулийн 33-р зүйлийн 3-ийг ШЕЗ-ийн даргын албыг УДШ-ийн дарга гүйцэтгэдэг байхаар удахгүй өөрчилж магадгүй байна. ШЕЗ-ийн гишүүний ажиллах хугацаа нь 6 жил бөгөөд энэ хугацаа албан тушаалаараа Ерөнхий зөвлөлт орсон гишүүдэд хамаарахгүй. ШЕЗ-ийн хуралдаан гишүүдийн гуравны хобёр ирснээр асуудал шийдвэрлэх, тогтоол гаргах хүчин төгөлдөр болно. ШЕЗ нь шийдвэр, тогтоолоо гишүүдийн олонхийн саналааар баталдаг.

ШЕЗ нь бүх шатны шүүхийн шуугчийн орон тоо, цалингийн хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, шуугчийг томилуулах, салгэн ажиллуулах, чөлөөлүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх, шуугчийг сахилгын болон мэргэшшийн хороо байгуулах, мөн түүнчлэн шүүгчдийг шилж сонгох, шалгаруулах зэрэг бүрэн эрхтэй. ШЕЗ-еес УДШ болон аймаг, нийслэлийн шүүхүүдийн дэргэд байгуулагдсан Шүүхийн сахилгын хороо нь шуугчийн сахилга, хариуцлагын бүхий л асуудлыг хариуцсан ажиллана. Сахилгын хорооны шийдвэрийг үл зөвшөөрөн шүүгч УДШ-д гомдол гаргах эрхтэй. Сахилгын хорооны шийдвэртэй холбоотойгоор шүүгчийг албан тушаалаас нь огцруулах тохиолдолд ШЕЗ-еес сахилгын хорооны шийдвэрийг дахин хянан үзэх бөгөөд огцруулах саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ. Шүүхийн мэргэшшийн хороо нь 9 гишүүнээс бүрдэх бөгөөд ШЕЗ-еес байгууллагдана. Шүүгчдийн мэргэшшийн түвшин, ажил хэргийн чадварыг үнэлж, дүгнэдэг энэхүү хорооны даргыг гишүүдийнх нь дотроос ШЕЗ-еес томилдог.

6. Хуульчдын боловсрол

1993 оны их, дээд сургуулиудын шинэчлэлтээс өмнө хувь зүйн чиглэлээр зөвхөн Улаанбаатар дахь МУИС-ийн Хууль зүйн дээд сургуульд суралцах болдог байв. Энэ хооронд 40 гаруй сургуулиуд бий болсон боловч тэдгэрээс гарч буй боловсон хүчин чанар түйлн хангалтгүй байгаа юм. Илүү сайн хуулийн боловсон хүчин бэлтгэн гаргахын тулд УИХ-аас батлагдсан Эрх зүйн шинэчлэлийн хөтөлбөрт Хуульчдын боловсролын асуудлаар шинэ зохицуулалт оруулах шаардлагатай байгаа юм. Энэ нь бүх хуулийн сургуулиудын тэгсэлтийн улсын шалгалтыг нэгдсэн журмаар авах, хоёр дахь улсын шалгалтыг дадлагын ажил хийлгэсний үндсэн дээр авах тухай зэрэг асуудал юм. Хуулийн сургуулиудын улсын шалгалтын талаархи дүрэм, журамтай холбоотой нэлээд хэдэн тэслүүд боловсрууллагдаад байгаа юм.

III. ШҮҮХ

1. Шүүхийн тоогтолцоо

Үндсэн хуулийн шүүхийн зэрэгцээ ердийн шүүхүүд үйл ажиллагаагаа явуулдаг. Үндсэн хуулиар мөн захиргааны шүүх байгуулж болохыг хуульчилсан байdag боловч төсвийн хүндэрэлээс болоод энэ заалт амьдралд биеллээ хараахан олоогүй л байна. Хэрвээ уг шүүх байгуулгадах аваас ердийн шүүхүүдэд одоо шийдвэргэж буй захиргааны, татварын, хөдөлмерийн маргаантай холбоотой бүхий л шүүн таслах ажиллагаа захиргааны шүүхээр шийдвэргэх боломжтой юм. Герман улсаас ялгаатай нь Монгол улсын шүүхүүдэд аж ахуйн бүртгэлийг хийдэггүй. Аж ахуйн нэгжүүд татварын газарт бүртгэгддэг бол үл хедлех хөрөнгийн бүртгэлийг Үл хедлех эд хөрөнгийн бүртгэлийн газар зэрэг биеэ даасан байгууллагууд гүйцэтгэдэг байна.

2. Үндсэн хуулийн шүүх

Монгол улсын Үндсэн хуулийн шүүх нь /Цэц/ 9 гишүүнээс бүрдэх бөгөөд тэдний ажиллах хугацаа нь 6 жил байдаг. Цэцийн есөн гишүүнний гурвыг УИХ, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг УДШ-ийн санал болгосноор УИХ томилдог. Цэцийн гишүүнээр хууль зүй, улс төрийн өндөр мэргэшилтэй, эрүүтийн ял шийтгэлгүй, дечин нас хурсэн Монгол Улсын иргэн ажиллана. Цэцийн дарга нь гишүүдийн дундаас сонгогдог бөгөөд түүний бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байдаг. Бүрэн эрхийн хугацааг дахин нэг удаа улируулан сунгаж болдог.

Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Үндсэн хуулийн Шүүх буюу Цэцийн эрх зүйн асуудлыг Үндсэн хуулийн 3-р булгийн 4 дэх хэсэгт тусгасан байна. "Бусад" шүүхийн тухай зохицуулалтыг мөн 5-р булэгт оруулж улмаар Монгол Улсын Шүүхийн дээд байгууллага нь Дээд Шүүх байхаар хуульчилсан байна. Эндээс хууль тогтоогч нь Цэцийг УДШ-тэй адил түвшинд үнэлээгүй гэж үзэж болохоор байгаа бөгөөд энэ утгаараа Цэц нь УДШ-ээс статусын хувьд илүү байх боломжгүй байгаа нь харагдаж байна. Гэсэн хэдий ч Цэц нь шүүхийн систем дотор чухал чиг үүргүүдийг гүйцэтгэж байгаа юм. Ердийн шүүхийн хувьд Үндсэн хуулийг тайлбарлах чиг үүрэг байдаггүй. Харин ердийн шүүхээс хэрэг, маргаан шийдвэрлэх явцад хэрэглэх хууль нь Үндсэн хууль зөрчсөн байна гэж үзвэл шүүн таслах ажиллагааг зогсоож, энэ талаар УДШ-д мэдэгдэнэ. УДШ нь асуудлыг авч хэлэлциээд энэ талаар Цэцэд уламжилдаг.

УИХ, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор зэрэг нь Цэцэд Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг хянан шийдвэрлүүлэх хүснэгт гаргах эрхтэй байхаас гадна Цэц нь Үндсэн хууль зөрчсөн тухай асуудлаар иргэдээс ирүүлжэн ергедел, мэдээллийг үндэслэн хянан шийдвэрлэх ажиллагааг мөн явуулдаг.

3. Ердийн шуухууд

а/ Улсын Дээд Шүүх /УДШ/

Монгол улсын шүүх эрх мэдлийн дээд байгууллага болох УДШ нь дарга /Ерөнхий шүүгч/ болон 16 шүүгчдээс бүрддэг. УДШ-ийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Монгол улсын Ерөнхийлөгч томилдог бөгөөд улируулан томилж болдог. УДШ нь иргэдийн болон эрүүтийн хэргийн танхимтай байх бөгөөд танхимиудын тэргүүн шуугч нарыг УДШ-ийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Монгол улсын Ерөнхийлөгч томилно. Шүүгч нарыг танхимиудад хуваарилах асуудлыг Ерөнхий шүүгчийн санал болгосноор УДШ өөрөө шийдвэрлэж баталдаг. Танхим тус бур нь нэг тэргүүн шүүгч, 7 шүүгчээс бүрдэнэ. Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, гучин таван нас хурсэн Монгол улсын иргэнийг УДШ-ийн шүүгчээр томилж болдог.

УДШ-ийн үйл ажиллагааны хамгийн гол чиг үүрэг бол хэрэг маргааныг хяналтын шатны журмаар шийдвэрлэж, шийдвэр, тогтоол гаргах явдал байдаг. УДШ-ийн шийдвэр, тогтоол нь эцсийн шийдвэр байдаг бөгөөд түүнийг бүх шүүх заавал биелүүлэх ёстой байдаг. Цаазаар авах ялны тогтоолтой эрүүтийн хэргийн хувьд хяналтын шатны журмаар УДШ-ээр

заавал хянан шийдвэрлэгдэх ёстой байдаг. Герман улсын хувьд холбооны болон муж улсуудын Хууль зүйн яамдууд хэсэгчлэн шийдвэрлэдэг захиргааны болон хяналтын шинжтэй олон тооны хэрэг, маргаануудыг Монгол улсын хувьд дээд шүүх нь бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэж байдаг. Түүнчлэн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх нэгдсан бодлого боловсруулж, нийт шүүхийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэг ч мен УДШ-ийн бүрэн эрхэд хамаардаг. Гэхдээ энэ нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хамаардаггүй. Үүнээс гадна УДШ-ээс хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргадаг бөгөөд энэхүү тайлбар нь хуулийн адил хүчин төгөлдөр байж, бүх нийтээр дагаж мөрддэг. Эдгээр зохицуулалт нь хуучны ЗХУ-ын зохицуулалттай ижил төсөөтэй шинжтэй бөгөөд мен зүүн бүсийн орнууд болон Хятадад адилхан байдаг.

Хуулийн тайлбар гаргахтай холбоотой УДШ-ийн дээрхи эрх мэдэл нь түүнд ямарваа зохицуулалт нь тодорхойгүй бүхий л маргаантай хэргүүдийг авч хянан шийдвэрлэх боломжийг олгож байгаа бөгөөд дээд шүүх уг эрх мэдлээ маш идэвхтэй, шуурхай хэрэгжүүлдэг. Засаглал хуваарилах онолын үүднээс дээд шүүхийн энэхүү эрх мэдэл нь тийм ч оновчтой бус бөгөөд шуумжлэлд өртөж байдаг юм. Хэдийгээр Герман улсад хууль тайлбарлах нь дээд шүүхийн эрх мэдэл байдаг хэдий ч энэ нь хуулийн адил хүчин чадалтайд тооцогдоггүй юм. УДШ-ийн энэхүү эрх мэдлэлтэй холбоотой хамгийн анхаарал татсан асуудал нь дээд шүүх энэхүү эрх мэдлийн хүрээнд доод шатны шүүхийн ямарч хэргийг /маргаантай/ өөрөө татан авч хянан шийдвэрлэх боломжтойд оршиж байна.

б/ Аймаг, нийслэлийн шүүхүүд

Аймаг бүрт аймгийн шүүхүүд байна. Засаг захиргааны хувьд нэг аймагтай ижил түвшинд тооцогдох нийслэл хот Улаанбаатарт байх шүүх нь нийслэлийн шүүх нэртэй. Аймаг, нийслэлийн шүүхийн үйл ажиллагааны гол онцлог бол хэрэг, маргааныг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэдэгт оршино. Мен түүнчлэн өөрийн харьяаны сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн захиргааны шинж чанартай асуудлыг зохицуулах, тухайлбал тус шүүхүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ хамаардаггүй. Аймаг, нийслэлийн шүүхийн шуугчээр хууль зүйн дээд боловсролтой, турваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, хорин таван нас хүрсэн, Монгол Улсын иргэн томилогдон ажилладаг. Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийг ШЕЗ-ийн санал болгосноор шүүгчдийн дотроос Монгол улсын Ерөнхийлөгч б жилийн хугацаагаар томилох бөгөөд ерөнхий шүүгчийг улируулан томилж болдог.

в/ Сум, сум дундын болон дүүргийн шүүхүүд

Аймгуудад сум дундын шүүхүүд байх бөгөөд энэхүү сум, сум дундын шүүх нь нэг суманд оршин суух хүн амын тоо багатай холбоотойгоор хэд хэдэн сумыг хариуцсан нэг сум дундын шүүх аль нэг суманд байрлан үйл ажиллагаагаа явуулж байдаг. Энэ утгаараа тус шүүгчийг сум дундын шүүх гэж нарийддэг. Нийслэл Улаанбаатар хотын хувьд эдгээртэй ижил шатны шүүх нь дүүргүүдэд байрлах дүүргийн шүүхүүд юм. Сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүд нь анхан шатны журмаар бүхий л хэрэг, маргааныг хүлээн авч, хянан шийдвэрлэдэг.

4. Шүүн таслах ажиллааваны үе шатууд болон шүүх бүрэлдэхүүн

Монгол улсад иргэний болон эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагаа нь 3 үе шаттай байдаг. Иргэний хэргийн хувьд сум буюу сум дундын, дүүргийн шүүхүүд нь анхан шатны журмаар хянан шийдвэрлэдэг.

Анхан шатны шүүхийн шийдвэрийн эсрэг Аймаг болон Нийслэлийн шүүхэд давж заалдах гомдол гаргах эсвэл Германы эрх зүйд байдагтай адил энэ шатыг алгасан УДШ-д хяналтын журмаар шийдүүлэхээр гомдол гаргаж болдог. Иргэний хэргийг давж заалдах шатны журмаар шийдвэрлэхэд мэргэжлийн 3 шүүгчээс бүрдсэн бүрэлдэхүүн оролцдог. Давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянан хэлэлцэх ёстой. Харин нотлох баримтыг гаргах ажиллагааг анхан шатны шүүхэд нотлох баримт гаргаж егсөн тухай протоколыг уншиж танилцуулсанаар орлуулж болдог. Нотлох баримтыг үзлэх ажиллагаа нь харин шинээр явагдана. Анхан шатны шүүх хуралдаан дээр гаргаж егеец нотлох баримтыг давж заалдах шатны журмаар хэргийг хянан хэлэлцэхэд харгалзан үздэггүй. Иргэний хэргийг давж заалдах шатны журмаар шийдвэрлэн гаргасан магадлалын эсрэг дээд шүүхэд хяналтын журмаар гомдол гаргаж болно.

Хяналтын журмаар иргэний хэргийг Улсын дээд шүүхийн иргэний танхимын тэргүүн шүүгч болон бусад 7 шүүгчээс бүрдсэн бүрэлдэхүүн хянан шийдвэрлэдэг. Ийм тохиолдолд хэргийг жинхэнэ хяналтын журмаар хянан хэлэлцэх бөгөөд зөвхөн материалыг болон процессын хуулийг зөрчсөн гэсэн үндэслэлээр л хяналтын шатанд гомдол гаргаж болдог бол Германы эрх зүйд хууль зөрчсөн гэдгээс бусад тодорхой үндэслэлээр хяналтын шатанд гомдол гаргаж болдог. Хяналтын журмаар хэргийг Иргэний танхимын олонхийн оролцоогоор бусу 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр шийдвэрлэдэг. Иргэний тэнхимзас гаргасан шийдвэрийн эсрэг хяналтын шатанд хандсан этгээд хууль зөрчсөн гэдгээ үндэслэлээр УДШ-д хандаж гомдол гаргаж болдог. Энэхүү гомдолыг УДШ-ийн Ерөнхий шүүгч үндэслэлтэй гэж үзвэл тухайн хэрэг маргааныг УДШ-ийн хуралдаанвар хянан хэлэлцүүлдэг. УДШ-ийн хуралдааныд УДШ-ийн Ерөнхий шүүгч болон бусад 16 шүүгч нар оролцдог. УДШ-ийн хуралдаанаас гарсан тогтоол нь эсийн шийдвэр байдаг.

Зарчмын хувьд хэрэг маргаан шийдвэрлэх шүүхийн шат болон шүүх бүрэлдэхүүн нь сайн зохион байгуулалттай бөгөөд эрх зүйт териин шаардлагыг бүрэн хангаж байна. Харин УДШ хэргийг хяналтын журмаар хэлэлцэн шийдвэрлэсэнд дараа ч түүний эсрэг дахин гомдол гаргах боломжтой бөгөөд Ерөнхий шүүгч уг гомдолыг хулзэн авч хэлэлцүүлэх талаар бие даан шийдвэр гаргадаг нь бага зэрэг содон зүйл юм. Үүнээс үүдэн Монгол улсын Ерөнхий шүүгчийг давхар хяналтын механизмуу гэсэн таамаг ч гарч болох юм. Үүний зэрэгцээ хэргийг хамгийн боломжит шудрага байдлаар шийдвэрлэх гэсэн санаа ч байж болох юм. Ямартай ч энэхүү нэмэгдэл шат нь зававал байх ёстой зүйл биш бөгөөд хэрэг маргааныг шийдвэрлэх хугацааг түргэтгэх үүднээс үүнийг бүрмэсэн хасах нь зүйтэй.

5. Тамгын газар

1998 оныг хүртэл Монгол улсын шүүхүүдэд тамгын газар, хэлтэс гэж байсангүй. Шүүгчид баримт бичиг, шүүхийн шийдвэрийг хургах зэрэг хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон бүхий л ажлыг хийж гүйцэтгэдэг байв. 1998 онд ажлын үр дүнг дорвийтой дээшлүүлэх зорилгоор

Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн шүүхэд тамгын хэлтэсийг загвар байдлаар байгуулах ажил эхлэсэн. Үүгээр шүүгчийн ажлыг хөнгөвчилж шүүгчид нь өөрсдийн үндсэн ажил болох шүүн таслах ажиллагаандaa илүү цаг зарцуулах боломжыг бурдүүлэхийг зорьсон. Энэ зорилтод хүрсэн бөгөөд энэхүү загварыг Улаанбаатар хотын бусад бүх шүүхүүдэд хэрэгжүүлсэн. Үүний зэрэгцээ хедеэ орон нутагт тухайлбал Дундговь аймагт загвар шүүхийн төслийг хэрэгжүүлж эхлэсэн.

6. Шүүхийн шийдвэр

Одоогоор хараахан нийтлэгдээгүй байгаа судалгааны хурээнд авч үзсэн 150 иргэний харгийн шийдвэрийг судалж үзсэн. Энэхүү судалгааны зорилго нь шүүхийн шийдвэрийн чанарыг тогтоох, үүгээр дамжин шүүгчдийн мэргжил боловсролын түвшинг тогтооход оршиж байсан. Судлагдсан шийдвэрүүд бараг бүгдээрээ их бага хэмжээгээр алдаатай байсан бөгөөд үүнд дараах алдаанууд зонхиц байв: Судлагдсан шийдвэрүүдэд хэргийг зүйлчлэх аргачлалыг огт хэрэглээгүй, зүйлчлэх аргачлалын оронд шийдвэрийн текстд болсон явдлын талаар болон эрх зүйн асуудлыг эмх замбараагүй хольж хутган оруулсан байлаа. Шүүчдэд эрх зүйн аргачлалын онолын чиглэлийн сургалт дутагдаж байгаа нь эндээс тодорхой харагдаж байна. Шийдвэрүүдэд шаардах эрхийн үндэслэлийг зөв олоогүй бөгөөд зарим талаар шаардах эрхийн үндэслэлийг огт дурьдаагүй байлаа. Нилээд хэдэн тохиолдолд шаардах эрхийн үндэслэлийг зөв олсон хэдий ч гарах эрх зүйн үр дагаварыг нь бууру тогтоосон байв. Зарим тохиолдолд шийдвэрийн тогтоох хэсэгт заасан эрх зүйн үр дагаварын зарим хэсгийг шийдвэрийн шаардах эрхийн үндэслэл нь хангаж өгч байлаа. Анзаарамгүй өнгөрч болохгүй нэг дутагдал нь шүүхийн шийдвэрт мэтгэлцах болон шүүх хуралдаан явуулах зарчмыг огт харгалзаагүй явдал байсан.

Зарим тохиолдолд шууд болон шууд бусаар эрх зүйн ямар нэгэн зөвлөгөө аваагүй нэхэмжлэлийг зөвлөх хариуцагчыг шийдвэрээс олж харж болох бөгөөд өөрөөр хэлбэл талуудын талаарх мэдээлэл тодорхой бус, зөвлөх тухайн хэргэг маргааны оролцогч бус этгээдийн зэрэг шийдвэр гарсан тохиолдолд ч тааралдаж байсан. Нилээд олон шийдвэрт нэхэмжлэгчийн хүссэн нэхэмжлэлийг хэмжээнээс нь хэтрүүлэн хангасан, хэрэгсэхгүй болгох зүйлийг хэвээр үлдээсэн зөвлөх нэхэмжилсэн зүйлийн зөвхөн зарим хэсгийг тогтоох хэсэгт дурьдсан, зөвлөх огт нэхэмжлээгүй зүйлийг тогтоох хэсэгт тусгасан байлаа. Шүүхээс нотлох баримтыг бурдүүлэх, нотлох баримтыг унзлэх ажиллагаанд ч мөн ялгаагүй алдаа дутагдал гарсан байна. Дийлэнх тохиолдол нь маргаангүй байгаа хэсэгт нотлох баримтыг бурдүүлэх ажиллагаа явуулсан зөвлөх талууд ямар нэгэн нотлох баримтыг санал болгоогүй байхад хүртэл энэ ажиллагааг явуулсан байлаа. Нилээд хэдэн тохиолдолд нотлох баримтын талаарх асуудал тодорхой бус байсан. Нотлох баримтыг үнэлсэн талаар шүүхийн шийдвэрт огт дурьдаагүй өнгөрсөн тохиолдол ч байна.

Судлагдсан хэргэг маргааны дийлэнх хэсэг нь хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөнөөр шийдэгдсэн байсаныг олж тогтоосон. Судалгаанаас үзүүлэд үүнд З терлийн шалтгаан байна: **нэгдүгээр** нийтийг хамарсан төлбөрийн чадваргүй байдал, **хоёрдугаарт** тэмдэгтийн хураамж нь хэтэрхий бага учир шүүхэд хэргэг маргаан үүсгэх нь хүнд айдас

терүүлдэггүй, түрэлжилж шүүгч нарын хандлага ширүүн дориун байдаагаас зарим тохиолдолд хариуцагч талд айдас төрүүлдэг.

7. Шийдвэр гүйцэтгэл

Иргэний хэргийн болон эрүүгийн хэргийн шийдвэр гүйцэтгэлийн асуудлыг 2002 оны 9-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар зохицуулдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэг болон хориг байгууллагын ажилтанууд аль аль нь ШШБГ-т харьялагддаг. Иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд захиргааны зарчмаа талуудын зарчмыд шилжсэн томоохон веерчлэлт гарсан. Үүнтэй уядлан шүүхийн шийдвэр гүйцэтгэчийн ажил үүрэг ч мөн ялгаагүй веерчлэгдсэн. Эдийн засгийн сонирхолыг төрүүлсэнээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаа амжилттай явагдана хэмзэн төсөвлийг байгаа билээ. Харин энэхүү илд нь хоёр талдаа иртэй бөгөөд хувийн хичээсэн, орлогод бодсон шийдвэр гүйцэтгэг төлбөрийн чадваргүй төлбөр төлөгчийн эсрэг менгэ олох гэсэн зохицгүй арга хэмжээ явуулах суд талыг бий болгож болох юм.

IV. ШҮҮГЧ

1. Шүүгчийн ёс зүй

ШЕЗ 1997 оны 2-р сарын 11-нд Шүүгчийн ёс зүйн тухай журам батлан гаргасан. Энэ журамд шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад болон зарим талаар хувийн амьдралдаа дагаж мөрдөх зохицуулалтыг тусгаж өгсөн. Энэ журамд шүүгч биеz эхрээн зөв авч явах тухай нийтлэг зохицуулалт буюу жишээлбэл зан суртахуун болон гэр булийн харилцааг анхааран авч үзүүлэхэд зорилтуулж агуулсан байдал. Үүний зэрэгцээ шүүгчид албан үүргээ хэрэгжүүлэхдээ улс төрийн аливаа нэлээнд автажигүй байх болон веерийн улс төрийн үзэл бодлыг олон нийтийн дунд хэтэрхий илтэд илэрхийлэхгүй байх зэрэгжийг журамлан зааж өгсөн байдал. Мөн түүнчлан шүүгч нь веерийн здийн засгийн хараат бус байдлаа хадгалж байх ёстой бөгөөд ямарваа нэгэн санхүүгийн ашиг хонжoo хайсан үйл ажиллагаанд оролцож хориглодог.

2. Шүүгчийн хараат бус байдал

Хууль хяналтын тогтолцооны шинэштэлд гарч буй дэвшлийг хэмжих нэгэн чухал хэмжүүр нь шүүгчийн хараат бус байдал юм. Монгол улсад шүүгчийн хараат бус байдлыг үндсэнд нь хангаж буй нь талархууштай явдал юм. Шүүгчийн хараат бус байдлыг Үндсэн хуулиар хуульчилж өгсөн. Шүүгчийн хараат бус байх зарчмыг шүүгчийн ёс зүйн дүрэмд онцгойлон тусгаж өгсөн нь онцгой ач холбогдолтой бөгөөд шүүхийн боловсон хүчин, санхүүжилт, сургалтын асуудлыг шүүхийн өрөнхий зөвлөл шийдвэрлэдэг болсон явдал нь нийт шүүгчид болон шүүхийн тогтолцооны хараат бус байдлыг хангахад үзэмж хувь нэмэр оруулсан гэж хэлж болно.

Ижил төстэй үйл явц өрнөж буй БНХАУ-тай (хараат бус шүүх гэж байхаас хараат бус шүүгч гэж байхгүй) харьцуулбал Монгол Улс Шүүхийн болон Шүүгчийн хараат бус байдлыг хангах асуудлаар өндөр хөгжилтэй өрнөдийн орнуудын жишигт нийцхүйц хэмжээнд очижээ.

3. Шүүгчийн сургалт

Шүүгчдийн зарим нь бүр огт хууль зүйн мэргжил, боловсрол эзэмшээгүй байх жишигтэй. Их дээд сургуулиудын хууль зүйн боловсрол эзэмшилж байдал саяхан болтол тун муу байсан. Харин өнеегийн байдлаар хийгдэж байгаа "хуульчдын сонгон шалгаруулах тогтолцоо"-ны шинэчлэл нь чанарын үсрэлт гаргах болно. Гэхдээ энэ салбарт гарах чанарын давшил нь шүүхийн шатанд мэдрэгдэх хүртэл нилээд хэдэн жил өнгөрөх болов уу.

Гарч байгаа гол дутагдалын нэг нь шүүгчид хэрэг маргааны шийдвэрлэхдээ тодорхой аргачлалыг ашигладагтуйд оршино. Монгол улсад эрх зүйн логик, хэргийн зүйлчлэх аргачлалыг өнеөг хүртэл бараг хэрэглэж хэвшээгүй бөгөөд цөөн хэдэн шүүгчид л хууль зүйн онолын аргачлалыг эзэмшсэн байдаг. Иймд олон шүүгч өөрийн гэсэн аргачлалын дагуу шийдэх гэж байгаа хэргийн эрх зүйн шийдвэрд хүрэхийг оролддог. Энэ нь цаашид улам сайжрах нь дамжигүү. 2002 оны 9-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон Иргэний Хэрэг Шүүхэд Хянан Шийдвэрлэх тухай хуульд шүүхийн шийдвэр нь дараах 4 хэсгээс бурданэ тэж тодорхой зааж өгсөн. Үүнд: Удиртгал хэсэг, Тодорхойлох хэсэг, Үндэслэх хэсэг, Тогтох хэсэг. Энэ шинэ зохицуулалт өөрөө хэрэгжих эхлэхгүй нь ойлгомжтой бөгөөд шүүхийн шийдвэр бичих аргачлалтай холбоотой энххүү салбарт давтан сургалтыг явуулах шаардлага илүү ихээр тавигдаж байна. Тэр болтол энххүү дутагдаж байгаа аргачлалын хэрээр эрх зүйт териийн баталгаа хумигдсан хэвээр байх болно. Хэргийг шийдвэрлэх нэгдсэн аргачлал байдаггүй учир тодорхой хэрэг маргаан яаж шийдэгдэхийг урьдчилан тооцох аргагүй юм.

Давтан сургалт явуулахад хууль хяналтын байгууллагад санхүүгийн бэрхшээл тулгардаг. 1996 оноос Монгол-Германы хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд интерактив хэлбэрийн сургалтыг явуулж эхэлсэн. Эдгэр сургалтыг ялангуяа хедеэ орон нутгийн шүүхүүд маш сайн хүлээн авсан бөгөөд энэ нь шүүгч нарт зориулсан давтан сургалтын ганц боломж нь байлаа. Давтан сургалтыг урьд нь гадаадын багши нар заадаг байсан бол одоо сургалтын дийлэнх хэсгийг бүтэн жилийн турш шүүгчийн ажлаасас чөлөөлгөн, тусгайлан бэлтгэгдсэн монгол шүүгч багши нар явуулж байна. Сургагч багши нарын багийн дэмжлэгтэйзэр таван багц хуулийг хэрэгжүүлэхээр зорьж байгаа. Энэ нь хүнд бөгөөд цаг хугацаа нилээд шаардагдах ажил юм.

4. Тангарагтны болон туслах шүүгч

Монгол улсад эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд тангарагтан шүүгч оролцдоггүй. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйг шинчлэх явцад Германы загварын дагуу тангарагтан шүүгчийг оруулах талаар хэлэлцэж байсан хэдий ч 2002 оны 9-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон хуульд хэрэгжих чадаагүй. Тангарагтан шүүгчийн оронд эрүүгийн болоод иргэний хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаанд иргэдийн төлөөлөгч оролцдог. Тэдгэр нь хэрэг маргааны талуудын адил статусийг байдаг. 2002 онд батлагдсан ИХШХШТХуульд тэдний эрхийг нилээд өргөн хүрээнд хязгаарлаж өгсөн. Урьд өргөдөл болон гомдол гаргах эрхтэй байсан бол одоо зөвхөн анхан шатны шүүх хуралдаан дээр асуулт тавих, мөн түүчлэн гэм бурууний

асуудал дээр зайлшгүй дагах ёсгүй санал өгөх эрхтэй болгосон. 2002 онд батлагдсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд ч мөн ялгаагүй иргэдийн төвлөгөөгчид гэм бурууний болон ял шийтгэлийн хэмжээний талаар өргөдөл гаргах болоод асуулт тавих эрхтэй байхаар заажаа ёсген. Монголын шүүхийн тогтолцоонд туслах шүүгч гэж байдал бөгөөд тэд байнгын орон тооны шүүгчийн зэгүйд буюу шүүгч 12 хоногоос дээш хугацаагаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон үед буюу өвчтэй үед шүүгчийг орлон ажилладаг. Туслах шүүгч нь шүүгчийн албанд ажиллах шаардлагыг хангасан байх ёстой.

V. ПРОКУРОР

Монгол улсын Үндсэн хуулийн "Шүүх эрх мэдэл" гэсэн З дугаар булагт прокурорын байгуулагын тухай заалтууд орсон байдаг. Энэ нь хууль тогтоогч прокурорын байгуулагыг гүйцэтгэх засаглалын нэг хэсэг бус, харин шүүх засаглалын нэг хэсэг, гэхдээ шүүхээс хараат бус байгуулаглаа байгалаараг хүссэн нь харагдаж байна. Зөвхөн шүүхүүд бус прокурорын байгуулаглаа ч мөн адил гүйцэтгэх засаглалаас хараат бус байдал. Энэ хөфөр байгуулаглаа өөр хоорондоо хамааралгүйгээр гүйцэтгэх засаглалыг хянаж байдал бөгөөд прокурорын байгуулаглаа үүний зэрэгцээ шүүхийн үйл ажиллагааг ч хянаж байдал. Монголын прокурорын байгуулагын үйл ажиллагааны чиг үүрэг нь ЗХУ-ын загварын ижил тестэй байгаа юм. Энэ нь ернедийн улс оронуудад хэргэлгэдэж байгаа 1789 оны Францын хувьсталийн дараагаар гарсан Руссо-гийн онодлын дагуу прокурорын байгуулаглаа нь гүйцэтгэх засаглалын гар гэсэн ойлголтоос эрс зерж байна. Иймд УЕПГ нь УДШ-ийн нэгэн адил чухал үүрэг рольтой байдал. Улсын ерөнхий прокурорыг Ерөнхийлөгч парламенттай зөвшилцэн 6 жилийн хугацаатайгаар томилдог.

Прокурорын байгуулагын чиг үүрэг нь өнөөгийн байдлаар өөрчлөгдхөш шатандaa явж байна. Өнөөг хүртэл мөрдөн байцаах бүхий л ажиллагааг цагдаагийн байгуулаглаа гүйцэтгэх харин прокурорын байгуулаглаа цагдааг хянах үүрэгтэй байсан. Шүүх хуралдаанд прокурор шүүгчийн зөвлөх буюу хянагчийн хувьд оролцож байсан. Үүнээс гадна прокурор иргэний хэрэг маргаан шийдвэрлэх ажиллагаанд териийн ашиг сонирхолыг төлөөлөн оролцож ирсан. Харин 2002 оны 9-р сарын 1-нд хүчин төгөлдөр болсон ЭБШХуулийн дагуу прокурор мөрдөн байцаах ажиллагааг удирдан явуулах болсон. Мөрдөн байцаах ажиллагааг Герман улсад байдагтай ижил хүнд болон хөнгөн гэмт хэрэгт аль алиинд нь ялгаагүй явуулахаар болсон.

Иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанд тэд цаашдаа зөвхөн териийг хэрэг маргааны оролцогч талын хэмжээнд төлөөлж байх бөгөөд иргэний хэрэг шийдвэрлэх бусад үйл ажиллагаанд оролцохгүй. Прокурорын байгуулаглаа урдын адил эрүүгийн ял эдлүүлах ажиллагаанд хяналт тавьсаар байх болно. Прокурорын байгуулагын чиг үүргийг шинээр тодорхойлсон нь энэ чиглэлд дэвшил гарч байгаагийн илрэл юм.

Чиг үүргийн шинэ хуваарилалт нь хэрэгжжээ эхэлмэгц прокурорын байгуулагын тогтолцоонд хамтаттан оруулсан социализмын тэгдэх зөвхөн хяналтын тогтолцоо нь үүгий болно, өөрөөр хэлбэл прокурорын чиг үүрэг зөвхөн хянах хүрээнээс өргөн хүрээтэй болж буй юм. Мөрдөн байцаах зарим нэг чиг үүргийг хууль зүйн илүү өндөр чадвартай прокурорын

байгууллагад шилжүүлэн өгсөн нь Монголд урьд нь бараг гарч байгаагүй здийн засгийн, байгаль орчны болон зохион байгуулалттай гэм хэрэгтэй тэмцэх зэрэг илүү нааштай байдлыг бий болгож буй юм. Ялангуяа эрүүгийн байцдан шийтгэх ажиллагаагаар урьд нь явуулж байгаагүйн хувьд хэзл хахуул, авилгалын эсрэг түүнээс огт хамааралгүйзэр ажиллаж чадна. Шинэ тогтолцоо хангалийт байдлаар ажиллаж эхлэх хүртэл өөрчлөлтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад зүйлүүдийг цэгцах хэрэгтэй. Хамгийн хундралтэй нь прокуроруудыг тэдний шинэ чиг үүрэгт бэлтгэх явдал юм. Урьд нь прокурорууд тэдний чиг үүрэгээс хамааран зах зээлийн здийн засгийн болон түүний эрх зүйн зохицуулалтын сургалтад тэр бүр хамрагдаж чаддагтуй байлаа. Үүнийг ч гэсэн ирээдүйд верчлех болно. Интерактив хэлбэрийн жишээ бодлогод сууринласан эрчимтэй сургалтууд 2002 оны зунаас явагдах эхэлсэн. Прокурорын байгууллагын зохион байгуулалтыг сайжруулах загвар тесэл ҮЕПГ-т хэрэгжиж байна. Гэсэн ч прокурорууд шаардлагатай ноу-хауг зэмших хүртэл нилээд хугацаа шаарддагдах болно.

ҮI. НОТАРИАТЧ БА ӨМГӨӨЛӨГЧИД

1. Notariat

Өөрчлөлт шинэтгэлийн үйл явц явсан явааар 1985 онд батлагдсан нотариатын хуулийг дөнгөж 1997 оны 5 сард шинчилж баталсан бөгөөд социализмын үед нотариатчид төрийн албанад харьялагддаг байв. 1997оны нотариатын хуулиар нотариатын үйл ажиллагааг эрхлэн явуулах З төрлийн нотариатч байна гэжээ. Үүнд нотариатч, өмгөөлөгч нотариатч болон нотариатчийн үүрэг гүйцэтгэгч төрийн захирагааны албаны хүмүүс байна. Хөдөө срон нутагт нотариатын үйл ажиллагааг нотариатчаас илүү нотариатын үүраг гүйцэтгэгч төрийн захирагааны албаны хүмүүс эрхлэн явуулах нь элбэг. Үүнээс гадна нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн үүргийг хилийн чинад дахь дипломат төлөөлөгчийн болон консульын газар эрхлэн явуулдаг.

Өмгөөллийн хуулийн дагуу өмгөөлөгч, нотариатчийн үүргийг давхар гүйцэтгэхийг зөвшөөрдөг.

Монгол улсын хэмжээнд үндэсний нотариатын нэг танхимтай бөгөөд салбарууд нь аймаг болон нийслэлд үйл ажиллагаагаа явуулдаг. Энэ байгууллага нь ашгийн төлөө бус хуулийн этгээд бөгөөд хууль зүйн яаманд бүртгүүлнэ. Нотариатын танхим нь Хууль зүйн яамтай хамтран нотариатын үйл ажиллагаанд хяналт тавидаг.

Нотариатчар монгол улсын харьят, хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, тогтоосон журмын дагуу мэргашгийн шалгаруулалтад орж, нотариатын үйл ажиллагаагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг ажиллуулахыг зөвшөөрнэ. Нотариатчийн сонгон шалгаруулах ажлыг нотариатын танхим зохион байгуулна. Нотариатын танхимын дэргэд нотариатчийг сонгон шалгаруулах мэргэжлийн, орон тооны бус комисс ажиллана. Комиссын бүрэлдэхүүнийг Хууль зүйн сайд батална. Хэрэв нотариатчийн сонгон шалгаруулалтад оролцуулахаас татгалзсан шийдвэрийг тухайн иргэн эс зөвшөөрвэл, шүүхэд гомдол гаргах эрхтэй. Нотариатч болон өмгөөлөгч нотариатын үйл

ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг Хууль зүйн яамнаас өгдөг. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэшлийн шалгаруулалт явуулах тухай асуудлыг нотариатын тойрог, нотариатчын орон тоо, хэрэгцээг харгалзан тухай бүр шийдвэрлэн. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан нотариатч Нотариатчдын танхимд бүртгүүлж үйл ажиллагаагаа явуулна.

Нотариатын тойрог, түүнд ажиллах нотариатчийн тоог хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтоодог. Аймаг, нийслэлийн Засаг дарга хүн амын байршил, нийгмийн хөгжил, хэтийн төлөвлөгөөний харгалзан нотариатын тойрот ажиллах нотариатчийн тооны талаар саналлаа боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн териийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ хэмээн зохицуулсан нь нотариатчдын тоог захиргааны аргаар хязгаарлаж буй мэт сэтгэгдэл төрүүлж байна. Улмаар цөөн тооны нотариатч өндөр орлоготой ажиллах нехцел байдал үүсч нь уг мэргэжлээр ажиллах сонирхолыг бүрэлдүүлж өрсөлдөөн өрнүүлэх зергээ талтай хэдий ч албан тушаалаа урвуулан ашиглах, хээл хахуульд өртөх эрсдлийг нэмэгдүүлж байна.

Нотариатч нь үйл ажиллагаагаа явуулахдаа хараат бус бие даасан шинжтэй ажиллах ёстой бөгөөд өөрийн үйл ажиллагаагаа хууль бусаар ашиглахыг хатуу хориглоно. Нотариатч нь нотариатчийн үйл ажиллагаанаас хохирол учирч болох тохиолдол бүрийг тусгасан даатгалын гэрээг Нотариатчдын танхимтай байгуулдаг. Нотариатчдын танхим гэрээний нехцел өөрчлөгдхөх, хүчингүй болох, хугацаа нь дуусгавар болох тохиолдолд энэ тухай нотариатчдад нэн даруй мэдэгдэж байна. Өнеөг хүртэл Хууль зүйн яам нь нотариатын танхимд хүчтэй нөлөөлж байгаа явдал нь нотариатчид бие даасан байдлаа бүрэн дүүрэн хярагчжуулж чадахгүйд хүргэж байгаа хэдий ч шинатгалийн үйл явц нотариатын эрх зүйн орчинг түүштэй өөрчилсөөр байна. Ялангуяа хөрш зэргэлдээ БНХАУ-д өнеөг хүртэл териийн албаны нотариат байдагтай харьцуулахад урагштай хөгжжих байна гэж дүгнэж болно.

2. Өмгөөлөл

Социализмын үед Монголд мэргэжлийн өмгөөлөгчийн нэгдсэн стандарт гэж хараахан байсангүй. Анх 1928 онд өмгөөлөгчдийн холбоог байгуулсан түүхтэй. 1944 оны өөрчлөлт шинэчлэлтээр бүх өмгөөлөгчид териийн албанц харьяалагдах болсон хэдий ч мэн онд батлагдсан өмгөөллийн хуулиар чөлөөт өмгөөлөгчид байж болох талаар тусгаж эхэлсэн байна. Улсын хэмжээнд өмгөөлөгчдийн нэг холбоо байх бөгөөд Аймаг, нийслэлийн салбар зөвлөлтэй, тэдгээр нь териийн бус, мэргэжлийн байгууллага байх ба өмгөөлөгчийн бие даасан, хараат бус байдлын хүрээнд өмгөөллийн үйл ажиллагааг нутаг дэвсгэртээ зохион байгуулах ажлыг эрхлэн. Өмгөөлөгчдийн холбоо нь гишүүдийн хандиварсан хүчжүүгинэ.

Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Монгол улсын харьяат, хууль зүйн дээд боловсролтой, урьд өмнө ял шийтгэл эдлэж байгаагүй, тогтсон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж тэнцсэн иргэнд олгодог. Тусгай зөвшөөрөл олгох мэргэшлийн хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх ба сонгон шалгаруулалтыг эрхлэн явуулдаг. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнийг шүүх, прокурор, хууль зүйн асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг, Өмгөөлөгчдийн холбооноос зурган хүний төлөөлөлтэйгээр, тэдгээр байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Мэргэшлийн шалгаруулалтад тэнцсан хуульчид тусгай зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгодог. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан өмгөөлөгч Өмгөөлөгчдийн холбоонд бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах эрх эзлнэ.

Монголд өмгөөлөгчийн сонгох эрхтэй. Өмгөөллийн үйл ажиллагаа төрийн извэлд байх ба аливаа байгууллага, албан тушаалтад өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс үл оролцно. Аливаа этгээдээс өмгөөлөгчид эрх зүйн туслалцаа хүсч хандсан болон үйлчлүүлэгчид эрх зүйн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчийг гэрчэр болон бусад байдлаар байцаах, нехцел байдлыг тодруулах зорилгоор асуухыг хориглоно. Мен өмгөөлөгч өмгөөллийн нууцыг задлах, эсхүл амин хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахыг хориглоно. Мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутсаны улмаас өмгөөллийн үйл ажиллагаанд алдаа гаргаж үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнийг нехэн төрөх зорилгоор өмгөөлөгч хариуцлагын даатгалд даатгуулна. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг нь харгалзан үзэж түүнийг өмгөөллийн үйлчилгээний хэлс төлөхөөс чөлөөлж болно.

Өмгөөллийн байгууллагад бүтцийн өөрчлөлт, шинчлэлтийн үйл явц их бага хэмжэээр хэрэгжих байна гэж үзэж болно.

Дээр өгүүлсэнчлэн монголын шүүхийн шийдвэрүүдийн ихэнх хэсэг нь учир дутагдалтай байгаа. Энэ бүхийг гагцхуу шүүгчдийн мэргэжил боловсролын асуудлаар тайлбарлах нь хангалигүй. Алдаагүй шийвэр гаргахад нь налеөлж чадах өмгөөлөгч дутагдаж байгаатай ч холбоотой. Үгээр өмгөөлөгчдийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээ нэн тэргүүнд тавигдаж байгааг харуулж байна.

VII. ЭРХ ЗҮЙН БАЙДАЛД ӨГӨХ ҮНЭЛЭЛТ, ДҮГНЭЛТ

Юуны өмнө сүүлийн жилүүдэд хууль эрх зүйн салбарт явуулсан өөрчлөлт шинэтгэл ямар үр дүнд хүрэв гэдгийг тодорхойлох хэрэгтэй. Өмнө нь явуулсан санал асуулгаар судалгаанд оролцогчдын ихэнх нь "Здийн засгийн хөгжилд саад болж буй гол зүйл нь эрх зүйн орчин" гэж үзэж байсан бол одоо 24% болж бууручээ. Мен цаашид анхаарвал зохих эхний 10 салбарын дотор хууль, эрх зүйн салбар 8-д тооцогдож буйг энэ судалгаагаар тогтоосон байна.

1. Хууль хамгаалах байгууллагуудын дотоод зохион байгуулалт, бүтцийн асуудал

Юуны өмнө хууль хамгаалах байгууллагуудын дотоод зохион байгуулалт, бүтцийг шинчлэх асуудлаар Монгол улс зоримог бөгөөд дорвийт шинэтгэлийг хэрэгжүүлж чадсан гэж тэмдэглэмээр байна. Шүүхийн болон шүүгчдийн хараат бус байдлыг хуульчлан тогтоосон болон 2002 онд хүчин төгөлдөр болсон Иргэний болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу прокурорын байгууллага эрх зүйт төртэй орнуудын

прокурорын байгууллагуудын гүйцэтгэдэг сонгодог чиг үүргийг хэрэгжүүлэх болсон нь нэн дэвшилтгэй үзэгдэл юм.

Өмгөөллийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох үйл явц үндсэндээ дууссан бөгөөд зөвхөн Нотариатын танхим ба ХЗЯам хоорондын харьцааг либериальчлах алхам үгүйлэгдэж байна.

1990-ээд оны байдалтай харьцуулбал төрийн хяналтын хатуу механизмыг устаж туннийг хэрэгжүүлэгч бүтцүүд үгүй болсон байна. Ийм ч учраас олон улсын шинжээчид Монгол улсыг эрх зүйн шинэлгээг хэрэгжүүлэгч орныхын хувьд "үлгэр жишээ орон" хэмээн нэрлэх нь олонтаа байна.

Эрх зүйн шинэлгээний замаар замнаж буй бусад орнууд (жишээлбэл: БНХАУ) Монголын туршлагаас суралцах нь зүйтэй.

2. Эдийн засгийн тогтвортой хөгжилд эрх зүйн тогтолцоо нелэөлөх нь

Харамсалтай нь Монгол Улсын эрх зүйн тогтолцоо тус орны эдийн засгийн тогтвортой хөгжлийг баталгаажуулан хангах хэмжээнд хүрээгүй байна.

Ямарваа нэгэн хэрэг маргаан шүүхэд хэрхэн шийдвэгдэх талаар урьдчилан таах аргагүй бөгөөд эл явдал нь хуулийн байгууллагуудын зохион байгуулалт, бүтцийн асуудалтай бус нийт хууль хэрэглэгчдийн мэдлэг боловсрол, мэргэжлийн үр чадвартай холбоотой юм. Орчин үеийн хууль зүйн шинжлэх ухаан бүрэн төгс хөгжөөгүй байгаа байдал нь дээр дурьдсан асуудлыг хүндруүлж байна.

Үүний ээрэгцээ шилжилтийн үйл явцад байгаа орнуудад ажиглагддаг түгээмэл бэрхшээлүүд ч Монголын эрх зүйн шинэлгээд хүчтэй серег нелвэ үзүүлж буйг үгүйгэх аргагүй юм.

Цавшид эрхэйн шинэлгэлийг гүнзгийрүүлэх улмаар эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох үүднээс дараах алхамуудыг хийх нь зүйтэй мэт санагдана:

1. Хууль зүйн шинжлэх ухааныг судалгааны болон сургалтын чиглэлээр тулхүү дэмжих;

2. Хуульчдыг сонгон шалгаруулах, мэргэшүүлэх чиглэлээр хийсэн ажлыг цавшид туштай мөрдех, хуульчдын сургалт, давтан сургалтын асуудлыг эрчимжүүлэх;

3. Хуулийн логик, хууль хэрэглэх ба ямарваа нэг хэрэг маргааныг зүйлчлэн шалтых арга техникийг (subsumtionstechnic) хуульчдын сургалт ба давтан сургалтын суурь болгох;

4. Соён гэгээрүүлэх замаар авилгальтай эрчимтэй тэмцэх.

Орчуулсан: **Б.Жавхлан**
А.Дэлгэрмээ
Б.Энхцэцэг
Л.Эрдэнэ-Очир

ОХУ-ЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХ ЗӨВХӨН ҮНДСЭН ХУУЛЬДАА ЗАХИРАГДАНА

Үндсэн хуулийн Цэцийн ажилтан Э.Лхагвасурэн

ОХУ-ЫН Үндсэн хуулийн шүүх нь тухайн улсын засаглалын тогтолцоонд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн Үндсэн хуулийн шүүхийн сонгодог утгаарахаа 1991 онд байгуулагдсан түүхтэй. Үүнээс өмнө дээрх байгууллагын үргийг 1089 оноос 1991 он хуртэл хуучнаар ЗСБНХУ-ын Үндсэн хуулийн хяналтын хороо гүйцэтгэж байв.

Тухайн үед ЗСБНХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн хяналтын хороо нь эрх зүйн хэм хэмжээний актуудад зохицууллагдан үйл ажиллагаагаа явуулах нь Зөвлөлт төр, засгийн нэг үндсэн шинж мен гэдэг үзэл баримтлалыг удирдлага болгон ажиллаж байсан ч тэр үеийн эрх баригч коммунист нам Үндсэн хуулийн хяналтын хорооны дээрх үзэл баримтлалыг ойшоож үзэхгүй байв.

Харин 1990 оны 4 дугаар сард ЗСБНХУ-ын төр, засаг Үндсэн хуулийн хяналтын хороонд хязгаарлагдмал бүрэн эрхийг бүрдүүлж өгсөн боловч 1991 оны 12 дугаар сард уг хороо үйл ажиллагаагаа зогсоожээ.

ЗСБНХУ-ын Үндсэн хуулийн хяналтын хороо нь хүний эрх, эрх чөлөөг дээдлэх зарчмыг баримталж шинээр батлагдан гарч буй хууль тогтоомжкуудад энэхүү зарчмыг ханггуулах талаар ажиллаж байсан нь утгаа ОХУ-ын шинж Үндсэн хуулийн язгуур үндэс нь болсон байна. Өөрөөр хэлбэл ОХУ-ын Үндсэн хуульд "Хүн, түүний эрх, эрх чөлөө бол хамгийн дээд зүйл юм. Хүн ба иргэний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, сахин биелүүлэх, түүнийг хамгаалах нь териин гол үүрэг мөн" хэмээн заажээ.

ОХУ-ЫН Үндсэн хууль батлагдсаны дараа буюу 1994 оны 7 дугаар сарын 21-нд ОХУ-ЫН Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль батлагдан гарсаннаар ЗСБНХУ-ЫН Үндсэн хуулийн шүүхийн тухай хууль хүчингүй болжээ.

Шинээр батлагдсан ОХУ-ЫН Үндсэн хуулийн шүүхийн тухай болон Холбооны улсын хуульд зааснаар "ОХУ-ЫН Үндсэн хуулийн шүүх нь эрх зүйн маргаантай асуудлыг практикт нийцүүлэн аливаа улс териийн сонирхолоос ангид гагцхүү шүүхийн байр сууриннаас эрх зүйн хэм хэмжээнд тулгуурлан хянан шийдвэрлэх, мөн хууль тогтоомжийн хүрээнд ард иргэдийнхээ эрх, эрх чөлөөг дээдлэн хамгаалах, тэдний нийгмийн болон ажил албаны, хувийн эрх ашиггээрхэмлэн баталгаажуулах, ямар ч нехцэлд аль нэг нам, улс төрийн хүчиний үзэл баримтлалыг илэрхийлэх болон хэн нэгний үйл ажиллагаагаа үзэлж дүгнэх, эрх мэдлээсээ хэтэрсэн үйл ажиллагаа явуулах эрхгүй" тухай онцлон заасан байдаг.

ОХУ-ЫН Үндсэн хуулийн шүүхийн шүүгч

ОХУ-ЫН Үндсэн хуулийн шүүх нь Холбооны Зөвлөлөөс томилогдсон 19 шүүгчээс бүрдэх ба тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа нь 12 жил, Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн уг албан тушаалыг хা�шиж насны дээд хязгаар нь 70 байна. Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид нэр дэвшигч нь ОХУ-ЫН

иргэн байх бөгөөд хууль зүйн дээд боловсролтой, 40 хүртэлх наасны, мэргэжлээрээ 15-аас доошгүй жил ажилласан, нэр хүнд бүхий иргэн байх ёстой.

Шүүгчид нэр давшүүлэх тухай саналыг ОХУ-ын Ерөнхийлөгчид Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын гишүүн, түүнчлэн ОХУ-ын субъектуудийн хууль зүйн байгууллагын төлөөлөгчид, хуулийн дэд байгууллага болон холбооны хууль зүйн захиргаа, Бүх Оросын Хууль цаазын шинжлэх ухааны болон сургуулийн газруудаас оруулж болдог.

ОХУ-ын Ерөнхийлөгчийн саналыг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчид томилох тухай асуудлыг Холбооны зөвлөл авч хэлэлцэн шүүгч бүрийг тусад нь нууц санал хуралтаар олонхийн саналаар томилно.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн бүрэлдэхүүнд Холбооны Зөвлөлийн гишүүн, Төрийн Думын гишүүн, тэдгээрийн төлөөллийн байгууллагын гишүүд орж үл болно. Үндсэн хуулийн шүүхийн шүүгч сурган хүмүүжүүлах, шинжлэх ухаан, оюуны хөдөлмөрөөс бусад үйлдвэрлэлийн болон тэдгээрийн удирдах ажил хийж болохгүй.

Холбооны Зөвлөлийн дарга тогтоосон журмын дагуу Үндсэн хуулийн шүүхийн шүүгчээр томилогдсон шүүгчдийг тангараг өргүүлнэ. Энэхүү тангараг нь "ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн албан үүргийг хэнд ч, юунд ч үл захирагдан гагцхүү ОХУ-ын Үндсэн хуульд захирагдан үнэнч шударга биелүүлэхээ тангараглаж байна" гэсэн утга агуулгатай байдаг.

Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нь урьд өмнө:

- шүүхээр шийтгүүлж байсан;
- эсвэл түүнийг эрүүгийн хариуцлагад татагдаж байсныг мэдсэн;
- эрүүл мэндийн байдлаас болж бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүй болсон тохиолдолд Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг 1 сараас дээшгүй хугацаагаар бүрэн эрхийг нь түтгэлзүүлж болно.

Харин дараахь тохиолдолд шүүгчийн бүрэн эрх дуусгавар болно.
Үүнд:

- Шүүгчийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон,
- албан үүргээсээ чөлөөлгэх тухай хувийн хүснэгтээ гаргасан,
- иргэний харьялалaa eerchilsen,
- шүүгчээр ажиллах хуулиар тогтоосон наасны дээд хязгаараас хэтэрсан,
- хуулийн дагуу эрүүгийн хариуцлагад татагдах шүүхээс ялны тогтоол гарсан бол,
- шүүгчийн нэр төрийг гутаасан гэмт хэрэг үйлдсэн бол,
- хуулиар тогтоосон албан үүрэгт нь харшлах үйл ажиллагаа эрхлэсэн бол,
- Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанаас хүндэтгэн үзэх шалтгаангүйзэр хөбоос дээш удаа зайлсхийсэн бол,
- эрүүл мэндийн хувьд болон өөр бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас удаан хугацааны туршид албан үүргээ гүйцэтгэж чадахгүй бол,

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

- эрх зүйн чадамжгүй болсон,
- нас барсан бол,
- сураггүй алга болсонд тооцсон тухай шүүхийн шийдвэр гарсан зэрэг болно.

Холбооны Зөвлөлт Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн дагуу Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бурэн эрхийг дуусгавар болгох тухай шийдвэр гаргаж, энэ тухайгаа ОХУ-ын Ерөнхийлөгчид албан ёсоор мэдзэлнэ.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дарга, дэд дарга

Үндсэн хуулийн шүүхийн дарга, дэд дарга, нарийн бичгийн даргыг Үндсэн хуулийн шүүхийн Бүгд хуралдаанаас 3 жилийн хугацаатай сонгох ба нэг удаа улируулсан сонгож болно. Үндсэн хуулийн шүүхийн ажил хэрэг болон бусад асуудлыг бүгд хуралдаанаараа, мөн шүүхийн 2 танхимаар авч хэлэлцэнэ. Энэхүү 2 танхимины нэг нь 10 шүүгчийн, нэгээ нь 9 шүүгчийн бурзэлдэхүүнтэй байх бөгөөд 2 танхимаас гаргасан аливаа шийдвэр нь хууль зүйн хувьд адил хүчин төгөлдөр үйлчилнэ.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дарга нь:

- Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдааны бэлтгэл ажлыг удирдан эхион байгуулж, хуралдаанаар даргална.
- Бүгд хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоох,
- Үндсэн хуулийн шүүхийн хуралдааны бурзэлдэхүүнгүй томилох,
- Хэлэлцэх хэрэг маргаантай асуудлыг 2 танхимд хувиарлах,
- Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бурэн эрхийг тутгалзулж,
- Үндсэн хуулийн шүүхийн дотоод гадаадад төлөөлж, түүний нэрийн өмнөөс мэдэгдэл гаргах,
- Эрх эзмийзнийгээ хурэнд тушаал, захирамж гаргана,
- Хууль тогтоомжид зассан бусад бурэн эрхийг здэлнэ

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн дэд дарга нь Үндсэн хуулийн шүүхийн даргын түрээгүйд болон эрүүл мэндийн байдлаас болж албан ўүргээ гүйцэтгээгүй тохиолдолд даргыг орлоно.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн нарийн бичгийн дарга

- Үндсэн хуулийн шүүхийн ажлын албыг удирдах,
- Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдааны болон 2 танхимины хурлын бэлтгэл ажил, түүний эхион байгуулалтыг хангах,
- Хуралдааны шийдвэр болон хэлэлцсэн асуудлын талаар нийтэд мэдээлэл хийх,
- Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг шаардлагатай мэдээллээр хангах ажлыг удирдах болон хуулиар олгогдсон бусад бурэн эрхийг хэрэгжүүлна.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь ОХУ-ын бүх нутаг дэвсгэрт, эрх бүхий байгууллага, засаг захиргааны нэгж, шүүх, аж ахуйн

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

нэгж байгууллага, албан тушаалтан, иргэдэд бүгдэд нь хамааралтай. ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 2 танхмын хурлаас гаргасан шийдвэр ч, мен бүгд хуралдаанаас гаргасан шийдвэр ч Үндсэн хуулийн шүүхийн эцсийн шийдвэр байна.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэр нь магадлал, тогтоол гэсэн хэлбэрээр гарна. Эрх зүйн маргаантай асуудлыг хэлэлцэн тохиолдолд тогтоол, хэрэг маргааныг хянан хэлэлцэх явцад өөр бусад асуудлыг шийдвэрлэснийг нь магадлал гэнэ. Мен Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаа, бусад зохион байгуулалтын асуудлаар шийдвэр гаргана.

Үндсэн хуулийн шүүх веерийн бүрэн эрхийн хурээнд ажиллаж байгаа тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд ямар нэг тушаал шийдвэр өвх байгууллага, эрх мэдэлтэн, бүр Улсын Ерөнхийлөгч ч байх ёсгүй. Ерөнхийлөгч болон Төрийн Дум веерийн байнгын төлөөлөгчийг Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанд томилох ба тэрхүү байнгын төлөөлөгч нь Үндсэн хуулийн шүүхийн хуралдаанд тодорхой асуудлаар томилогдсон байгууллагын байр суурийн илэрхийлэх уурзгэй. Байнгын төлөөлөгчид нь Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх, шийдвэрээс татгалзах эрхгүй.

Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг дагаж мөрдөхгүй, түүний хэрэгжилтэд аливаа саад хийсэн хэнийг ч болов Холбооны хуулийн дагуу хариуцлагад татна.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн бүрэн эрх

Үндсэн хуулийн шүүхийн нийт гишүүдийн дэревний турваас багагүй бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулах эрхтэй.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх нь Үндсэн хуулийн хяналтын шүүх байгууллага бөгөөд биеэ даасан, хэнээс ч хараат бус, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, Үндсэн хуулийн хэрэгжилт болон түүний эрхэм дээд байдлыг ОХУ-ын бүх нутаг дэвсгэрт хангах зорилгоор ОХУ-ын Үндсэн хуульд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.

- Хууль, Ерөнхийлөгч, Төрийн Дум, Засгийн газар, Холбооны Зөвлөлөөс гаргасан бусад шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх,
- Бүгд Найрамдах Улсын Үндсэн хууль, хууль, хэм хэмжээний актууд, дүрэм, түүнчлэн ОХУ-ын тэр засгийн байгууллагад хамаарах асуудлууд, ОХУ-ын субъектүүдийн хууль дүрэм нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх,
- ОХУ-ын Төр, засгийн байгууллага, ОХУ-ын Төр засгийн субъектүүдийн коорондох гэрээ хэлэлцээр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх,
- ОХУ-ын Олон улсын гэрээ хэлэлцээр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх,
- Эрх мэдлийн тухай маргааныг магадлан шийдвэрлэх
- Төр, Засгийн болон Холбооны байгууллагуудын коорондох маргаан,
- Холбооны Төр Засгийн байгууллага болон ОХУ-ын субъектүүдийн коорондох маргаан,

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

- ОХУ-ын субъектүүдийн Төр, Засгийн дээд байгууллагуудын хоорондох маргаан
- ОХУ-ын Үндсэн хуулийн дагуу иргэний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн тухай голмодлын дагуу маргаан үүсгэн шийдвэрлэх
- ОХУ-ын Үндсэн хуульд тайлбар гаргах
- ОХУ-ын Ерөнхийлөгч эх ороосоо урvasan, эсвэл онц ноцтой гэмт хэрэг үйлдсэнэй нь тогтоо тухай дүгнэлт гаргах
- Өөрийн эрх мэдлийн асуудлаар хууль санаачлах
- Өөрсдийн дотоод үйл ажиллагааны талаар Үндсэн хуулийн шүүхийн дотоод журмыг батлах,
- Үндсэн хууль болон Үндсэн хуулийн шүүхийн тухай хуулиар олгогдсон бусад бүрэн эрхийг эзлэн.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдаанвар Үнсэн хуулийн шүүхийн эрх хэмжээний талаархи ямар ч асуудлыг авч хэлэлцэх эрхтэй бөгөөд дараах асуудлуудыг зөвхөн Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдаанвар авч хэлэлцэн. Үүнд:

- ОХУ-ын Үндсэн хуульд Бүгд Найрамдах Улсын Үндсэн хууль, ОХУ-ын субъектүүдийн хууль, дүрэм нийцсэн эсэх,
- ОХУ-ын Үндсэн хуульд тайлбар гаргах,
- ОХУ-ын Ерөнхийлөгч эх ороосоо урвах, онц ноцтой гэмт хэрэг үйлдсэн тухай дүгнэлт гаргах,
- Өөрсдийн эрх хэмжээний талаар хууль санаачлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэн. Мен Үндсэн хуулийн шүүхийн дотоод зохион байгуулалтын асуудлаар буюу;
- Үндсэн хуулийн шүүхийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргыг томилох,
- Үндсэн хуулийн шүүхийн хуралдааны дэг, дотоод журмыг батлах, өөрчлөлт оруулах
- Үндсэн хуулийн шүүхийн танхим хоорондын ажил хэргийг хувиарлах,
- Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийн бүрэн эрхийг тутгэлзүүлэх, дусгавар болгох шийдвэр гаргах
- Үндсэн хуулийн шүүхийн дарга, орлогч дарга, нарийн бичгийн даргыг албан тушаалаас нь хугацаанаас нь өмнө огцруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэн.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн хуралдааны дэгэр 2 танхимины ажил хэргийг хувиарлах журам, танхим болон бүгд хуралдаанар асуудлыг хэлэлцэх дараалал, хурлын даг жаяг, Үндсэн хуулийн шүүхийн албан бичиг хэргийг хөтөх онцлог. Үндсэн хуулийн шүүхийн ажлын албаны ажилтнуудад тавигдах шаардлага мен Үндсэн хуулийн шүүхийн дотоод үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан байдаг.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн үндсэн зарчим

- Шүүгч биеэ даасан байх
- Үйл ажиллагаа нь ил тод байх
- Маргааны хамтын зарчмаар шийдвэрлэх
- Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа нь тасралтгүй байх
- Маргагч талуудын эрх тэгш байдлыг хангах зэрэг болно.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн ажлын алба

ҮНДСЭН ХУУЛИЙН БАЙГУУЛАЛТ

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн едер тутмын ўл ажиллагаагаар нарийн бичгийн дарга нарын газар болон өөр бусад салбар хэсгээс бүрдсэн ажлын алба хангана. Нарийн бичгийн дарга нарын газар нь зохион байгуулалт, шинжлэх ухаан, мэдээлэл, лавлагас болон бусад зүйлзэр Үндсэн хуулийн шүүх, шүүгчдийг хангах ажиллагаагаар хэрэгжүүлнэ.

Төлөвлөгөдийг хүлээн авах, хурал, зөвлөгөөнд хэлэлцэх асуудлыг бэлтгэх, шүүгчдэд шаардлагатай туслацааг үзүүлэх, мэдээлэлээр хангах, Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийн хэрэгжилтийг хянах ажлыг гүйцэтгэнэ. Мен ажлын албанаа бусад салбар хэсгүүд нь Үндсэн хуулийн шүүх, түүний гишүүдийг материал, техник болон ахуй хангамжаар хангах ўүргэлтийн.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх нь "ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн мэдээ" гэсэн албан ёсны хэвлэлтэй, ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тамга нь ОХУ-ын төрийн сүлд бүхий дурстэй верийн нэртэй байна.

Үндсэн хуулийн шүүхийн байгын байрлах газар нь ОХУ-ын нийслэл Москва хот. Үндсэн хуулийн шүүхийн байран дээр ОХУ-ын төрийн далбааг мандуулах ба Үндсэн хуулийн шүүхийн хурлын танхимд ОХУ-ын төрийн сүлд болон түгийг байрлуулсан байна. Үндсэн хуулийн шүүгчид нь тусгай өмсгэл /нэмрэг/-тэй байх бөгөөд хуралдааны үед өмснөн. ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх нь Холбооны төсвөөс санхүүждэг.

Үндсэн хуулийн эрх зүй ба иргэний эрх, эрх чөлөөг зөрчсөн талаархи гомдолыг хянан шийдвэрлэх

Францын алдарт философич, эрх зүйч Шарль Монтесье 18 дугаар зуунд бичихдээ: "Би аль нэг улсад очиждоо тэр улсад хир сайн хууль байдгийн сонирхлогүү, харин тухайн хууль нь хэрхэн хэрэгжээгэйг л сонирхдог. Яагаад гэвэл хаа сайгүй л сайн хуулиуд байдаг" гэж бичжээ.

Энэхүү узл номилот одоо ч хуучраагий юм. 1998 оны 2 дугаар сарын 17-ны өдөр баталсан ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн тогтооолд "Хүн бүхэн, ялангуяа гадаадын иргэн, мөн иргэний харьяалалгүй иргэд ч өөрийн эрх, эрх чөлөөв Үндсэн хуулиар хамгаалуулах тухай" дурдажээ.

ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхэд бие хүмүүс, иргэний төлөвлөгөч, өмгөөлөгч, тусгай эрхт хүмүүс өөрийн гомдлын дагуу хандаж болно. Мен иргэдийн нэгдэл ч өөрдийн нэгдмэл эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл хандах эрх нээлттэй. Иргэд Үндсэн хуулийн шүүхдээз хандахдаа тухайн асуудлаар эрх зүйн хамгааллын бүх хэрэгслээр дамжих, түүнийг ашиглах шаардлагагүй. Өөрөөр хэлбэл Үндсэн хуулиар олгогдсон эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхийн бүх шатны байгууллагаар дамжих шаардлагагүй гэсэн үт юм.

Үндсэн хуулийн тайлбарыг хянан шийдвэрлэх тухай

ОХУ-ын Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлд Үндсэн хуулийн шүүхийн хууль санаачлах эрхийг хуульчилсан байдал.

Ерөнхийлөгч, Холбооны зөвлөл, Төрийн Дум, Холбооны Засгийн газар болон тэр засгийн субъектүүдийн байгууллагууд Үндсэн хуулийн шүүхэд Үндсэн хуульд албан ёсны тайлбар гаргуулахаар хандах эрхтэй.

Үндсэн хуулийн тайлбар болон түүний ач холбогдлыг Үндсэн хуулийн шүүхийн бүгд хуралдаанаар тодорхойлох бөгөөд энэхүү тайлбарыг нийт шүүгчдийн гуравны хоёрөс илүүгүй олонхийн санаалаар батална.

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

АНГЛИ-САКСОНЫ ЭРХ ЗҮЙ ДЭХ ХӨРӨНГИЙН БАРЬЦААНЫ ОЙЛГОЛТ, ТӨРӨЛ, БАТАЛГААЖУУЛАЛТ

ХЗҮТ-ийн Иргэний хууль тогтоомжийн
секторын ЭША, магистр Ж. Баттуяа

Барьцаа ба барьцааны эрх

Австралийн хууль зүйн сургалтад зориулсан "Санхүү болон Барьцааны" сурах бичигт "Барьцаа нь хэлцэл биш, хэлцэлээс үүсч байгаа ашиг сонирхол, эрхийн хуримтлал юм". Барьцааны эрх нь эд юмс өмчлөлд бүрэн шилжих гэдэг утгаар бус, харин хувь этгээд төдийгүй эд юмс руу хандсан эрхийг агуулж буй утгаараа өмчийн шинжлэй байдаг гэжээ.

Гэрээнээс үүсэх хувийн эрхийн хувьд хуулийн дагуу гаргасан нэхэмжлэлийн үндсэн дээр шүүхийн шийдвэрээр төлбөр төлөгчийн хөрөнгөн /asset/ дээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа эхлэхээс өмнө эд хөрөнгийн аливаа эрх үүсдэггүй бол төлбөр төлөгчийн хөрөнгийг барьцаалнаар үргийн гүйцэтгэл хангагдахгүй нэхцэлд үүргүй гүйцэтгүүлэгч эд хөрөнгийг худалдах буюу бусад аргаар шаардлагаа "шууд" хангуулах эрхтэй болох юм.

Тэгэхээр барьцааны ойлголт нь нэгдүүгээрт, барьцаалсан хөрөнгө, эд юмсаар шаардлагаа хангуулах эрхийг агуулдаг бөгөөд тухайн эд юмс, хөрөнгийн өмчлөл веерчлэгдсөн ч энэхүү эрх хадгалагддаг байна¹.

Хоёрдугаарт, барьцааны эрх нь гэрээнээс үүсэх хувийн эрх болон өмчлөх эрхийн хэрэгжилтийн ялгаа заагийг арилгах үр дагавартай. Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгч дамжуурахад хөрөнгө барьцаалаагүй зээлдүүлэгчид түүний хөрөнгөнөөс ногдох хувь хэмжээ бусад зээлдүүлэгчийнхтэй адил байна. Харин тодорхой хөрөнгө барьцаалсан бол бусдын өр бүрэн төлөгчдэх эсэхээс үл хамаарч өөр ногдох төлбөрөө тухайн хөрөнгөнөөс гаргуулан авна. Эд юмс буюу хөрөнгө барьцаалах гурав дахь практик шалтгаан нь барьцаалагч шүүхэд хандажуүлэгч эд хөрөнгийг зээмдэх эрхээ /access to property/ бусад эрхийнхээ хамт хэрэгжүүлэх боломжтой болдог байна.

Нийтлэг эрх зүйд барьцааны эрх дараах арга замаар үүсдээ:

- Эд юмс, хөрөнгийн өмчлөл буюу бодит эзэмшлийг шилжүүлэх
- Эд юмс, хөрөнгө барьцаалах тухай гэрээний заалтыг шүүхийн журмаар хэрэгжүүлэх
- Худалдах үнэ төлөгтэл худалдагч/зээлдүүлэгч/ эд хөрөнгийн өмчлөх эрхийг хадгалах
- Өмчлөх эрхийг шилжүүлэхгүйгээр эд юмс, хөрөнгийн эзэмшлийг шилжүүлэх

¹ Sykes, E., and Walker, S., 1993, *The Law of Securities*, 5th ed, Law Book Co, Sydney, pp 3-4.

² Барьцааны эрх үүссэндийг мэдэгүйгээр хөрөнгө, эд юмсыг худалдан авсан гэмгүй худалдан авччийн ашиг сонирхол энэхүү эрхийг үгүйгэнэ.

Хүчин төгөлдөр барьцааны эрх үүсэх, үүссэн гэж тооцох зарчмын хувьд нийтлэг эрх зүй болон шударга ёсны эрх зүй ялгаатай байр суурь баримталаад. Тухайлбал, барьцааны агуулгатай гэрээ, хэлцлийн хувьд хөрөнгийн өмчлөл буюу эзэмшил заавал шилжих тухай ойлголт шударга ёсны эрх зүйд байдаггүй³.

Тэрчлэн зээл авахад эд хөрөнгө барьцаалуулах тухай амаар хийсэн хэлцлийн хувьд гэрээг өргөлжүүлэх хуулийн шаардлага хангдаагүй ч тухайн уургийн гүйцэтгэлийг хангахыг /specific performance/ шударга ёсны эрх зүйд шаардана. Амлалтгүй “үндэстний төлөө” егсен л бол хэрэгжих ёстой гэж шударга ёсны эрх зүйд үздэг. Харин *Нийтлэг эрх зүйд хөрөнгийн барьцаалуулах амлалт /өмчлөх эрх буюу эзэмшил шилжээгүй/ биелэгдээгүй тохиолдолд зээлдүүлэгч гэрээнээс үүсэх эрхээс хэрэгжүүлэхээр шүүхэд хандах ёстой.*

Гэрээ зерчсэнээс учирсан хохирлоо төлүүлээд өнгөрөх нь тухайн зээлдүүлэгчийн хувьд үүргээ гүйцэтгэгүй төлбөр төвлөгчийн эд хөрөнгөөр шаардлагагаа хангуулах бусад зээлдүүлэгчийн өрсөлдөөн бий болоход эрх зүйн хангалттай хамгаалалт болохгүй нь ойлгомжтой. Иймээс Шударга ёсны эрх зүйд тодорхой хөрөнгө барьцаалахаар тохирч зээл олгосон бол энэхүү тохиолцоогоор хүчин төгөлдөр барьцааны эрх үүссэн гэж үздэг.

Шударга ёсны эрх зүйд барьцааны гэрээ хийх үед байхгүй байгаа буюу барьцаалуулагчийн өмчлөл буюу эзэмшилд байхгүй байгаа барьцааны зүйлийн⁴ хувьд үүссэн барьцааны эрхийг хүчин төгөлдөр гэж тооцдог. Үндэстний төлөө хийсэн амлалт хэрэгжих ёстой гэсэн зарчим энэ тохиолдолд нэгэн адил үйлчилнэ.

Барьцааны төрөл, түүний шинж

1. Хуулийн дагуу үүсэх барьцаа /Legal mortgage/

Хуулийн дагуу үүсэх барьцааны эрхийн хувьд барьцаалсан хөрөнгийн хууль ёсны өмчлөл бүрэн шилжинэ. Гэхдээ, шударга ёсны эрх зүйн зарчмын дагуу мөнгөн төлбөрийг төлж өмчлөх эрхээ сэргээх эрх гэрээнд заасан хугацаа өнгөрсөн ч хэрэгжих ёстой байдаг.

2. Шударга ёсны эрх зүйн дагуу үүсэх барьцаа /Equitable mortgage/

Шударга ёсны эрх зүйн дагуу үүсэх барьцааны хувьд хөрөнгийн хууль ёсны өмчлөгч, итгэмжлэлийн үндсэн дээр хөрөнгийг захиран зарцуулах этгээд буюу анхны барьцаалагчид хадгалагдана. Өөрөөр хэлбэл, зөвхөн шударга ёсны эрх зүйн зарчмаар хүлээн зөвшөөрсөн өмчлөх эрх /анхны барьцааны дараа буцаан авсан өмчлөх эрх буюу итгэмжлэлийн дагуу ашиг хүртэгч этгээдийн хөрөнгийн ашиг сонирхол/ буюу мөнгөн төлбөрийн үүргийн барьцаанд аливаа төрлийн хөрөнгийн эрх олгох тохиолцоог хэлнэ⁵.

³ McCracken, S., and Everett, D., 1998, *Finance and Security Law*, Butterworths, p 361.

⁴ Малын ноос, нооптур, үр тариа үүнд хамаарах бөгөөд тэдгээрийг барьцаалах журмыг Австралийд хууль тогтоогоочоос гаргасан эрх зүйн актвар зохицуулдаг.

⁵ McCracken, S., and Everett, D., 1998, *Finance and Security Law*, Butterworths, p 386.

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

3. Гэрээний дагуу үүсэх барьцаа /Charge/

Зээлдүүлэхгээр үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөрөнгийг ашиглах үүргийг гэрээгээр хүлээлгэдэг, үүргийн гүйцэтгэл хангагдаагүй тохиолдолд барьцаалсан хөрөнгөнөөс шүүхийн журмаар шаардлагасаа хангуулах эрхийг агуулсан барьцааны төрөл⁶. Энэ төрлийн барьцаагаар эмчийн эрх үүсдэг эсэх талаар ихээхэн маргаантай байдаг. Үүргийн гүйцэтгэлийг шүүхийн журмаар хангуулах хөрөнгийг худалдаа буюу хүлээн авчг томилох/ эрхийг үүрэг гүйцэтгүүлэгчид одоо хадгалагдаж байгаа эрх болохоос ирэздүйд үүсэх эрх гэж үздэггүй байна.

Гэрээний дагуу үүсэх барьцаа дотор нь:

1. тусгайлсан эд хөрөнгийн барьцаа
2. хөвөх эд хөрөнгийн барьцаа гэж ангилаад байна.

Тусгайлсан эд хөрөнгийн барьцааны тухайд барьцааны эрх тусгайлан барьцаалсан тодорхой эд хөрөнгийн хувьд хэрэгжих ба тэдээр хөрөнгийг нэг талын хүсэл зорилгоор гуравдагч этгээдийн тусын тулд ашиглаж болохгүй юм. Хөвөх эд хөрөнгийн барьцааны хувьд компаниас барьцаанд тавьсан одоо байгаа болон бий болох хөрөнгөе компанийн бизнесийн ердийн үйл ажиллагааны туршид өөрчлөгдж болно. Өөрөөр хэлбэл, компани татан буугдах, худалдаа арилжкаа эрхлэжээ болих хүртэл барьцаалсан хөрөнгөе чөлөөтэй захиран зарцуулах эрхтэй байдаг байна.

4. Эзэмшил шилжсэнээр үүсэх барьцаа /Security by possession/

Талуудын бодит хүсэл зоригтоос ул шалтгаалж, эрх зүйн зарчмын дагуу үүсдэг барьцааны эрх буюу төлбөр төлөгдтэл эд хөрөнгийг эзэмшилдээ байгалах эрх /lien/, түүнчлэн санхүүжилт авах зорилгоор эзэмшилдээ буй эд хөрөнгийг зөвшөөрлийн үндсэн дээр барьцаалахыг /pledge/ энэ төрлийн барьцаанд хамааруулан ойлгоно. Зөвшөөрлийн үндсэн дээр хийгдэх хэлчлийн /pledge/ хувьд үүргийн гүйцэтгэл хангагдаагүй тохиолдолд барьцаалсан эд хөрөнгийг худалдаа эрхийг нийтлэг эрх зүйн шүүх хүлээн зөвшөөрхөн хандлагатай байдаг. Үүргийн гүйцэтгэл хангагдтай эд хөрөнгийг үүргэгдэж тохиролцож болох ба ийм гэрээг биет бус хөрөнгө, банкнаас харилцагчид төлөх өрийн /хадгаламж/ хувьд хэрэглэж болохгүй юм.

Талуудын тохиролцоонд үндэслэж үүсдэггүй барьцааны эрхийн /lien/ хувьд эд хөрөнгийг худалдаа эрх үүсдэггүй бөгөөд нийтлэг эрх зүйд энэ төрлийн барьцаа нь зочид буудал, тээврийн үйлчилгээ эрхлэгчид, эд юмс засварлагчдын хувьд зөвхөн байрлуулсан, тээвэрлэсэн, засварласны төлөөх төлбөрийн гүйцэтгэлийг хангахад чиглэдэг.

5. Ерөнхий барьцаа /General liens/

"Арилжкаа эрхлэгчдийн дунд тогтсон заншил" гэж шүүхээс хүлээн зөвшөөрдөг эзэмшилээр үүсэх ерөнхий барьцааны эрх гэж байдаг. Энэ нь эзэмшилд авсан ба барьцаанд тавьсан эд хөрөнгөтэй холбоогүйгээр үүссэн бусад үүргийн гүйцэтгэл хангагдтал барьцаалсан эд хөрөнгийг

⁶ дээр, хуудас 388, 428, 430.

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

эзэмшилдээ байлагхыг хэлж байгаа юм. Ерөнхий барьцааг банкирууд, өмгээлэгчид, хөрөнгийн болон даатгалын брокерүүд өргөн хэрэглэдэг байна.⁷ Барах хадгалагчийн хувьд хадгалалтын хэлс дээр зөвж тээвэрлэсний хэлс нэмэгдэж төлгөдөнө. Ерөнхий барьцааны эрх үүссэн эсэхийг тогтооход шүүгчээс нотолгооны өндөр стандарт шаардлаг төдийгүй энэ нь бусад зээлдүүлэгчийн хувьд хохиролтой байдаг байна. Барьцааны төрлүүд нь концепцийн хувьд ийм ялгаатай ч тэдгээрийн талаархи эрх зүйн зохицуулалтын хандлага адил байдаг байна.

Биет бус хөрөнгийн барьцаа

A. Хувьцаа, ерийн үнэт цаас

Үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хувьцаа болон ерийн үнэт цаасыг барьцаалах явдал Австралид 15 жилийн өмнөөс практикт нэвтэрсон байна. Тэдгээр нь гэрчлүүлсан хэлбэрээр болон барьцаагаар хангагчийн нэр дээр бүртгэгдсэн, эсхүл өөр этгээдэд бүрэн шилжүүлж болох нехцэл заахгүйгээр төлбөр хийх баримтын /bearer negotiable instruments/ хэлбэртэй байдаг.⁸ Хувьцаа, ерийн үнэт цаасанд барьцааны уламжлалт хэлбэрүүд болох хууль буюу шударга ёсны эрх зүйн дагуу болон гэрээний дагуу барьцаалах, эсхүл худалдах эрхтэйгээр эзэмшилд шилжүүлэх аргаар барьцааны эрх үүсгэж болно.

Барьцааны эрх үүсч болох биет бус хөрөнгөнд /intangible property/:

- Хувьцаа
- Ерийн үнэт цаас /debentures-компаний өрөнхий кредитийн хэмжээгээр гаргасан/
- чек /bills of exchange/
- бонд
- хувьцаа, үнэт цаасыг одоо тогтоосон үнээр ирээдүйн тодорхой өдөр худалдах буюу согилцох тухай гэрээ /futures contracts/
- нехцэл заахгүйгээр төлбөр хийхийг амалсан буюу даалгасан бусад төлбөрийн баримт /promissory notes and derivatives/

Эдгээрээс гадна Австралийн Хөрөнгийн биржийн Клерингийн төвийн Электрон бүртгэлийн систем /CHESS/, Нөөцийн Банкны Мэдээлэл, Шилжүүлгийн Системд /RITS/, ерийн үнэт цаас гаргагч буюу түүний өмнөөс бүртгэл явуулах этгээд дээр хувьцаа, үнэт цаас эзэмшигчийн нэр, эсхүл барьцаалагчийн нэр дээр гэрчлүүлээгүй хэлбэрээр бүртгэгдсэн байдаг. Хувьцаа, үнэт цаас гаргагч, барьцаагаар хангагч, зээлдүүлэгч, бүртгэгч, томилогдсон буюу хянан харгалзах этгээдүүд нь гадны хүмүүс байдагтай холбоотойгоор шинээр нэвтэрсэн эдгэр арга нь эрх зүйн хувьд олон янзын хүндэрлүүд үүсгэдэг байна⁹.

B. Зээлдүүлэгч үүрээз барьцаалах

Банкны харилцагч тухайн банкин дахь дансны үлдэгдлээ барьцаалж зээл авах нь олонтаа байна. Энэ нь барьцааны эрхийг жинхэнэ утгаар

⁷ Дээр, хуудас 479.

⁸ дээр, хуудас 534

⁹ дээр, хуудас 534

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

үүсгэж байгаа эсэх нь маргаантай байдаг. Английн шүүхээр шийдэгдсэн нэгэн хэрэгт¹⁰ шүүг Millett J "аливаа этгээд бусдад төлөх үүрэг буюу ерендэе өмчийн эрх үүсгэж чадахгүй бөгөөд энэ нь концепцийн хувьд боломжгүй зүйл"¹¹ гэсэн байна. Шүүгчийн энэхүү санааг илт дэмжигч Профессор Goode¹² "Өр нь зээлдүүлэгч болон өрийг шилжүүлэн авсан гуравдагч этгээдийн хувьд өмчлөлийн зүйл. Харин зээлдүүлэгч, төлбөр төлөгч хоёрын хувьд цэвэр үүрэг" гэжээ.

B. Нехөрлөлийн эрхийг барьцаалах

Нехөрлөлийн эрх гэдэг нь бухэлд нь буюу зарим хэсгийг нь шилжүүлийн болох нехөрлөлийн гишүүнд төлөх өр буюу эд хөрөнгийн эрх /choose in action/ байна.¹³ Нехөрлөлийн гишүүн нь нехөрлөлийн тодорхой эд хөрөнгийг өмчлөх эрхгүй ч түүний өмчлөлийн аливаа эд хөрөнгийн хувьд ашиг хүртэх эрхтэй. Нехөрлөлийн хөрөнгөнөөс гишүүнд ногдох хувь нь нехөрлөлийн хөрөнгөөр өр, бусад үүргийн гүйцэтгэлийг хангасны дараа үлдэх хөрөнгөс хувь хүртэх эрх юм. Өөрөөр хэлбэл нехөрлөлийн эрхийг шилжүүлэн авсан буюу барьцаалсан этгээдэд ногдох хөрөнгийн хувь хэмжээс нехөрлөл татан буугдахад тодорхой болно.

C. Оюуны өмчийн эрхийн барьцаа

a. Зохиогчийн эрхийн барьцаа

Зохиогчийн эрх, патент, бараганы тэмдэг болон баараа, бүттээгдэхүүний загвар нь биет бус хөрөнгийн барьцааны чухал хэлбэрүүд төдийгүй Австралийн Үндсэн хуулийн 51(xviii) дүгээр зүйлийн дагуу эдгээртэй холбогдох хуулийн зохицуулалт Холбооны түвшинд хийгдэх ёстай. Зохиогчийн эрхийн хуулийн дагуу¹⁴ эрх шилжүүлэх үед байгаагүй зохиогчийн эрхийг шилжүүлж болох бөгөөд түүнийг бий болсоор барьцааны эрх үүснэ. Энэ боломжийн хажуугаар зохиогчийн эрхийг барьцаалахад хэд хэдэн практик хүндэр гардаг. Зохиогчийн эрхийг барьцаалахаас өмнө буюу хийн үүссэн лицензийн эрх барьцаалагчийн хувьд /chargee/ хүчинтэй хэвээр үлдэгээ тул барьцааны зүйлийн уна буурах асуудал гарна.¹⁵ Үүнээс зайлсхийн нэг арга нь барьцаалагч зохиогчийн эрхийг өмчлөх эрх буюу лицензийн эрхэд харшилсан үйл ажиллагааны талаар баталгаа гаргуулах явдал юм. Харамсалтай нь энэхүү баталгааны зорчил барьцаагаар хангагдах үе буюу зээлдэгч дамжуурах үед илрэх нь олон байна. Иймээс баталгаа зорчсноөөс учирсан хохирлоо төлүүлэх нэхэмжлэл үр ашигтүй болох талтай байдаг.¹⁶

Лицензийг цаашид зөвшөөрөлгүй олгохос хамгаалах нэг арга нь зохиогчийн эрхийг өмчлөх эрхийг холбогдох бусад эрх, түүний дотор лиценз олгох эрхийн хамт шилжүүлэн авах явдал юм. Лиценз олгох нь эрхээс барьцаалагч этгээдийн бизнес бол лиценз авагчид уг эрхийн өмчлөгчтэй харьцах нь мэдээж. Чингэх нь барьцаагаар хангагчийн

¹⁰ Re Carge Card Services Ltd (1986) 3 ALL ER 289

¹¹ McCracken, S., and Everett, D., 1998, *Finance and Security Law*, Butterworths, pp 554-555

¹² Goode, 1988, *Legal problems of credit and security*, 2nd ed, Sweet and Maxwell, p 125

¹³ McCracken, S., and Everett, D., 1998, *Finance and Security Law*, Butterworths, pp 572, 574

¹⁴ Copyright Act 1968, section 197(1).

¹⁵ McCracken, S., and Everett, D., 1998, *Finance and Security Law*, Butterworths, p 580

¹⁶ дээр, хуудас 581

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

бизнесийн боломжийг хааж байгаас учраас арилжааны талаасаа хүлээн зөвшөөрдөгдхүй юм.¹⁷ Өөр нэг хүндэрэл бол зохиогийн эрхийн өмчлөх эрхийг лицензийн эрхийн хамт барьцаалах нь гуравдагч этгээдийн зохиогийн эрхийг барьцааны зүйл болох бүтээл зөрчвэл лиценз олгосон барьцаалагч дээрх эрхийг зөрчих зөвшөөрөл олгосонд тооцогдсон хариуцлага хүлээж болох юм.

б. Патентын барьцаа

Патентын тухай хуулиар¹⁸ патентад өмчлөх эрх, лицензийн болон бусад эрх үүсч¹⁹ болох тухай зааж дээрх эрхийг бүртгүүлэхийг шаардсан. Патентын журамд²⁰ "бүртгүүлэх хүснэгт гаргаж байгаа этгээд холбогдох эрхээ нотлох ёстой" гэсэн нь бүртгэлд орсноор өмчлөх эрх үүсахгүй, харин хүснэгт гаргахад эрх бий болсон байна гэсэн уг.²¹ Хоёулаа бүртгүүлээгүй патентын барьцааны эрхийн хувьд сүүлд үүссэн эрх нь давамгтайлагдаг байна.

в. Барааны тэмдгийн барьцаа

1995 оны Барааны тэмдгийн хуулиар бүртгэлтэй барааны тэмдгийг хувийн хөрөнгөнд тооцох тухай тодорхой заасан. Гэхдээ, барааны тэмдгийг бүртгэлээс хасах хад хэдэн тохиолдол байдаг.²²

1. Барааны тэмдгийг тасралтгүй 3 жил ашиглаагүй бол
2. Анхны бүртгэл доголдолтой бол
3. Анхны бүртгэл доголдолгүй ч барааны тэмдэг өмчлөгчийн хайрамжгүй байдал, зохиж ёсны арга хэмжээ аваагүйгээс болж өмчлөгч бус этгээд барааны тэмдгийг зөвшөөрөлгүй ашиглах олон нийт тухайн буюу түүнтэй төстэй барааны тэмдгийг уул хэрэглэгчтэй холбож уздаг болсон. Барааны тэмдэг нь өмчийн ийм эмзэг хэлбэр учраас түүнийг барьцаалах практик ач холбогдол бага байдаг.

Барьцааны эрхийн баталгаажуулалт

Барьцааны гэрээ нь тухайн гэрээний тал бус гуравдагч этгээдийн эрхэд сергеер нелөөлөх талтай. Учир нь үүрэг гүйцэтгэч барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр хөрөнгийн эрхийг гуравдагч этгээдэд шилжүүлэлээ гэхэд барьцаалагч түүнийг гуравдагч этгээдээс гаргуулан авах эрхтэй байдаг. /Худалдан авагч буюу бусад сонирхогч этгээд эд юмс буюу хөрөнгөнд барьцааны эрх үүссэн эсэхийг мэдэх механизмыг байхгүй бол ийм үр дүн нь шударга бус юм. Түүхийн хувьд, барьцааны гэрээг дагалдаж эд юмсын бодит эзэмшил шилжээгүй бол шүүх гэрээг хуурамч гэж үзэн хүчингүй болгодог байсан бөгөөд барьцаалсан хөрөнгийг улсын бүртгэлд бүртгүүлэх хуулийн шаардлага бий болсноор энэ асуудал шийдвэгдсэн байна.

Канад улсын бараг бүх мужид хувийн хөрөнгийн барьцааны тухай тусгай хуультай. 1990 онд батлагдсан Алберта мужийн Хувийн хөрөнгийн барьцааны тухай хуулинд²³ /Personal Property Security Act/ хөрөнгийн

¹⁷ дээр, хуудас 581

¹⁸ Patents Act 1990

¹⁹ Patents Act 1990, sections 103 (1) and 187

²⁰ Patents Regulations, Regulation 19.1(1)(c)

²¹ McCracken, S., and Everett, D., 1998, *Finance and Security Law*, Butterworths, p 582

²² дээр, хуудас 585-586

²³ Тус хуули нь АНУ-ын Арилжийн нээлдсэн хуулийн 9 дүгээр заалтад үндэслэсэн.

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

барьцааны эрхийг баталгаажуулах журам, энэхүү журмын ўйлчлэлээр тэргүүн ээлжинд шаардлагагаа хангуулах барьцаалагчийн эрх хэрхэн хэрэгжих талаар дэлгэрэнгүй зохицуулсан.²⁴ Уг хуулиар барьцааны эрхийг баталгаажуулах дараах 3 аргыг хулзэн зөвшөөрсөн:

1. Бүртгэл
2. Хөрөнгийн эзэмшил
3. Түр баталгаажуулалт

Барьцааны эрхийг бүртгэлээр баталгаажуулах ✓

Хувийн хөрөнгийн барьцааны хуулийн 25 дугаар зүйлд барьцааны эрхийг бүртгэлээр баталгаажуулах тухай заасан. Энэ арга нь бүх төрлийн хөрөнгийн барьцаанд хэрэглэгдэх хамгийн түгээмэл арга юм. Хөрөнгөнд үүссэн барьцааны эрхийг бүртгүүлснээр үүрэг гүйцэтгэх барьцааны зүйлийг эзэмшилдээ байлан ашиглах боломжтой байдаа. Хуулийн фирмүүд болон санхүүгийн байгуулагууд электрон бүртгэлийн аргаар "санхүүгийн мэдэгдлээ" бүртгүүлдэг байна. Хоёулаа барьцааны эрхээр хангагдсан талуудын хувьд хэн туруулж баталгаажуулах алхам²⁵ хийсэн байна түүний шаардлагагаа туруулж хангагдана гэсэн уг.

Барьцааны эрхийг эзэмшилээр баталгаажуулах

Хуулийн 24 дүгээр зүйлд зааснаар биет бус хөрөнгөес бусад бүх төрлийн хөрөнгийн барьцаанд энэ аргыг хэрэглэж болно. Хөрөнгийн эзэмшил заавал барьцаалагчид шилжих шаардлагагүй бөгөөд түүний өмнөөс таравдагч этгээдэд шилжиж болно. Цаг хугацааны хувьд баталгаажуулалтыг барьцааны эрх үүсэхээс өмнө болон барьцааны эрх үүссэнээс хойш хийж болно²⁶. Жишээ нь: Зээлдээг 5 дугаар сарын 1-нд хувьцааны эрхийн бичээс зээлийн барьцаанд өөч зээлдүүлэгчийн эзэмшилд шилжүүлсэн бөгөөд 5 дундаж сарын 15 хуртгал санхүүжилт хийгдээгүй байсан бол энэ тохиолдолд баталгаажуулах алхам 1-нд хийдэсэн. Барьцааны эрх нь 15-нд услээ гэж бодоход энэхүү барьцааны эрхийн хувьд "баталгаажилтгүй байсан үе" байхгүй гэсэн уг.

Барьцааны эрхийг үүссэнээс хойш баталгаажуулахад "баталгаажилтгүй хугацаа" гарах бөгөөд энэ тохиолдолд шаардлагагаа тэргүүн эзлжинд хангуулах эрхээ алдаа эрсдэлтэй байдаг.

Түр баталгаажуулалт

Эзэмшил буюу бүртгэлээр баталгаажаагүй барьцааны эрхийн хувьд түр баталгаажилтыг хэрэглэх бөгөөд энэ баталгаажилт нь бусад барьцаалагчид болон төлбөр төлөгчийн дамжуурлын хэрэг гүйцэтгэгчийн эрхэнд захирагдахгүй. Энэ төрлийн баталгаажуулалтыг үүрэг гүйцэтгүүлэгч гардан хийдэгтүй, харин хуулиар тодорхой төрлийн барьцааны зүйлүүдийн хувьд богино хугацаа зааж өгсөн байдаг. Жишээ: А, Б-гээс нэгэн компанийн хувьцааг нь барьцаалж, эрхийн бичгийг нь эзэмшилдээ авсан бөгөөд Б өөр компанийн хувьцааг авах зорилгоор барьцаалсан

²⁴ Дээрх хууль зөвхөн гарзсонд дагуу буюу зөвшөөрлийн үндсэн дээр бий болох барьцааны баталгаажуулалтад хамаарна.

²⁵ Section 35(1), Personal Property Act 1990, Alberta

²⁶ дээр, section 19.

ИРГЭНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

хувьцаагаа худалдахыг хүссэн. Тэгэхээр Б-ийн шинэ хувьцаа эзэмшилд нь шилжинэ гэсэн ойлолтоор А хувьцааны эрхийн бичгийг 5 дугаар сарын 10-ныэс эзэмшилээсээ гаргасан.

Хуулийн 26.1 дутгаар зүйлд хедлех хөрөнгийг төлбөр төлөгч хяналтандыа авсанас хойш 15 хоногийн дараа барьцааны эрх түр баталгаажих тухай заасан. Тэгэхээр эхний компани 5 дугаар сарын 20-нд дампуурлаа гэхэд А-гийн барьцааны эрх баталгаажсан статустай байх учраас дампуурлын хэрэг гүйцэтгэлийн дараалалд захирагдахгүй. Барьцааны эрхийг 1-25 жилийн хугацаатай буюу хугацаагүйгээр баталгаажуулж болно. Хугацаа уртсах тусам хураамж нэмэгддэг учраас бүртгэлд аль болох далгэрэнгүй, олон мэдээлэл оруулах нь ашигтай байдаг.

Барьцааны эрхийг баталгаажуулаагүйн үр дагавар

Алберта мужийн Хувийн хөрөнгийн барьцааны тухай хуулинд баталгаажуулаагүй барьцааны эрх нь үүрэг гүйцэтгэгчийн бизнес дампуураад дампуурлын хэрэг гүйцэтгэгчийн өр барагдуулах дэс дараалал болон тухайн хөрөнгө "барьцаалагдсаныг мэдэхгүйгээр", "үнэ өртгөөр" өмчлөлдөө авсан этгээдийн эрхэнд захирагдана"²⁷ гэж зааэж. Дээрх заалтын барьцааны эрхийг баталгаажуулаагүй үед эд хөрөнгөөр этгээдэд бэлзгэсэн бол, түүнчлэн хөрөнгө шилжүүлж авсан этгээд барьцааны эрх үүссэн тухай мэдэж байгаа бол үйлчлэхгүй гэж ойлгож болно. Үүнээс гадна, Алберта мужийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн хуулинд хедлех хөрөнгийг хураах шүүхийн шийдвэрийг гүйцэтгээс өмнө барьцаалагч эрхээ баталгаажуулах алхам хийгээж бол барьцааны эрх шүүхийн шийдвэр гүйцэтгэд захирагдана²⁸ гэжээ. Шийдвэр гүйцэтгэл нь шийдвэр "бүртгэгдсэнээр" хүчинтэй болно гэж заасан. Дээрх хуулийн дагуу "бүртгэгдсэн шүүхийн шийдвэр" нь үүнээс хойш үүссэн "худалдан авах мөнгөний барьцааны эрхэнд" /purchase money security interest/ захирагддаг. Гэхдээ төлбөр төлөгч хедлех хөрөнгийг эзэмшилдээ авсанас хойш 15 хоногийн дотор барьцааны эрхийг баталгаажуулсан байх ёстой байна.

Тэргүүн ээлжинд шаардлагаа хангуулах ерөнхий журам

Барьцааны эрх бүхий хоёр этгээдийн хэнийх нь шаардлага түрүүлж хангагдах нь эрх үүссэн болон эрх баталгаажсан цаг хугацаанд үндасладгүй, харин хэн нь түрүүлж "баталгаажуулах алхам" хийснээс шалтгаалдаг байна. Жишиг: А 7 сарын 10-нд санхуужилтийн мэдээлэлээ бүртгаалуулжээ Б-а үүрэг гүйцэтгэвээгээз барьцаалсан хөрөнгийг тодорхойлсон байна. Б ээлийн хүснэгтээ 7 сарын 1-нд гаргасан ба 8 сарын 15 хүртэл барьцааны гэрээнд гарын үсээз зураагүй байна. Энэ хооронд Б Г-ээс зээл авч, барьцааны эрх нь 7 сарын 25-нд үүссэн ба 7 сарын 30-нд Г санхуужилтийн мэдээлэлээ бүртгаулсан. Дээрх тохиолдолд Г-д барьцааны эрх түрүүлж үүссэн төдийгүй эрх нь түрүүлж баталгаажсан. Гэвч, хуулийн 35.1-т зааснаар баталгаажуулах алхмыг А түрүүлж хийсэн учраас шаардлагаа түрүүлж хангуулна гэсэн үг.

²⁷ дээр, Section 20

²⁸ Section 35, Civil Enforcement Act, Alberta

Дээрх журам үйлчлэхгүй тохиолдол

1. Хөрөнгийн бүртгэлийн хүчинтэй хугацаа өнгөрсөн буюу бүртгэлээс гарсан тохиолдолд тэргүүн зэлжинд шаардлага хангуулах эрхээ алдана. Энэ тохиолдолд нэг хөрөнгө барьцаалсан хоёр этгээдийн хувьд түрүүлж бүртгүүлсэн нь дахин зээл олгоходо шинээр бүртгүүлэх бус харин өмнөх бүртгэлээ хугацаа дуусахаас өмнө сунгах нь өөр барьцаалагчид байраав тавихаас сэргийлж юм.

2. Тэргүүн зэлжинд шаардлага хангах дээрх өрөнхий журам үйлчлэхгүй барьцааны эрх бол "худалдан авах мөнгөний барьцааны эрх" /purchase money security interest/ ба энэ терлийн барьцааны эрхийн хувьд шаардлага нэн түрүүнд²⁹ /super priority/ хангагддаг байна. Ийм барьцааны эрх үүсдэг хэлцлүүдэд³⁰:

- Худалдагчаас төлгөдөөгүй мөнгөний барьцаанд худалдсан эд хөрөнгө, хөрөнгийн эрхээ барьцаалах "зээлээр худалдах гэрээ"
- Шинээр хөрөнгө бий болгох зорилгоор төлбөр төлгөчид зээл олгосон, зээл энэ зорилгоор ашиглагдсан³¹ бөгөөд бий болох хөрөнгийг барьцаалсан /ур, бордоо авах, малын тэжээл, эм тариа/
- 1-ээс дээш жилийн хугацаатай түрээсийн гэрээ
- Худалдааны тээвэрлэлтийн гэрээ орох юм.

²⁹ Section 34, Personal Property Security Act 1990, Alberta

³⁰ дээр, section 1(1)(ii).

³¹ дээр, sections 34(9) and 34(10).

ЧЕЛЕӨӨТ БУСИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН
ЗАРИМ АСУУДАЛ

Олон улсын эрх зүйч М.Энх-Амгалан

Улс орнуудын здийн засгийн харилцаа улам бүр хоорондоо хамааралтай (interdependence) болж байгаа энэ үед Монгол Улс ч гэсан өөрийн орны онцлогтой уялдуулан здийн засгийн хувьд харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар "Челеөөт бүс"-ийг эх орондоо байгуулах нь цаг үеэ олсон, здийн засгийн болоод эрх зүйн хөгжилд хувь нэмэрээ оруулах зүйл юм.

"Челеөөт бүс" гэдэг нь хөрөнгө оруулалтыг татах арга, механизмуудыг ашиглах замаар тухайн бүс нутгийн хөгжлийг хангаж улмаар тухайн улсын нийт здийн засгийн чадавхи, багтаамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц харилцаа юм" хэмээн тодорхойлж болно. Челеөөт бусийг төрөл, чиглэлээс нь хамаараад ерөнхий зорилтот бүс, тусгай зорилтот дэд бүс хэмээн аngilдаг юм байна.

Өнөөдөр дэлхий дээр нийтдээ 80 гаруй улсад хэдэн зуун челеөөт бүс ажиллах байна. Эдээр улсууд өөрсдийн орны онцлог болон бусад хүчин зүйлээ анхааран здийн засгийн челеөөт бусийг байгуулахын зэрэгцээ нийт улс орныхоо хэмжээнд хэрглэж ул болох тийм тийм эрх зүйн хэм хэмжээнүүдийг тэрхүү сонгосон бусууддээ хэрэглэж үр дүнд хүрч байна. Челеөөт бусийн байршилыг сонгох нь тухайн улсын хувьд стратегийн чухал сонголт бөгөөд дараах 2 чиглэлээр байгуулж байна. Үүнд:

1. Аливаа улсууд өөрийн хамгийн ашигтай байрлалд байгаа бүс нутгийг челеөөт бүс болгох, тэр бүс нутгаа түшиглэн улс орноо хөгжүүлэх, здийн засгийнхаа вселтийг хангах;
2. Газар нутгийнхаа хамгийн хөгжил муутай газраа челеөөт бүс болгох замаар тухайн бүс нутгийн хөгжлийг дээшлүүлэх.

Энэ талаар амжилт олж байгаа улс орнууд ихэвчлэн өөрийн газарзүйн байршил, хүн амын няягтрал, үйлдвэрлэлийн төвлөрөл гэх мэт хамгийн тохиромжтой байршилыг челеөөт бүс болгон хөгжүүлсэн байна. Гэхдээ тэдээр орнууд энэ хүчин зүйлсийг зөв ашиглахын хажуугаар эрх зүйн зохицуулалтыг үр дүнтэй, уян хатан, тухайн бусийн онцлог, улсынхаа эрх ашиг нийцүүлсэн байдаг. Ялангуяа Хятад улс хөрөнгө оруулалт орж ирэх таатай боломж бүхий эрх зүйн орчны бурдлуулсан байна. Челеөөт бүс байгуулах асуудал дээр улс орнууд ерөнхийдөө дараах механизмуудыг хэрглэж байна. Үүнд:

- орлогын албан татвараас хэд хэдэн жилийн хугацаагаар чөлөөлдег
- гаалийн татвараас чөлөөлдег
- гадаадын хөрөнгө оруулагчдыг өмчийн болон гүйлгээний татвараас чөлөөлдег
- бүсэд оруулж ирсан эд хөрөнгө, тоног техноремж, машин техник болон түүхий эд зэрэгээс импортын татвар авдаггүй

- газрын түрээсийн төлberийн хэмжээ, хугацааг хөнгөлөлттэй тогтоох валютын үйл ажиллагааг чөлөөт зах зээлийн ханшавар хийх зэрэг механизмууд орж байна.

Манай орны хувьд чөлөөт бус байгуулах хамгийн тохиromжтой газрыг сонгоод уг газраа чөлөөт бус байгуулж, тухайн бус нутгийн хөгжилд түлхэц өгөх замаар нийт эдийн засгийн есслөө хангах нь зүйтэй билээ.

Чөлөөт бус байгуулсаар бидэнд дараах асуудлуудыг шийдвэрлэхэд чухал нелвэ үзүүлэх болно. Үүнд:

- Улс орны экспортын чадавхи, валютын орлого, бус нутгийн хөгжлийн түвшинг нэмэгдүүлэхэд дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;
- Дотоодын болон дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадалтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд туслах давшилтэт техники технологи оруулах;
- Бус нутгийн ажил эрхлэлтийн түвшинг сайжруулах;
- Зах зээл хөгжсөн орнуудын туршлага, маркетингийн соёл, чадварыг нэвтрүүлэх;
- Байгалийн баялаг, ашигт малтмалын неецеэ илрүүлж ашиглах;
- Харилцагч улсуудтайгаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, биеэ биеэ нехех үйлдвэрлэл үйлчилгээний боломжко олох

Хоёр их гүрэнтэй хиллэсэн улс болохынхoo хувьд веийн газар нутаг дээр гуравдагч орны ашиг сонирхлыг бий болгосноор аюулгүй байдал тусгаар тогтолоо баталгаажуулна.

Дээр дурдсан асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэхийн тулд гадаадын хөрөнгө оруулалтын үргслэлийг веийн орондоо чиглүүлэх эрх зүйн таатай орчныг бий болгох ёстой. Эрх зүйн таатай орчныг бий болгоход эн тэргүүнд дараах 3 асуудлыг анхаарах ёстой.

- ❖ Татвар
- ❖ Газар ашиглалт
- ❖ Удирдлага, захиргаа

Чөлөөт бусийн татвар, төлberийн нехцэл нь хөрш орнуудын ижил тэстэй чөлөөт бусуудийн тогтоосон татварын хувь, хэмжээнээс илүү тааламжтай байгаа тохиолдолд л 2 их гүрний дунд оршдог, далайд гарцуулж, зах зээл хязгаарлагдмал, дэд бүтэц тааруу хөгжсөн манай улсад хөрөнгө оруулж чөлөөт бус байгуулах сонирхлыг төрүүлэх болно. Өөрөөр хэлбэл, бид чөлөөт бус байгуулах эхэн уедээ ашиг орлогод "үл шунах зарчим"-ийг баримтлах ёстой. Мен чөлөөт бусад оруулах хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэдээ татвар, төлberийн нехцлүүдээ маш тогтвортой байлгах, тогтоосноосоо дордуулахгүй байх гэсэн зарчим баримтлах ёстой. Гадаадын төдийгүй дотоодын хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт, чөлөөлөлттэнд өргөнөөр хамруулах ёстой болгүүр уу. Хууль тогтоомжийн тогтвортгуй байдал нь хөрөнгө оруулахад эрсдэлийг бий болгож байна.

2002 онд батлгадсан "Алтанбулаг" худалдааны чөлөөт бусийн тухай хууль нь татвар, хөнгөлөлтийн талаар хэт өрөнхий залалт агуулсан. Хөрөнгө оруулагчдийн сонирхлыг татна гэхэд эргээлзээтэй хууль болжээ гэж үзэж

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

байна. Жишээ нь, "drawback" буюу Чөлөөт бүсийн хуулинд зайлшгүй тусгагдах ёстой "олсон ашигийнхээ 60-аас дээш хувир тодорхой хугацаанд дахин хөрөнгө оруулсан аж ахуйн нэгжийн ёмне нь талсан татварын буцаах тухай асуудал" үл тусгагдсан, мөн гадаадын хөрөнгө оруулагч чөлөөт бүсэд олсон ашигаа гадаад орон руу гүйвуулах тухай харилцааг зохицуулаагүй. өөрөөр хэлбэл энэ асуудал дээр татвар төлөх эсэх нь тодорхойгүй зэрэг асуудлууд хамарагдаж байна. Яваандаа манай улс чөлөөт бүсээ "tah heaven" буюу "татварын диваажин" болгоход болохгүй юм байхгүй. Учир нь "орлогод үл шунах зарчим"-ийн дагуу татварын маш таатай орчныг бүрдүүлснээр хөрөнгө оруулалтыг ихээр татах улмаар чөлөөт бүсээ хөгжүүлэх боломжтой.

Жишээ нь, чөлөөт бүсэд экспортод чиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах их хэмжээний хөрөнгө оруулалт хийж байгаа аж ахуйн нэгжид орлогийн татвар ногдуулахгүйгээр зөвхөн дурмийн сангийн хөрөнгөнд нь тохируулан жилийн хураамж авч болох юм. Жишээ нь, Лейхтенштейны компаниуд орлогоскоо бус харин үндсэн хөрөнгийнхэе 0,1%-тай тэнцэх хэмжээний татвар төлдөг байна. Мөн чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах гадаад, дотоодын аж ахуйн нэгкүүдэд компани байгуулахад шаардагдах хөрөнгөө бэлнээр төлөх шаардлагагүйгээр зохицуулах буюу үйл ажиллагаа явуулаад олсон ашигасаа суутгал маягвар төлөх гэх мэт боломжийг бүрдүүлбэл зөв болов уу. Мөн байгуулагдах эхэн үедээ татвараа төлөх боломжгүй байгаа тохиолдолд зарим төрлийн татвараас нь чөлөөт бүсийн захирагчийн албаны зөвшөөрлөөр тодорхой хугацаанд хөнгөлөх буюу чөлөөлөх гэсэн уян хатан зохицуулалтыг оруулах хэрэгтэй байна гэж үзэж байна. Ийм төрлийн зохицуулалтыг Хятад улсын татварын хууль тогтоомжуудад оруулсан байdag.¹

Газар ашиглалт бол чөлөөт бүсийн нэг чухал асуудал хэмээн миний бие үзэг. Бид чөлөөт бус дэх газрыг зэмшиүүлж, ашиглуулахдаа маш хямд үнээр, эсхүл зарим тохиолдолд үнзгүй байх хэрэгтэй. (Энэ нь чөлөөт бүсээс гадна оршиж байгаа Монгол улсын бусад нутаг дэвсгэрт үл хамарагдана) Хятад Улсад чөлөөт бүсэд бизнес эрхлэх аж ахуйн нэгж нь хамгийн түрүүнд газрын зөвшөөрөл авах ёстой байдаг. Яваандаа ерген уудам нутаг дэвсгэртэй манай орны хувьд нутаг дэвсгэрийнхээ аль нэг хэсгийг гадаад оронд удаан хугацаагаар түрээслэх боломжийг бүрдүүлбэл манай здийн засагт ихээхэн нэмэр болно гэж би үздэг. Ингэдээ олон улсын нээлттэй тэндэр явуулах замаар удаван хугацаагаар түрээслэж болох юм.. Харин төндерийн болзول нь манай орны язгуур эрх ашиг, үндэсний аюулгүй байдалд үл харшлахаар хийдсэн байх ёстой бөгөөд гарч болох серег үр дагаварыг тооцсон байх хэрэгтэй, наад зах нь уул уурхайн олборлолтын үйл ажиллагаа эрхлэхээс бусад тохиолдолд "газрын хэвлэгүй үл ашиглана" гэсэн хориглосон диспозици оруулж болно. Учир нь газрын хэвлэгүй доогуур нь ухсаар байгаад уг бүсээс гаднах нутаг дэвсгэрийн баялагийг ашиглаж болох серег талтай юм. Мөн тэрхүү улсыг зэмшиж байх үед Монголын талын хөндлөнгүйн хяналтыг зайлшгүй байлгах, түрээслэсэн нутгийн газар ашиглалсты төлбөр нь манай улсын жилийн төсвееес дор хаяж 3-5 дахин их байхаар бодолцсон байвал зүгээр юм уу.

¹ Тяньжини Эдийн засаг, технологийн чөлөөт бүсийн журам, 5-р бүлэг, 28 дугаар зүйл

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

Чөлөөт бүсийн захиргааны хувьд тэр оролцох нь зайлшгүй боловч аль болох териин удирдлагас татгалзах ёстай. Учир нь тэр удирдаж байва цагт хүнд суртал газар авч, чирэгдэл их учирдаг хэмээн хөрөнгө оруулагчид үздэг учир тэдний эрх ашигийг хамгаалах зайлшгүй төлөөллийг бий болгох хэрэгтай. Одоогийн хуулиар¹ "хөрөнгө оруулагчдын зөвлөл" байж болно гэж заасан байгаа, харин миний бодлоор байж болох биш зайлшгүй байх ёстай гэж бодож байна. Тэнд аж ахуй эрхлэгчдийн эрх ашигийг хамгаалсан Худалдаа аж үйлдвэрийн танхим юм уу Төлөөлөн удирдах зөвлөл заавал байх хэрэгтэй гэж бодож байна. Тэд зарим тохиолдлогд чөлөөт бүсийн териин захиргааны зарим шийдвэрт хориг тавихаар зааж егех хэрэгтэй. Ингэж хуульчлах нь хөрөнгө оруулагчдад хөрөнгөе оруулах итгэлийг төрүүлж, баталгаа егч байна гэж ойлгож болно.

Чөлөөт бүстэй холбоотой бас нэг чухал асуудал бол чөлөөт бүсэд байнгын арбитр байгуулах тухай асуудал юм. Учир нь хөрөнгө оруулагчид аж ахуйн эрхлэгчдийн хооронд гадаад эдийн засгийн хэлцлээс үүдэн маргаан гарч болох тул түүнийн цаг тухайд нь шийдвэрлэж байх байнгын арбитрыг байгуулах шаардлагатай.

Мөн Монгол Улс Дэлхийн Худалдааны Байгууллагад тишигчийн эрэлсэнтэй холбогдуулан хүлээсэн үүргэг амлалтаа (Эдгэр амлалтанд 1. "Чөлөөт бүсийн талаар авах арга аливаа арга хэмжээний тухай ДХБ-ын гишиг орнуудад мэдээлэхийн хамт тус байгууллагас энэ асуудлаар баримтлах чиглэл журмыг зөрчилгүй байна. 2. Хэрэв Монгол Улс худалдааны чөлөөт бус байгуулбал уг бусээс Монголын бусад нутав дэвсгэрт худалдаалаадаа импортын барав, зөвлэл импортын бүтээгдэхүүн оролцсон бараванд татвар, тариф, гваалийн хураамжийн ердийн хэмжээг хэрэглэх бөгөөд чөлөөт бусэд фирмүүд байгуулахад олгох хөнгөлөлтийг ДХБ-ын Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрт нийцүүлж байна" гэсэн амлалтууд багтана) чөлөөт бус байгуулах тухай холбогдох хууль тогтоомжуудаа нийцүүлэх нь зайлшгүй юм. Олон улсын эрх зүй нь дотоодын эрх зүйгээс хүчин чадлын хувьд давуу байдгийн хувьд манай улс эдгэр амлалтыг юуны эмийн энэ төрлийн гарз, хэлэлцээрүүдэд өөрийн хууль тогтоомжкоо нийцүүлэх нь зүй билээ. Энэхүү өгүүллийнкээ эцслэг ДХБ-ын нэгэн салбар хэлэлцээр болох Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрээр чөлөөт бусэд мөрдөгдхөх хууль тогтоомжинд тусгагдах "татаас" гэдэг ойлголтын талаар төвч дурдья.

Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн 1 дүгээр булагийн 1 дүгээр зүйлд "татаас"-ийг тайлбарласан байдаг. Тухайлбал, 1 дүгээр зүйлийн (a)-гийн ii-д "засгийн газар хураах ёстай орлогосоо татгалзах, эсхүл хурааж авахгүй байх (өөрийн хэлбэл, татварын зээл, татварын хөнгөлөлтүүд)" орно гэж заасан байдаг. Шууд утгаар нь хэлбэл, чөлөөт бус байгуулахдаа дотоодын холбогдох хууль тогтоомжуудад тусгагдах ёстай гудаадын аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдад олгох татварын хөнгөлөлтүүдийг "татаас" гэж ойлгоно.

¹ Чөлөөт бүсийн тухай хууль, II булаг, 10 дугаар зүйл

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

Тодорхой татаасыг энэхүү Хэлэлцэрээр хориглосон бөгөөд үүнд дараах төрлийн татаас хамааградана:

- экспортны үр дүнтэй нэг, эсхүл хэд хэдэн нэхцлийн аль нэгийн хувьд хуулиар, эсхүл болдит байдлаар холбогдсон татаас
- импортын оронд дотоодын бүтээгдэхүүн ашиглахтай нэг эсхүл, хэд хэдэн нэхцлийн аль нэгийн хувьд хуулиар, эсхүл болдит байдлаар холбогдсон татаас хамааградана.¹

Тэгэхлээр энэ хоригийн дагуу Монгол улс өөрийн эдийн засгийн чөлөөт бүсэд бараа бүтээгдэхүүн экспортлоохор хөрөнгөе оруулах сонирхол бүхий гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуй эрхлэгчдэд татварын хөнгөлөлтүүдийг олгох боломжгүй болсон гэсэн ойлголтыг төрүүлж байна. Жишээлбэл, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхэз 50 юм уу 70-аас илүү хувийг экспортолж байвал орлогын татварыг нь 10-20 хувь хуртал бууруулах гэх мэт татварын хөнгөлөлтүүдийг олгож болмооргүй мэт санагдаж байна. Гэхдээ энэхүү Конвенцийн 8 дугаар бүлгийн "Хөгжих буй гишүүн орнууд" гэсэн хэсгийн 27 дугаар зүйлд "хөгжэх буй гишүүн орнуудад зориулсан тусгай болон ялгавартай нэхцел-ийн 27 дугаар зүйлийн 2-ийн (а)-д заасан "Хавсралт 7-д дурдсан хөгжих буй Гишүүн орнууд"-д дээр дурдсан хоригийг" үл хэрэглэнэ гэж заасан байна. Уг Хэлэлцээрийн Хавсралт 7-д зааснаар хөгжих буй гишүүн орнууд гэдэгт "НҮБ-ас тийнхүү тодорхойлсон бөгөөд ДХБ-ын Гишүүн нэн буурай хөгжилтэй орнууд..."-ийг хэлнэ гэжээ. Үүнээс үзвэл бид дээрх Хэлэлцэрээр татаасыг хөрөнгө оруулагчдад олгож болохоор заасан байна.

Мен олон улсын эрх зүйн хурзэнд Монгол Улс цаашдаа Гаалийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай Олон Улсын (Киотогийн) Конвенциад нэгдэн орох хэрэгтэй бөгөөд ингэснээр манай улс оролцож улсуудтай чөлөөт бүстэй холбогдолтой гаалийн хамтын ажиллагаа өргөжих таатай нэхцел бурдэх юм.

Эцэст нь хэлэхэд, бид чөлөөт бүс байгуулахдаа хөрш орнуудынхаа чөлөөт бүсийн өнөөгийн болдит хөгжлийн түвшин, тэдний гаргаж байгаа амжилтийг тооцон, тэднээс илүүгэйзэр гадны хөрөнгө оруулагчид явавал манай чөлөөт бүсүүдэд хөрөнгөе оруулж болох вэ гэдэгт гол анхаарлаа хандуулан ажиллах ёстой болов уу. Өөрөөр хэлбэл, тэдний сонирхлыг хэрэн, яаж өөрийн чөлөөт бүсүүдэд төрүүлах вэ гэдэгт чиглэн эрх зүйн зохицуулалтаа хийх хэрэгтэй юм. Үүний тулд, тэр засгийн бодлого дотоодод чиглахээс гадна гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газруудын үүрэг, үйл ажиллагааг энэ тал дээр идэвхитэй чиглүүлбэл зохистой билээ.

¹ Татаас болон саармагжуулах арга хэмжээний тухай Хэлэлцээрийн 2 дугаар бүлгийн 3 дугаар зүйлийн (а),(б) заалтууд.

ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА БА КОНВЕРГЕНЦИ

ХЭЗҮТ-ийн Олон улсын эрх зүйн секторын
Эрдэм шинжилгээний ажилттан *Б. Гун билэг*

XIX зуунд үүссэн Харьцуулсан эрх зүй нь үүссэн цагаасаа эхлэн өнеөг хүртэл өөрийн мөн чанар, зорилго, судлагдахуун, үүрэг, хэрэглээ, онолын ургсал зэрэг олон салбар чиглэлүүдээр судлаачдын сонирхлыг татах иржээ. Дэлхийн олон улс орны хувь, эрх зүйн дээд сургуулудын хичээлийн хөтөлбөрт багтаж, оюутнуудын сэтгэн бодох чадварыг хөгжүүлж, эрх зүйг танин мэдэхүйн их аянд хөтөлж болсон энэхүү эрх зүй нь 21 дүгээр зуунд өөрийн хөгжлийн оргил цагт хүрэх нь гарцаагүй юм. Өөрөөр хэлбэл бидний амьдарч буй энэ зууны эрх зүйн шинжлэх ухааны гол судалгаа нь бүхлээрээс харьцуулсан эрх зүй судлалд чиглэгдэх болно.

Дараахь үйл явдлууд түүхэнд болж өнгөрөөгүй бол магадгүй өнөөдөр харьцуулсан эрх зүйн тухай ч, эрх зүйн тогтолцооны тухайд ч тэр яриа гарвагчийг байх байсан бишээ. Хэрэв Ромын эзэнт гүрний эрх зүйн үзт их өв Варварчуудын түрэмгийлэлд өртөөгүй бол, хэрэв Англи, Норманчуудын булаан эзлэлтэд өртөж, Эзэн хааны нэгдсэн шүүхүүд байгуулгадаагүй бол, хэрэв Наполеон эзсийн эзст хуулиудыг эмхэтэн терелжүүлэхийн сонирхоогүй бол, хэрэв Ромын эрх зүй XII зууны гэтэлж чадаагүй бол, хэрэв улс бүр өөрийн нутаг дэвсгэр дээр засаг захирагаагаа байгуулан өөр өөрийн гэсэн засаглалыг хэрэгжүүлэгээгүй байсан бол, хэрэв дундад зууны үеийн колоничлогчид газар нутгаа өргөжүүлэн тэлээгүй бол Харьцуулсан эрх зүйн үүсэл, хөгжилт, цаашдын төлөвийг ярих нь утгагүй юм.

Харьцуулсан эрх зүй нь хөгжлийнхөө явц, шат бүртээ шинийг эрэлхийлагч байсан бөгөөд өнөөгийн Харьцуулсан эрх зүйчдийн голлон анхаарах болсон судлагдахуун нь Конвергенцийн онолыг¹ эрх зүйд хэрхэн буулагах вэ гэдэгт чиглэгдэх байна.

Академич С. Нарангэрэл "Улс орон бурийн эрх зүй судлалын хэрэгжүүлж буй судалгааны цар хүрээ, манай гариг дээр оршиж буй /оршиж байсан/ эрх зүйн тогтолцоонд хамаарах мэдээ баримтын баялгийг бүтээлчээр ашиглах нь хойшилтуулшгүй чухал асуудал юм. Тийм учраас дэлхий дахини хуримтуулсан бух түршлэгыг нэгтгэн дүгнэсний үндэсн дээр бүх нийтийн, үндэстэн болгоны дагаж баримтлах эрх зүйн онолыг боловсруулах шаардлагатай тийм цаг үе, эрин зуунтай бид золгож байна"² хэмээн тэмдэглэсэн бол доктор Должингийн Баярсайхан багш "Сүүлийн үед эх газрын системийн орнуудад хуулийг бүтээхээс илүү түүнийг

¹ Дэлхийн хоёрдугаар дайны дараа философийчид, улс төрчид, тухайлбал П. Сорокин, Ж. Голбрайт, У. Ростоу /Анг/, Ж. Фурштадт, Ф. Перри /Франс/, Я. Тинберген /Нидерланд/, Х. Шельский, О. Флейтхэм /Герман/ нар 1950-60-аад оны үеүдэд Конвергенцийн онол буюу капитализм, социализм хоёртын ногтгэн нэг бүхэлзгээ идеал нийгмийг цогцлоож болох тухай заасан байна. Энэ нь сүүлдээ техник, здийн засаг, социологийн хурээнд ирвэлийг ногтгэж сонгодгийг бүтээх тухай сургааль болон хувирчээ.

² Нарангэрэл. С. "Орчин үеийн эрх зүйн конвергенци", "Эрх зүй" сэргүүл. 8-8/2002, 15 дах тал

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

хэрэглэх, тайлбарлах практик тогтоох улмаар шүүхийн прецедентийг жишиг, хэм хэмжээг нэвтрүүлэх шаардлагыг илрүүлж байхад, Англосаксоны системийн орнуудад хууль, хуульчилсан актуудыг олионоор гаргах, тэдгээрийг шүүхийн прецедентийн зарчмуудтай уялдуулж, хослуулах гэсэн эрмэлзэл хандлага нилээд үзгэдэг болжээ³" гэсэн байна.

Нийтийн болон эх газрын эрх зүйн тогтолцоонуудын уламжлалаас аль алинаас нь бурдсан эрх зүйн конвергенцийн нэгэн тод жишээ бол АНУ-ын Луизиана муж улс болон Филиппин улсуудын туршлага юм. Луизиана муж улс, Филиппин улс нь АНУ-ын бусад муж улсуудаас эрх зүйн тогтолцооны хувьд харьцаангуй бие даасан, Эх газрын болон Нийтийн эрх зүйн тогтолцоонуудын аль алиных нь шинжийг вөртөө хадгалжээ.

Ийнхүү эрх зүйг конвергенц болон интеграццалгүйгээр цаашид хөгжүүлэх боломжгүй юм гэж үү, байгаа юм байгаагаараа л байгаад уламжилж ирсэн эрх зүйгээ тахин шүтэж, үндэстэн үндэстнээрээ л үлдэж болохгүй гэж үү гэсэн асуулт эндээс урган гарна. Өөрөөр үзлэл Конвергенцийн онолын эсрэг Дивергенцийн онолын үзэл баримтлалууд серен тавигдана. Энд энгийн наг жишээ авья. Хэрэв ногоочны гэрийн гадаа малчин ирээд "Та мах авах уу?" гэж асуувал ногоочин түүнд "авья" гэх буюу эсвэл "Уучлаарай, би мах идэгдүүгүй. Би цагаан хоолтон" гэх болно. Малчин "Тэгвэл сүү авах уу?" гэвэл ногоочин "Тээье" хэмээн хариулах буй заа. Учир нь түүний хашаанд сүү ургадагтуй. Харин ногоо л ургадаг. Гэтэл ногоочны ходоод сүү нэхэж байж болно.

Үүнтэй адилгаар нийгмийн харилцаа хөгжих тусам эдгээр шинэ харилцаануудыг зохицуулах оновчтой зохицуулалтыг нийгэм хуульчдаа, төрөөс шаарддаг. Тэр тусмаа ширэнэг ойн будуулаг, эртний чөйн амьдралын хэв маягийн омгууд шиг өнеегийн нийгэмд амьдралхыг л эрмэлзэгүй бол улс орнууд даяарчлалын энэ нийгэмд бусад оронтой харилцаж, бусдас туршлага судлах нь гарцаагүй юм. Иймээс Дивергенцийн онол үгүйсгэгдэх нь гарцаагүй. Гэхдээ бүхлээрээ үгүйсгэгдэх гэж ойлговол алдаа болно. Өнөөгийн байгаа хэв маягтаа сэтгэл нь ханасан, дам ганцаараа оршин тогтоно эрмэлзэлтийн улс үндэстэн байж болохыг үгүйсгэхгүй. Тийм учраас ардчиллын үнэт зүйлсийг дээдлэх үүднээс Дивергенцийг бүхлээр нь үгүйсгэх шаардлагагүй юм. Энэ талаар доктор Д.Баярсайхан "Систем хоорондын интеграццал гүнзгийрэхийн хирээр үндэсний онцлог, уламжлалын үнэт зүйлсээ хадгаж авч гарах гэсэн тэмүүлэл хүчтэй илрээ болсон зэрэг нь илт анзарагдах боллоо. Энэ бүхнээс шалтгаалж хөгжлийг тодорхойлдог хоёр хүчин зүйлийн харьцаанд зөрчил үүсч, уламжлагдах замаар шинэчлэгдэх үү, эсхүл шинэчлэгдэх замаар уламжлагдах уу гэдэг нь өнөө үед нэн бүрхэг, нэг улс ард түмний төдийгүй дэлхийн ертэнцийн анхаарлыг татсан тулгамдсан асуудал болж байна.

Хөгжингүй орнуудад шинэчлэлийг төлөвшүүлснээр уламжлалыг санагалзах эрмэлзэл ихтэй байхад, хөгжлеөр буурай орнуудад уламжлалыг авч үлдсэнээрээ шинэчлэлийг эрхэмлэх гэсэн тэмүүлэл

³ Д. Баярсайхан., Монгол улсын эрх зүйн тогтолцооны сонголт төлөвшүйн асуудалд. Шихижутгүүл, УБ.1999/2, 26 дахь тал

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

дүүрэн байдаг нь дээрх зүй тогтолцатай холбоотой"⁴ гэж эрх зүйн тогтолцооны төлөвшлийн асуудлыг авч үзжээ.

Дэлхийн эрх зүйн тогтолцоо өнөөдөр дөрвөн үндсэн хэсэгт хуваагдаж байна.

1. Ром-германы буюу эх газрын
2. Англи-саксоны буюу нийтийн
3. Шашины буюу Лалын
4. Социалист буюу үзл суртлын

Эдгээрийн аль аль нь өөрийн хамрах хүрээ, нутаг дэвсгэр, зохицуулалтын өөврмэц онцлог шинжүүдийг өөртөө агуулсан байдал ба өнөөгийн нийгэмд дан ганцаараа бие даан оршиж, нийгмийн харилцааг зохицуулж буй нь нэг ч үгүй гэх хэлэхэд хилсдэхгүй. Энэ юунаас харагдаж байна вэ гэвэл:

1. Эрх зүйн тогтолцоонууд бие биенээсээ ашигтай зохицуулалтыг хуулбарлан авч өөртөө шингээх,
2. Эрх зүйн тогтолцоогоороо тэргүүлэх чиг хандлагын жишээ нь, АНУ, ХБНГУ, Франц, Англи зэрэг орнууд өөрийн эрх зүйгээ маш өргөнөөр сурталчилж, хөгжлийн хувьд хөгжих шатандaa явж буй өрнүүдүүн эрх зүйд өөрийн эрх зүйгээ суулгаж өгөх, түүгээр ч ул барам үүгээрээ дамжуулан улс тэр, нийгэм, эдийн засаг, соёлын нэеелье тогтоох, хадгалахыг оролдох,
3. Негee талаас нийгмийн бодит хэрэгцээ дан ганц нэг эрх зүйн тогтолцоо дангаар орших нь эрх зүйн хөгжил, нийгмийн харилцаанд сергөөр нэвээлж байгааг баталж буй учир түүнийг зохицуулж, хөгжүүлж чадах эрх зүй шаардлагатай гэсэн бодит шалтгаануудын үүднээс эрх зүй нь дан ганцаар бие даан орших боломжгүй болсон юм.

Дэлхийн ихэнх улс, АНУ, Япон тэргүүтэй орнууд эрх зүйгээ шинчилж өөрийн харьялаагдах эрх зүйн тогтолцооноос гадна бусад эрх зүйгээс шаардагдах эх сурвалж, хэм хэмжээнүүдийг татан авч байна. Үүнтэй адилaaар эрх зүйн тогтолцоонуудын хамгийн том багана болсон Англи, Герман хоёр ч өөр өөрсдийн ашигтай, давуу талуудаас суралцах байгаа юм. Тухайлбал, Англи улс статут буюу бичмэл хуулийг өргөнөөр ашиглах болсон, Герман улс нийгмийн бүхий л харилцааг нарийн зохицуулах нь нийгмийг авилтгэл, тогтвортгүй байдалд эргээд хүргэх, үүний улмаас хүний эрх ихээр зөвчигдэх хандлага яхь болсынг хүлээн зөвшөөрч хэвшиүүлэн шийтгэх эрх зүйн зарим давуу талын хүлээн зөвшөөрч байна. Үүнтэй нэгэн адилaaар Монгол улс ч гэсэн териийн үйл ажиллагаа, эрх зүй бүтээх үйлд зөвхөн эх газрын эрх зүйн тогтолцоот гэлгүйзэр нийтийн эрх зүйн орнуудын зарим ололтой талуудыг авч ашиглахыг эрмэлзэж байгаа юм. Үүний АНУ-аас хэрэгжүүлж буй "Шүүхийн шинэчлэл" теслийнхэн Эрүүгийн хууль, Эрүүгийн Байцан Шийтгэх хууль, Прокурорын тухай хуулиудын тесэлд зөвлөгөө егснөөс, мөн 1992 оны Үндсэн хуульд териийн эрх мэдэл хуваарилах онол хэрхэн тусгагдсанас тус тус харж болно.

⁴ Д. Баатарийн, Монгол улсын эрх зүйн тогтолцооны сонголт төлөвшлийн асуудалд. Шийхүүтүү сэтгүүл, УБ.1999/2, 28 дахь тал

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

Эрх зүйг ийнхүү шинчилж, бусад эрх зүйгээс ололттой талуудыг вөртөө шингээсэн тэр эрх зүй ямар эрх зүй болох вэ? Хэрэв эрх зүйн тогтолцоо веерсийн сонгодог шинж чанаараа алдаад бусдаасаа давуу талуудыг нь авч хэрэглэж байгаа бол эдгээр эрх зүй нь ямар эрх зүйн тогтолцоотой болох вэ гэдэг асуулт урган гарч ирнэ. Манай улсын эрдэмтэд Холимог эрх зүй гэдэг ойлголтыг өргөнөөр авч үзэх, ихээр бичицгэж байна. Тэгэхлээр Холимог эрх зүй гэж юу вэ?, Эрх зүйг хольж болох уу?

Эрх зүйг хольж болохгүй нь нэн ойлгомжтой. Учир нь эрх зүйн зорилго нь үнэн, шударга ёсыг тогтоох, хүний эрх, эрх чөлөөг хөгжүүлэх гэсэн үндсэн гурван тулгуур ойлголт дээр тогтдог. Энэ гурвыг хангаж чадаж байвал тэр эрх зүй тэгс эрх зүй болж байгаа юм. Гурван тулгуур ойлголт:

1. Эрх зүй бол эрх чөлөөний баталгаа мен.
2. Эрх зүйн үндэс нь үнэн мен.
3. Эрх зүй нь шударга ёсны эх сурвалж мен.

Холимог эрх зүй гэдэг нэр томьёо нь өөрөө утга зүйн алдаатай. Холимог гэдэг уг нь аливаа зүйлийг холих, хутгах гэсэн утгатай ба эндээс харвал холимог үнэн гэсэнтийэй адил болж байгаа юм. Харин Эрх зүйг холимог гэж хэлж болох боловч энэ нь тухайн эрх зүйг тодорхойлоход саадтай болж байна. Харин "Сонгомол" эс бөгөөс "Сэлгэмэл" эрх зүй гэж томьёолж болох юм.

Эрх зүйн сонгомол буюу Конвергенцын онолын үр дүнд үүсч болох Сонгодог тогтолцоог бүрдүүлэхийн тулд Эрх зүйн тогтолцоо бурийн идеал шинжүүдийг цуhas дурдай.

1. Эх газрын эрх зүйгээс бичмэл буюу статут эрх зүйг,
2. Нийтийн эрх зүйгээс хэвшүүлэн хэрэглэх эрх зүй, тэгш эрхийн эрх зүйг,
3. Шашны эрх зүйгээс ухамсарласан үүрэг, ёс зүйг,
4. Социалист эрх зүйгээс идеализм буюу эрх зүйн зорилгод бүрэн тэгс итгэх итгэлийг сонгож авч болно.

Нийтийн эрх зүйн хэвшүүлэн хэрэглэх эрх зүй нь үнэнийг процессын үр дүн гэж үздэг бол, эх газрын эрх зүйд хуулийн үзэл баримтлалын үр дүн гэж үздэг. Өөрөөр хэлбэл эцсийн эцэст нэг үнэний олохын тулд хоёр салав замыг түүлдаг. Процесс, хуулийн үзэл баримтлал хоёрт хоёуланд нь давуу талууд байгааг бид олж хардаг. Яагаад хэвшүүлэн хэрэглэх эрх зүй, бичмэл эрх зүй хоёр дан дангаараа нийгмийн харилцааг зохицуулж чадахгүй байна вэ гэвэл:

1. Хуулийн үзэл баримтлалын үр дунд Эрх чөлөө хэзээ ч бүрэн тэгс хэрэгжихгүй. Детальчилсан хууль зүй эрх чөлөөг хөгжүүлах биш, хяглаарлана. Энд хуулийг парламентын буюу улс төрийн ашиг сонирхлын үүднээс тогтоож байгаа юм. Гагцхүү улс төрийн тохирооны үр дунд үнэн тогтоно.
2. Парламент өөрөө савьлаттай субъект, харин шүүх өөрөө хэзээд маргааны үр дүнг тогтоодог, бодит фактыг гаргаж өгдөг, бүтээгч шинжтэй. Харин эх газрын шүүх ийм биш. Хөндлөнгөөс харахад парламентаас баталсан хуулиин дээр дасгал хийж буй мэт.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

- Хуулийг дээдлэх ёсанд эрх зүйн ухамсар хөгждөггүй. Хүн хууль бол миний бутгэгдэхүүн гэж боддоггүй. Хууль бол миний эрхийг хяглаарласан зүйл гэж харах нь олонтаа ажиглагддаг. Харин нийтийн эрх зүйд Үндсэн хууль бол миний эрхийг биш, төрийн эрх мэдлийг хяглаарласан хууль мөн гадэг шинжийг илүүд хардаг байна.

Шашны эрх зүйн талаар Р. Давид "Манай гариг дээр шашны сургаал номлолд суурилсан бүхэл бүтэн эрх зүйн тогтолцоо бий. Орчин үеийн эрх зүйн нэг үндсэн тогтолцоо нь Лалын эрх зүй мөн"⁵ гэжээ. Энэ нь Коран, Сунна, тэдгээрийг нэгтгэсэн Шариатын эрх зүйд үндэслэгддэг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд "Хүн бүр чөлөөтэй бодож сэтгэх, шүгж бишрах, сүсэглэх эрхтэй. Энэ нь шашны шүтлаг буюу үзэл бодлоо өөрчлөх, ганцаараа буюу бусадтай хамтран нийгмийн болон хувийн журмаар шашин шүтлэг үзэл бодлоо заан түгээх, мергел хийх, сургаал гүйцэтгэх шашны хийгээд зан үйлийн ёслол үйлдэх эрхийг хамарна"⁶ гэж заажээ.

Академич, доктор, профессор С. Нарангэрэл "Шүтэн бишрах эрх чөлөө нь энхийг тогтоох, нийтийн сайн сайхны тусын тулд бүх сусагтнууд хамтран ажиллах, хүн төрөлхтний соёл иргэншилд тус дахь узуулж иржээ"⁷ хэмээн шашны эрх зүйг үнэлсэн байна. Харин Социалист эрх зүйгээс иргэдийн ирээдүйд итгэх итгэл, эрх зүйн соёлыг өөвлий болно.

Дээр өгүүлсэн эрх зүйн тогтолцооны идеал шинжүүдийг дараах 4 түвшинд авч үзэх хэрэгтэй юм.

- Харьцуулсан эрх зүй ба эрх зүйн философи /харьцуулсан хууль судлал, эрх зүйн онолын асуудлууд гэх мэт/ хэмээн түвшин нь эрх зүйн мөн чанарыг таних цорын ганц хэрэглүүр болж чадах юм.
- Харьцуулсан эрх зүй ба эрх зүйн түүх /түүхчилсэн харьцуулсан эрх зүй, үндэл улс төр, нийгмийн бусад шинжилэх ухааны түүх гэх мэт/ түвшин нь эрх зүйн тогтолцоонуудын түүхийг өргөнөөр авч үзэж, ирээдүйд алдаа гаргажкуйг байхад чиглэгдэнэ.
- Харьцуулсан эрх зүй ба соёл /харьцуулсан эрх зүйн соёл ба соёл судлал, уламжлал гэх мэт/ түвшин нь олон янзын соёл, уламжлал давхцах буюу интеграци, мультикультуризмын онолыг судлах болно.
- Харьцуулсан эрх зүй ба эдийн засгийн түвшин нь харьцуулсан эрх зүйчдийн хамгийн их анхаарал төвлөрүүлж байгаа түвшин бөгөөд даяарчлалын нийгмийг хеделгэгч гол хүчин зүйл гэж үзүүлэх байна. Өөрөөр хэлбэл нийгмийн бүхий л харилцааны цаана эдийн засгийн сонирхол оршдог гэж энэ түвшнийг баримтлагчид үздэг байна.

Эдгээр түвшинд харьцуулан судалсан эрх зүйн зохицуулалтыг хуулбарлах, шууд шилжүүлэх, стандартчлан нийцүүлэх, хослуулах, харьцуулсны үндсэн дээр шинэ зохицуулалт бий болгох зэрэг олон янзын

⁵ Лүндиндорж. Н. Төрийн онол. УБ., 1997. 115 дахь тал

⁶ Хүний эрх, олон улсын гарээ, хэлэлцэрүүдийн эмхээтгэл., УБ. 1998. 5 дахь тал

⁷ Нарангэрэл. С. "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо", УБ. 2001. 40 дахь тал

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ, ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙ

аргаар улс орнууд өөрийн эрх зүйн тогтолцоонд шинэ зохицуулалтыг буулгаж байна. Харамсалтай нь улс орнууд ихэнхи тохиолдолд хослуулах, шинэ эрх зүй бий болго замаас хальшрах буюу эс бөгөөс гадны дарамт шахалтны улмаас чухал ач холбогдолтой аргуудыг тэр бүр сонгож чадалгүй харьцангуй ач холбогдол багатай хуулбарлах, шилжүүлэх, стандартчлан нийцүүлэх арга замуудыг сонгож байна. Европын Холбоонд нэгдэж буй орнуудын туршлагаас хараад стандартчлан нийцүүлэх аргыг өндөрт өргөж, өндөр хөгжлийг орнуудын боловсруулсан стандартад нийцэхийн тулд хөгжиж буй бусад орнууд чармайх болсныг бид харж болно. Тухайлбал энэ нь Европын холбоонд элсэжэд тавигдах шаардлагууд буюу болзол хэмзэх зүйлүүдээр илрэн гарч байгаа юм.

Мен шилжүүлэх төөрөгдлийн талаар доктор, профессор Пол. Х. Бриетце "Ийм төөрөгдлөд автсанаас болж гадны эрх зүйн хэм хэмжээг ямар нэг нэр хүндтэй улс оронд хэрэглэгддэг нь найдак уг бурчлэн, бөөнөөр нь хуулбарлан авахад хүрч байна. Хуучин Зевелент Холбоот Улсын олон хууль тэндээ үр дүнтэй хэрэгжик байсан эсэх, монголын соёл, бусад нехцэлд тохиорох эсэх, монголын эрх зүйн тогтолцоо ба ард түмний амьдралд ямар их цэгцгүй, нийцгүй байдал үүсгэж болох зэргийг уг харгалзан монголд ийнхүү шилжүүлэн суулгасан. /Бусад оронд үүнийг "колонийн" эрх зүй гэж нэрлэх биз/. Ийм эрх зүйн тогтолцоо байсан орны хувьд монголчууд Америк, Австрали, эсхүл Германы ч хуулийг уг бурчлэн шилжүүлэн авна гэж үү? Гадаадын эрх зүйн хэм хэмжээг болгоомжтой, цаг хугацаа зарцуулан өөртөө тохируулах хэрэгтэй байдаг.

Гэтэл Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Банк, Азиийн Хөгжлийн Банк зэрэг олон улсын хандивлагчид шилжүүлэн суулгах төөрөгдлийн бишрэн шүтэгчид байдаг. Тэдний үзэж байгаагаар, сайн хууль бол хаана ч сайн хууль болно. Энэ онол зөв онол байсан бол бух орнууд ижил төстэй хуультай байх байсан бөгөөд эрх зүйн дарвинизмын дагуу чадалтай нь үлдэх байсан⁸ хэмээн голчийг нь олон тэмдэглэжээ.

Хэдийгээр дээрх аргуудын алийг нь ч сонгосон эрх зүйн конвергенцад хүрч болох боловч гагцхүү зөв, оновчтой арга нь зөв тогтолцоог бий болгож ирээдүй, үр ашгаа егех ёстой юм. Тиймээс улс орны эрх зүйн тогтолцоог конвергенцлох үйл ажиллагаагааг нарийн няхуур, ирээдүйд хэлбэрийн тедий, үр дүнгүй олон зохицуулалт үүсэхээс урьдчилан сэргийлж, мухардлал оруулахгүйгээр боловсруулах нь харьцуулсан эрх зүйчдийн үндсэн гол үүрэг болж байна. Мен Харьцуулсан эрх зүйн бүх зорилго нь төсөөтэй нэгдмэл нягтгэлээ тогтолцоог бий болгохыг зорьдоггүй бас ялгаатай талуудыг хөгжүүлж болно гэдгийг мартаж болохгүй юм.

⁸ Пол. Х. Бриетце., Монгол Улсын эрх зүйн шинэтгалийн сонголт" илтгэл, "Эрх зүйн шинэтгэл ба үндэсний эрх зүйн тогтолцоо" олон улсын симпозиум, УБ 2000., 72 дахь тал

КРИМИНОЛОГИЙН СУДЛАГААНЫ
НАЙДВАРТАЙ БАЙДАЛ,
ТҮҮНИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ АРГА ЗАМ

МУИС-ийн ХЭС-ийн Эрүүгийн эрх зүйн
тэнхимийн багш Г.Эрдэнэбат

Гэмт явдалтай тэмцэх ажил нь юуны өмнө гэмт явдлын судалгааг
найдвартай, үнэн, бодитой болгоос эхлэх ёстай. Эрүүгийн тоо бүртгэлээс
үзүүлэд Монгол Улсад сүүлийн 10 жилийн (1991–2000) хугацаанд гэмт
хэргийн илрүүлэлт 87 % байгааг бусад улс оронтой харьцуулбал¹ нилээд
өндөр үзүүлэлт бөгөөд чухам энэ тоо бүртгэлдээ тулгуурлан
криминологийн судалгааг явуулж байгааг үндэс болговол гэмт явдлын
шалтгаан нехцлийг тогтоох ажил нилээд өндөр магадлалтай судалгаанд
үндэслэгдэн, бодитой явагдаж байна гэж үзэж болохор байна. Гэвч уг
үзүүлэлт вөрөө бодитой эсэх нь харин эргэлзээтай юм.

Гэмт хэргийн илрүүлэлт ийм өндөр төвшинд байгааг манай орны хүн
ам цөөн, цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа эрнимтэй сайн явагддаг
зэрэг онцлог хүчин зүйлсээр тайлбарлаж болох ч юу юунаас илүү эрүүгийн
тоо бүртгэл бодит бус байгааг анхаарч үзвэл зохино.

Ерөөсөө гэмт явдлын бодит төвшинг тодорхойлох нь Монгол Улсад
төдийгүй дэлхийн бусад улсад ч төвөгтэйд тооцогддог асуудал. Үнэн
хэрэгтээ бодит гэмт явдлын төвшин бүртгэгдсэн гэмт явдлаас хавьгүй
өндөр байдаг. Гэсэн атлаа бүртгэгдсэн гэмт хэргийн цөөхөн хувьд мөрдөн
байцаалтын ажиллагаа явагдаж бүр цөөхөн хэсгийг шүүхээр хянан
шийдвэрлүүлж түүнийхээ очижүүхэн хэсэгт ял шийтгэл ногдуулдаг.

Энэ зүй тогтол шахуу үзэгдлийг криминологчид “юулуурийн
үйлчлэл” гэж нэрлэсэн. Дэлхий дахинь нийтлэг хандлагаас үзвэл нийт
үйлдэгдсэн гэмт хэргийн дөнгөж 10 хувь нь шүүхээр шийдвэрлэгдэж 4-5
хувь нь ял шийтгэгдэг байна. Үүнийг графикаар дурслэвэл дараах
байдалтай харагдана:

¹ Өндөр хэргийн, цагдаагийн техник тоног твексеремжвер өвч зэвсэглэсэн орнуудад гэмт хэргийн
илрүүлэлтийн хувь 25-45 % халбалац, тухайлбал, АНУ-д (21-22), Англид (32-40), ХБНГУ-д (45-46)
байна.



Үүний нотолгоо болгож өгүүлэхэд 1996 оны байдлаар Монгол Улсад 19259 хүн гамт хэрэгт холбогдох илрүүлэлтийн хувь нь 84 % гарсан атлас нийт холбогдогчдын 72.3 % буюу 13907 хүн ял шийтгүүлжээ (үүнээс нийт холбогдогчдын 54% болох 10398 хүн хорих ялаар шийтгэгдсэн).

Харин эрүүгийн хэрэг үүсгэсэн 19259 хүний 27.7 % буюу 5352 хүний асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тодорхойгүй байгаа юм. Эндээс нийт бүртгэгдсэн гамт хэргийн 56.3 % -ийг бурзан гүйцэд мөрдөн шалгах шүүхээр шийдвэрлэсэн болох нь харагдаж байна. Өврөөр хэлбэл, бидний зөвхөн бүртгэсэн гэмт хэрэгт үндэслэн хийсэн криминологийн судалгааны найдвартай байдал 56.3 % байна. Гэтэл үүний цаана нуугдмал, бүртгэгдэггүй гэмт хэрэг хичнээн байгав нь тодорхойгүй юм.

Криминологийн судалгааны найдвартай байдлыг дээшшуулэхэд нуугдмал гэмт явдлын төвшинг тодорхойлж, бууруулах ажил чухал байр эзлэх нь зүй. Гэтэл нуугдмал гэмт явдлын бидит төвшин тогтоох нь бараг боломжгүй зүйлд тооцогддог. Судлаачдын узэж буйгаар бодитойгоор үйлдэгдэсэн гэмт хэргийн 60 гаруй хувь нь нуугдмал хэвээр үлддэг гэх.

Тодорхой төрлийн гэмт явдлын хувьд энэ тоо асар их хэлбэлзэх нь ойлгомжтой. Ер нь бол гэмт хэрэг хэдийчинээ ноцтой байх тусам нуугдмал байх магадлал төдийчинээс бага байна. Хүний бие махбодод хүнд гэмтэл учруулах гэмт хэргийн нуугдмал байх боломжкоос хөнгөн гэмтэл учруулах нь гэмт хэргийн нуугдмал байх магадлал өндөр. Тэгвэл хамгийн ноцтой гэмт хэргийн тоонд ордог, энэ утгаараа нуугдмал байх боломжкоор хамгийн бага хүний санаатай алах гэмт хэргээр жишээ болгон аваад үзье. 1996 оны байдлаар Монгол Улсад 277 хүний санаатай алах гэмт хэрэг бүртгэгдсэн байна.

Харин энд онд 50 хүн сураггүй алга болсоноор тооцогдож 234 хүний амшиг хорлох болон золгүй байдлаар нас барсандаа тооцжээ. Саннаатайгаар бусдиг алсан этгээд асар нарийн төлөвлөж золгүй байдлаар нас барсан мэтээр ул мөрийг хуурмаглах, цогцыг нуухаас авахуулаад гэмт хэргийн ул мөрийг баллах бүхий л ажиллагаа хийх нь олонтай. Цогцос байхгүй ихэнх тохиолдолд сураггүй алга боловсодын тоонд бүртгэгдээд өнгөрнө. Үүний

зэрэгцээ мөн онд хүн амины гэмт хэрэгт шалгагдаж байсан 9 хүн хэрэг бүртгэлт, мөрдөн баацаалт, шүүхээс оргон зайлсан байна. Энэ хүмүүст холбогдох хэрэг эрүүгийн тоо бүртгэлд ороогүй нь мэдээж. Жишээнд ашиглаж буй 1996 онд цагдаагийн байгууллагад хэн болох нь тогтоогодохгүй цогцос 68 одсон. Энэ бүх үйл баримтын цаана хүн амины гэмт хэрэг нуугдсаар байж болох нь ойлгомжтой болов уу.

Энэхүү юулзуурин үйлчлэлийг хэрэг бүртгэлт, мөрдөн баацаалтын явацад олон хэргийг хэрэгсэхгүй болгодог, зарим нэг хэрэг нэгтгэгдэж (мөн заримыг нь тусгаарладаг), гэмт хэргийн холбогдог нас барах зэрэг хүчин зүйлүүд нийлөөлдөг, тэрчлэн цагдаагийн болон шүүхийн тоо бүртгэл өөр аргачилалаар хийгддэг зэрэг янз бурийн шалтгаанаар тайлбарлах болох ч бүртгэгдсэн гэмт хэрэг болон бодитойгоор үйлдэгдсэн гэмт хэргийн хооронд зөвхөн арга зүйн төдийгүй зориудын гэж хэлж болох шалтгааны улмаас зөрүү гардаг.

Жишээлбэл, цагдаагийн байгууллага олон нийтэд гэмт хэргийн талаархи тоо баримтыг еренхий дүнгийн хувьд есгэед харин илрээгүй гэмт хэргийн төвшинг багасгаж харуулахыг хичээдэг. Энэ нь цагдаагийн байгууллагын нэр хүндийг өргөх, гэмт явдалтай тэмцэх ажилд иргэд ач холбогдол өгч энэ үйл хэрэгт олон нийтийн тус дэмжлэгийг авах улмаар гэмт явдалд тавих хяналтын үр нелоөг дээшлүүлэхэд чиглэсэн нэг төрлийн арга ажээ.

ХБНГУ-ын эрдэмтэн Ханс Шнейдер "Эрүүгийн албан ёсны тоо бүртгэл нь шат шатны хууль сахиулах байгууллагууд нийгмийн хяналтын ёмне өөрийгөө зөвтөн харуулах гэсэн үлгэр (загвар) юм. Тухайлбал, цагдаагийн байгууллага энэхүү тоо бүртгэлээр өөрсдийн ажил үүргийг хэрхэн сайн гүйцэтгэнээс илрэхийлэхийн зэрэгцээ гэмт явдал нийгэмд ямар их аюул заналхийлж байгаа, түүнтэй тэмцэх нь хичнээн тулгамдсан асуудал болохыг харуулахыг зорьдог.

Тэгэхгүй бол тэдний төсөөв мөнгийг нь хасаж, орон тоог нь цомхтожж эхэлдэг юм² гэсэн байдаг. Үүний нотлох мэт гэмт хэргийн тоо бүртгэлийг цагдаагийн байгууллага нь нэгтгэдэг ХБНГУ-ын хувьд гэмт хэргийн төвшин бусад улстай харьцуулахад ямагт харьцангуй өндер төвшинд байдаг аж.

Криминологийн үзүүлэлтийн найдвартай байдалд улс төрийн, зохион байгуулалтын, материалыг хангамжийн, сэргээл зүйн болон техникийн шинжлэхүүний хүчин зүйлс цогц байдлаар нелоөлдөг гэж мэргэжилтэнүүд үзэж байна.

Улс төрийн гэж болох намуудын мөрийн хетелберийн биелэлт, төрийн эрх баригчдын өөрсдийн ажлыг үзүүлэлтийн нэг хэсэг болгон гэмт явдлыг бууруулсан үр дүнг сонгоч олонд хүргэх сонирхол нь криминологийн судалгааны үр дүнг өөрчилдэг. Үүнээс болоод ямар нэгэн улс төрийн хүчин засгийн эрх барж эхэлсэнээс хойш гэмт хэрэг буурсан тоо баримтыг олон нийтэд хүргэж эхэлдэг атлаа тэдний засгийн эрхийг барж эхлэхээс ёмни гэмт хэрэг журам мэт всеж байсан болж таардаг.

² Шнейдер Ханс Йоахим. Криминология. М., 1994. С. 111

Ийм улс төрийн нэлэөвлөл доор криминологийн судалгаа хийгдэж байгаа тохиолдолд гэмт явдлын талаар бодитой мэдээлэл цуглуулах нь боломжгүй юм.

Эрүүгийн тоо бүртгэл нэгдсэн хяналтгүй цагдаа, прокурорын байгууллага, шүүх тусдаа тоо бүртгэл хөтөлж түүгээрээ веерсийн ашиг сонирхолыг илэрхийлсээр байгаа нь криминологийн үзүүлэлтийн найдвартай байдлыг алдагдуулж байна. Зөвхөн ашиг сонирхолын төдийгүй судалгааны аргачилалын хувьд ч эрс зөвүүтэй байх нь энэ байдлыг улам хүндруулж байдаг.

Сүүлийн жилүүдэд эрүүгийн хэргийн судалгаанд сергэер нэлэөвлж болзошгүй нэгэн нөхцөл байдал үүссэд байгаа нь хууль сахиулах байгууллагын ажлын ачаалал юм.

Нэг хэрэг бүртгэгч, мөрден байцаагч, прокурор, шүүгчид ногдох хэргийн тоо болон уг хэрэгт явуулах ажлын ачаалал хэрээс хэтэрсэн байх нь тухайн ажилтанууд худал тоо баримтаар дээд албан тушаалтануудаа аргалан веерөө ажлаа хийсэн болж өнгөрөх хандлагыг гарцаагүй төрүүлэх бөгөөд эхэндээ байгууллага дотооддоо, цаавшиад байгууллагаас дээд байгууллага, албан тушаалтанaa худал мэдээ баримтаар аргалахад хүргэж энэ байдал криминологийн үзүүлэлтийн найдвартай байдлыг алдагдуулахад хүргээд байна.

Зөвхөн криминологийн судалгааг бодитой, бүрэн дүүрэн болгоход сергэер нэлэөвлөөд зогсохгүй гэмт явдалтай тэмцэх ажил хэрэгт бухажд нь сергэер нэлэөвлж байдаг эд хөрөнгө, зэвсэг, техник, санхүүгийн хангамжийн дутагдалтагийн байдлыг дурьдахгүй өнгөрч болохгүй. Ерөөсөө нийгэм дэх гэмт явдлыг хянах хүчирхэг материал техникийн бааз угүйзэр криминологийн судалгааны, гэмт явдалтай тэмцэх ажлын үр нэлэөг дээштүүлэх нь бараг боломжгүй зүйл юм.

Криминологийн үзүүлэлтийг илүү бодитой, үнэн зөв болгох үндсэн арга нь криминологийн судалгааг тодорхойгүй болгох буй дээр өгүүлсан хүчин зүйлсийн нэлэөллийг арилгах, саармагжуулах явдал болно.

Юуны өмнө статистикийн тоо баримтыг хуурмаглахыг ямарг эрмэлзэдэг улс төрийн, байгууллагын ашиг сонирхолын, үзэл суртлын нэлэөвлөөс тусгаарлах хэрэгтэй. Энэ тэрүүнд улс төрийн хүчин веерийн мөрийн хөтөлбөр, хөгжлийн үзэл баримтлалаа алдаагүй зөв болохыг нотлоход ашиглаад байгаа нэлэөнөөс тусгаарлах нь чухал.

Хоёрдугаарт, гэмт хэргийн талаарх байгууллага тус бурийн бүртгэлийг нэгтгэж улсын хэмжээнд нэгдсэн бүртгэл гаргах шаардлагатай байна. Энэ аливаа нэг байгууллага веерийн ашиг сонирхол, нэр хүндийг хадгалж үлдэх зорилгоор гэмт хэргийн тоо бүртгэлийг дураараа веерчлоед байх боломжийг хязгаарлах юм. Мен энэ тохиолдолд гэмт явдлын судалгааг нэгдсэн аргачилалаар хий боломж бурдэнэ.

Гуравдугаарт, Гэмт явдалд тавих хяналтыг илүү бодитой болгохын тулд цаашид авч хэрэгжүүлах шаардлагатай бас нэг чухал арга хэмжээ бол хууль сахиулах байгууллагын ачааллыг судлаж гаргах явдал болно. Хэрэг

бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид ноогдож буй хэргийн тоо, явуулах ажиллагааны ачааллыг тогтоосны үндсэн дээр цаашид хууль сахиулах байгууллагын орон тоо, төсөв, цалин хангамжийг тооцож гаргахын зэрэгцээ бидний хувьд энэ тоо баримт гэмт явдлын статистик үзүүлэлтийн найдвартай байдлын бас нэг шалгур болох учиртай.

Дарөвдүгээрт, гэмт явдалд тавих хяналтыг боловсронгуй болгохын тулд эрүүгийн тоо бүртгэл болон криминалистикийн бүртгэл мэдээллийн санг улам бур төгөлдөржүүлж, цаашид энэхүү мэдээллийн санг иргэний бүртгэл мэдээлэл, хүн амын орлого, зарлагын бүртгэл, татварын болон иргэний эрүүл мэндийн, эд хөрөнгийн гэх мэт бүх төрлийн бүртгал мэдээллийн сантай уялдуулан нэгдмэл байдлаар ашиглаж, өөр хооронд нь харьцуулан шалгаж найдвартай байдлыг нь тодорхойлж ашиглах шаардлагатай байна.

Тавдугаарт, социологийн судалгааны тусламжтайгаар гэмт явдлын бодит төвшинг тогтоох нь чухал байна юм. Иргэдээс өөрийнх нь эсрэг болон ойр дотных нь хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэрэг, хууль бус үйлдлийн талаар болон энэ хэрэг явдал хууль сахиулах байгууллагад бүртгэгдэж шалгагдсан эсэх талаар авах санал асуулгыг олон оронд нийт хүн амын дунд тодорхой хугацааны давтамжтайгаар авдаг бөгөөд (жилд, хагас жилд нэг удаа) нуугдмал гэмт явдлын төвшинг баримжаалахад тус болдог гэж үздэг байна.

**МОНГОЛ УЛСАД ТЕРРОРИЗМТАЙ
ТЭМЦЭХ ЭРХ ЗҮЙН
ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ**

Хууль зүйн магистр Л.Батдолгор

Монгол Улсад терроризмтай тэмцэх эрх зүйн орчин бүрдүүлэх талаар сүүлийн үед тэр засгаас анхаарч Монгол Улсын шинэ Эрүүгийн хуулинд хэд хэдэн заалт оруулж өгсөн байна. Монгол улс терроризмын эсрэг олон улсын зэвслэл байгуулахыг дэмжих тухай Монгол улсын Ерөнхийлөгчийн 60 дугаар зарлиг 2001 оны 10 дугаар сарын 3-ны едер гарсан юм.

Ерөнхийлөгч энэ зарлигтаа Монгол улс терроризмын эсрэг олон улсын зэвслэл байгуулах чармайлтыг тууштай дэмжих дипломат, хууль зүй, санхүү, цэрэг, тусгай албадын шугамаар эвслийн үйл ажиллагаанд еөрийн хувь нэмрийг оруулахад бэлэн байгаагаа мэдэгдэх чиглэлдийг Засгийн газарт өгч, 2001 оны 10 дугаар сарын 10-ны едер Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Ерөнхийлөгчийн уг зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Терроризмын эсрэг олон улсын зэвслийн үйл ажиллагааг дэмжих" тухай 226 дугаар тогтоол гаргажээ.

Энэ тогтоолоор Террористуудын талаар болон тадгээрийн санхүүжилтийн эх үүсвэр болсон хар тамхи, менгэ угаах үйл ажиллагааны талаар зэвслэл орсон улс орны холбогдох албадтай хуулийн хүрээнд мэдээлэл солицдох, хамтран ажиллахы Хууль зүй дотоод хэргийн сайд, Тагнуулын ерөнхий газарт үүрэг болгож, 2002 оны 12 дугаар сард Улаанбаатар хотноо болсон Терроризмын эсрэг олон улсын бага хуралд "Терроризмтай холбогдох эрх зүйн веерчлелт"-ийн талаар Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Ц.Шаравдорж дэлгэрэнгүй илтгэл тавьж, олны сонорт хүргжээ.

Терроризмын эсрэг дээрхи онол-практикийн бага хуралд Ц.Шаравдорж: "Монгол Улс азүүгийн хууль тогтоомждоо терроризмын гэмт үйлдэл хүн төрөлхтөний эсрэг, даян дэлхийн энх тайван, аюулгүй байдлын эсрэг гэмт хэргүүдийг Монгол Улсын Эрүүгийн хуулиар хүнд, онц хүнд гэмт хэргэгт тооцон аягилж зарим зохицуулалт хийж хуульчилсан нь чухал алхам болсоныг тэмдэглэж, гэхдээ алан хядах ажиллагаанаас урьдчилан сергийлэх, түүнтэй тэмцэхдээ үндэсний хууль тогтоомжийн шинчлэлд анхаарах зүйл нэлээд байгааг онцлон дурьдлаа. Тухайлбал терроризм буюу алан хядах ажиллагааны тухай ойлголтыг тодорхой болгож хуульчлах, алан хядах шинж бүхий гэмт хэргийн олон улсын жишиг стандартад хүргэх, олон улсын гарээ конвенцийн заалттай нийцүүлэх шаардлага бий гэж цохон тэмдэглэсэн юм. Би судлаачийн хувьд үүнтэй санал нийлж байна.

Цаашид терроризмтай тэмцэх эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, ялангуяа террорийн гэмт явдалтай тагнуулын байгууллага, цагдаагийн байгууллагын эруүгийн цагдаагийн алба, хилийн тагнуулын алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын гүйцэтгэх ажлын үйл ажиллагааг хуулийн хүрээнд явуулах эрх зүйн орчин бурдуулэх, гүйцэтгэх ажлын энэ албад гүйцэтгэх ажил явуулаад олсон үр дүн /бүтээгдэхүүн/-г хуулийн дагуу хэрхэн борлуулхтай холбоотой зарим асуудлаар өөрийн бодол санааг нэмэрлэх гэсэн юм.

Өнөө үед Тагнуулын ерөнхий газар Монгол Улсын ЭБШХ-ын 27 дугаар зүйлийн 1-ээр тус байгууллагад харьяалулсан төр, нийгмийн зүтгэлтийн амь биед халдах, төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хүйвалдаан зохион байгуулах, хорлон сүйтгэх, төрлөөр устгах гэх зэрэг Монгол Улсын Эруүгийн хуульд зүйлчилсэнээр терроризмтай холбогдох зургаан төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг хүлээсэн байна.

Гэтэл террорын гэмт явдлын хуульчилсан тодорхойлолт гэж тайлбарлаад байгаа Монгол Улсын эрүүгийн хуулийн тусгай ангийн 177 зүйлд заасан гэмт хэргийг мөрдөн шалгах эрх Тагнуулын ерөнхий газарт хуулиар олгогдоогүй .

Энэ тухай дээр дурьдсан терроризмын зэрэг онол-практикийн бага хуралд илтгэл тавьсан академич С.Нарангэрэл терроризмтай тэмцэх, мөрдөн шалгах, гэмт үйлдлийг таслан зогсооход тусгай албад, тагнуулын байгууллага чухал үүрэгтэй боловч ЭБШХ-ийн 27 дугаар зүйлд зааснаас үзүүхэд Тагнуулын ерөнхий газрын мөрдөн байцаалтын харьяалалд уг хэргийг хамруулаагүй байна тэж онцлон тэмдэглэснийг зөвшөөрч байна.

Монгол улсад террор, терроризмын тухай өнөө хэр нь тогтоон цэгцтэй ойлголт, тодорхойлолт бий болоогүй байна. Монгол Улсын Эрүүгийн хуульд "зандалчлах" гэж оруулсан зүйлийн нэр ч, агуулга ч террорын гэмт явдлын бүрэн утгыг илэрхийлэхгүй байна. Террор терроризм гэсэн нэр томъёог олон улсын жишгээр уг нэрийг хэвзэр нь хэрэглэх нь зүйтэй гэж үздэг судлаачидтай санал нэг байна

Террорын гэмт явдалтай тэмцэл явуулж байгаа олон улсын туршлагаас үзүүхэд террорын гэмт явдал нь нарийн зохион байгуулалттай, далд нууц аргаар үйлдэгддэг, тусгай албадад хэрэглэгддэг аргуудыг зээлдэн авч хэрэглэдэг, тэр ч байтугай өөрийн тагнуул, серх тагнуулын албатай болсон гэж ном хэвлэлд бичсээр байна..

Террорын гэмт явдалд тусгай албадад урьд өмнө нь ажиллаж байсан буюу ажиллаж байгаа ажилнуудыг татан оролцуулдаг нь ховор биш байна. Хууль хяналтын байгууллага, түүний дотор тусгай албадад өөрийн хань хамсватныг нэвтрүүлэхийг террорын гэмт явдал зохион байгууллагич гол зорилго болгодог нь нотлогджээ. Түүнээс гадна гүйцэтгэх ажлын байгууллагад хэрэглэгддэг нууцаар чагнах хэрэгсэл, нууцаар харах хэрэгсэл, гүйцэтгэх ажлын бусад хэрэгслүүд ч террорын гэмт явдал, зохион байгуулалттай гэмт хэргийн этгээдүүдэд ашиглагдаж түүний зэрэг гүйцэтгэх ажлын арга хэрэгсэл ашиглаж мөрдөн шалгах тэмцэх ажиллагаа олон улсын хэмжээнд давамгайлах хандлагатай байна..

Үүнээс үндэслээд гүйцэтгэх ажлын үйл ажиллагаа явуулахад хэрэглэгддэг гол аргуудыг "Гүйцэтгэх ажлын тухай хууль"-д хуульчилж егех нь тулгамдсан асуудал болсныг тэмдэглэж байна. Гүйцэтгэх ажлын нууц мөрдөн шалгах ажиллагаанд голчлон хэрэглэгддэг гүйцэтгэх ажлын асуулга тавих, нууцаар лавлагaa гаргуулах, харьцуулан шинжилгээ хийхийн тулд дээж загвар цуглуулах, шалгаль хийж зорилгоор худалдан авах, эд зүйлс ба баримт бичгийг шинжлэх, хууль бус зөвверлэлтийг хяналтад авах, гүйцэтгэх ажлын ажиглалт /хяналт/ хийх, бие хүнийг нууцаар таниулах, байшин барилга, ерөө тасалгаа, орон сууц, эзэмшил газар, тээврийн хэрэгсэлд нууц үзлэг хийх, шуудангаар илгээсэн зүйлс, цахилгаан ба бусад харилцааны мэдээлэлд хяналт тавих, утсан харилцааны яриаг чагнах, холбооны техникин сувгаас мэдээлэл олж авах, гүйцэтгэх ажлын нэвтрэх арга хэмжээг зохион байгуулах, гүйцэтгэх ажлын туршилт хийх гэсэн аргуудыг ОХУ "Гүйцэтгэх-эрэн" сурвалжлах ажиллагааны тухай" хуульдаа /1995 онд/ хуульчилсан байна. Эдгээр аргууд бол дэлхийн зонхилох тусгай албадад хэрэглэгддэг аргууд юм.

1997 онд Монгол Улсын Их Хурлын батлан гаргасан гүйцэтгэх ажлын тухай хуулийн төслийг хэлэлцэх уед Улсын Их Хурлын гишүүн Ц.Нямдорж "Гүйцэтгэх ажлын тухай" хуулийн тесел санаачлахдаа гүйцэтгэх ажлын дээр дурьдсан аргуудын ихэнхийг уг төсөлдөө оруулсан байсан боловч харамсалтай нь дэмжигдээгүй билээ.

Мен Улсын Их Хурлаар батлагдан гарсан "Гүйцэтгэх ажлын тухай" хуульд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди бүхэлд нь хориг тавихдаа, уг хориг тавьсан үндэслэлийн гуравдугаарт: "Хуулиар зайлшгүй зохицуулбал зохих гүйцэтгэх ажлын аргатал холбоотой асуудлыг хуульд тусгаагүй орхисон байна" гэж тэмдэглэсэн боловч Улсын Их хурал Ерөнхийлөгчийн хоригийг хулээх аваагүй юм.

Үүнээс гадна гүйцэтгэх ажлын үйл ажиллагаа явуулах, хэрэг шалгах явцад олсон мэдээ салт /үр дүн/, баримтгэй үзүүлж хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа, шүүн таслах ажиллагаанд нотлох баримтын хэмжээнд нотолгоо болгож ашиглах ажиллагаагаа хуулийн хүрээнд зохицуулах асуудал ч учир дутагдалтай байсаар байна. Энэ асуудлын практик ажиллагаанд одоо хүртэл ахиц гарахгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан баримт сэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлж болно гэсэн ЭБШХ-ийн 79 дүгээр зүйлийн заалт нь гүйцэтгэх албадын хөдөлмөр гаргаж олсон ажлын үр дүнг ашиглаж ч болно, ашиглахгүй ч байж болно гэсэн хоёрдмол уттатай заалт болжээ гэж боддог. Мен хуулийн 92 дугаар зүйлд "хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор нь талуудын хүсэлт болон өөрийн санаачлагагаар гүйцэтгэх ажил эрхэлж байгаа байгууллагаас хэрэгт ач холбогдол бүхий эд мөрийн баримт сэлтийг гаргуулож авах эрхтэй" гэсэн заалт бий. Гэсэн ч ЭБШХ-д гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий хад хэдэн албадын гүйцэтгэх ажлын үйл ажиллагааны үр дун /бүтээгдэхүүн/-г хэрэглэх тухай гүйцэтгэх албатай хамтран ажиллах ажиллагааг зохицуулсан заалт байхгүй байна.

Террорын гэмт явдалтай тэмцэж буй гадаадын олон орны хууль сахиулах байгууллагын туршлагаас үзэхэд террорын гэмт хэргээс сэргэжлүүлэх, урьдчилан сэргийлэх, шуурхай илрүүлиж таслан зогсоохын тулд гүйцэтгэх ажил, мөрдэн байцаах ажлын хамтарсан баг байгуулж гүйцэтгэх ажил явуулж олсон мэдээллийн дагуу шуурхай агаа хэмжээ авснаар томоохон үр дүнд хурдэг байна. Тийм учраас гүйцэтгэх албад, мөрдэн байцаах албадын хоорондын харилцан ажиллагааг зохицуулах эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох шаардлагатай гэж үзэж байна.

Өнөө уеийн эрх зүйн олон шинжлэх ухаанаас гадна "Гүйцэтгэх, ажлын эрх зүйн шинжлэх ухаан" гэж хууль эрх зүйн салбар шинжлэх ухван бий болжээ. Эрх зүйн энэ салбар шинжлэх ухааныг манай эрх зүйч эрдэмтэн судлаачид Монгол улсад хөгжүүлж гарын авлага, сурх бичиг, судалгааны материал бэлтгэж ядахдаа эхний эзлжинд хэрэг бүртгэгч, мөрдэн байцаагч нар, прокурор, шүүгчид, төрийн сургалттай болон магадлан итгэмжлэгдсан хуулийн бусад дээд сургуульд суралцагчдад "Гүйцэтгэх ажлын эрх зүй" эсхүл "Гүйцэтгэх ажлын эрх зүйн үндэс" тасэн хичээлийг сургалтын хөтөлбөрт оруулж заах хэрэгтэй гэсэн саналтай байна.

Гүйцэтгэх ажлын үйл ажиллагааны хуулийн зохицуулалтын зохих хэмжээний мэдлэгүйгээр гүйцэтгэх ажлын үйл ажиллагааг явуулдаг байгууллага болон мөрдөн байцаагч нар, хяналт тавьдаг прокурор, хэрэг таслан шийдвэрлэдэг шүүгч нарын ажлын уялдаа хөлбоо няятарч террор мэтийн нууц далд аргаар үйлдэгддэг онц хүнд хэрлүүд авсаар илрэхгүй.

ОХУ-ын Хууль зүйн ухааны доктор А.Ю. Шумилов "Орчин үед хууль хамгаалах байгууллага ба тусгай албадын гүйцэтгэх ажлын үйл ажиллагааг зохицуулдаг эрх зүйн гүнзгий мэдлэгтүй хуульч өөрийгөө индер мэдлэгтэй гэж тооцоохын аргагүй болжээ. Эрх зүйн салбар дахь өнөөгийн бодит байдал ийм байна". гэж хэлсэн нь бас ч гүн гүнзгий учир утгатай байна. Гүйцэтгэх ажлын зохих мэдлэгтэй болсоноор манай хуульчид террор мэтийн хүнд, онц хүнд гэмт хэргийн илрүүлэхэд гүйцэтгэх ажлын арга хэрэглэж нотолгоо болох зүйлийг олохын давуутай талыг олж харахад ахиц гарна гэж найдаж байна.

ШҮҮН ТАСЛАХ АЖИЛЛАГААНД ПРОКУРОР
ЯЛЛАХ ҮҮРЭГТЭЙ ОРОЛЦДОГ

Нийслэлийн прокурорын газрын
хяналтын прокурор Е.Сагсай

/Шүүн таслах ажиллагааг
мэтгэлцээний үндсэн дээр
явуулах талаар хяналтын
прокурорын эргэцүүллийг
толилуулж байна/.

Монгол Улсын шинэ Эрүүгийн болон ЭБШХ хэрэгжээд нэг жил гаруй боллоо. Энэ нь Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх салбарт хүний эрхийг туштай хамгаалах, хууль дээдлэх талаархи Үндсэн хуулийн заалтыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөхөд чухал алхам боллоо. УИХ-ас батлан гаргасан энэхүү хууль нь хууль, эрх зүйн ажлын дадлага туршлагатай практикийн болон удирдах ажилтнууд, хууль зүйн шинждэх ухааны эрдэмтдийн оюун ухаанаар тунгаагдсан, олон улсын хууль эрх зүйн орчин үеийн жишиг чиг хандлагыг тусгасан, онол практикийн өндөр түвшинд боловсруулагдсан сайн хуулид болсон гэдэгтэй практикийн ажилттан миний бие санал нэгтэй байна. Шинэ ЭБШХ-ийн үзэл баримтлал, үндсэн зарчмын шинжтэй нэг гол асуудал бол шүүх хуралдааныг мэтгэлцээний үндсэн дээр явуулах тухай асуудал юм.

1994 онд ЭБШХ-д оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр анхан шатны болон давж заалдах шатны шүүх хуралдааныг мэтгэлцээ зарчмаар явуулахаар хуульчилсан нь хууль зүйн утгаараа шүүгээгчийн гэм буруутай эсэхийг бүх талаас нь бүрэн бодитойгоор тогтооход чиглэгдсэн анхны алхам байсан гэдгийг угүйсгэхгүй байна. Шүүн таслах ажиллагааг мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчмыг хэрэгжүүлэхэд оролцож нь яллах тал юм. Шинэ ЭБШХ-д зааснаар яллах тал гэдэгт зөвхөн прокурорыг хамааруулж томъёолсон байна. Зарим улс орнуудад яллах талд хохирогч, түүний төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч тэдэнтэй хууль ёсны төлөөлөгчдийг оруулж тооцдог бөгөөд биелэлийн хувьд ч тэгэж үздэг байна.

Яллах тал болох прокурор нь Үндсэн хуулийн 56 дугаар зүйл болон ЭБШХ-д заасан чиг үүргийн хүрээнд шүүн таслах ажиллагаанд мэтгэлцээний нэг тал болон оролцож, улсын яллагчийн үүргийг гүйцэтгэж, шүүгдэгчид сонсгосон ялын нотлох үүргийг хэрэгжүүлж байна. Үүний тулд шүүн таслах ажиллагааг мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчмыг хангахад оролцох прокурорын оролцоо нь дараахь байдлаар илрэх хэрэгжих байна гэж үзэж болохоор байна. Үнд:

1. Эрүүгийн хэргийг анхан шатны шуухийн шүүх хуралдаанаар хэлэлцэх үндэслэл нь зөвхөн прокурорын үйлдсэн яллах дүгнэлт болон прокурор баталсан хэрэг бүртгэгчийн яллагдагчаар татах тухай тогтоол болдог.

ПРОКУРОРЫН ХЯНАЛТ

2. Улсын яллагч нь прокурорын яллах дүгнэлт, эсхүл яллагчаар татах тухай тогтоолыг уншиж сонсгохоос шүүхийн хэлэлцүүлэг эхэлдэг.

3. Улсын яллагч нь шүүх хуралдааны журам, уг хуралдаанд зайлшгүй оролцуулбал зохих этгээд, бусад оролцогчдын гаргасан санал хүснэгт, шүүх хуралдааны явцад шийдвэрлэж байгаа асуудлын талаар санал гаргахавс гадна шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж үндэслэлгүй, хууль зөрчсөн гэж үзвэл эсргүүцэл бичдэг.

4. Улсын яллагч нь шүүгдэгчийн үйлдсэн гэмт хэрэгт ял ногдуулахад баримтлах Эрүүгийн хуулийн зүйл, хэсэг, хэргийн байдал, хэргэгтийн санаа зорилго, арга, хэлбэр, садэлт, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл, шалтгаан, хэргийг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлууд, шүүгдэгчид ногдуулах ялын төрөл, хэмжээ, хорх ял эдлүүлэх дэглэмийн болон бусад асуудлаар дүгнэлтээ шүүхэд гаргадаг.

5. Шүүхийн хэлэлцүүлгээр шүүгдэгч гэм буруугүй болох нь нотлогдсон, эсхүл хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шаардлагатай гэж улсын яллагч үзсэн бол ялахаас татгалзаж, санаалаа бичгээр гаргана. Энэ нь шүүхээс шүүгдэгчийг цагаатгах буюу хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаах шууд үндэслэл болдог.

6. Терийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж улсын яллагч үзсэн бол иргэний нэхэмжлэл гаргах буюу гаргасан нэхэмжлэлийг дэмжих эрхийг хуулиар залдэг. Түүнчлэн Эрүүгийн хуульд заасан хөнгөн хэргийн хохирогч нь яллагдагчийн эрхшээлд байгаагас, эсхүл шалтгааны улмаас өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадахгүй тохиолдолд прокурор хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шилжүүлэх эрхтэй байдаг.

Эндээс үзэхэд анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг мэтгэлцэний үндсэн дээр явуулах зарчмыг хэргэжүүлэхэд хамгийн идэвхитэй үүрэг бүхий нэг тал нь улсын яллагч болох нь тодорхой. Негеөн талаар Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийн хэргийг шүүн таслах ажиллагаанд терийн ашиг сонирхол заавал хөндөгдөх учраас үүнийг тэр төлөөлен оролцдог прокурор гүйцэтгэдэг нь мэдрэж билээ.

Анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааг мэтгэлцээний үндсэн дээр явуулах талаар хуулиар тогтоосон зарчмыг хэрэгжүүлэх бодит боломж мэтгэлцүүлэн шүүх явдал зайлшгүй шаардлагатай эсэх талаар өөрийн бодлоо илэрхийлье.

1. Мэтгэлцэх зарчим нь барууны улс орнуудад сонгодог утта агуулгаараа хэрэгждэг зарчим юм. Гэтэл 1992 онд баталсан шинэ Үндсэн хуулиар манай улс хууль дээдлэх зарчмыг сонгсоноороо эх газрын эрх зүйн тогтолцоотой улс орнуудын буулд хамаарч үндсэндээ хуучин уламжлалаа хадгалийг үлдсэн юм.

Эх газрын эрх зүйн бүлд хамаарах улс орнуудад мэтгэлцэх зарчим төдийлиен үйлчилдэгтүй болох нь зарим улс орнуудын хууль тогтоомжоос тодорхой харагддаг. Эндээс үзэхэд анхан шатны шүүх хуралдааныг

3. Marttineauin tixen accyjatan aix 1994 oia 36x4-
hemwet. Deepwatered pak dixatxet haxha mahrli doon jaxk sarranet warri
muyxun wuxk xypandarlar narttunex sapinnaa raybyura rck hundaa xatty
tibootsoos sapinnaa sonuk, xyynta tyrcatun doona xepnusciyil qish
hp ych goint tixx doon yuucn rayattun hex a maprayxyl gusee. Ena hp
her tixxap myxk myxkuuq gahyuuq gahyuuq
Gahyuuq, here traaneek myxk myxkuuq gahyuuq
dahmaraancen saek gahyuuq myxk myxkuuq
am raxxy cyypallar, san, sondoo, xepnusaa meejattunin qulaxx ahan
xekkeray, qanu saorin qanu xekkeray manan opbi xypala mettunuehniur
cothajor ytrap xepnusaa somonohuun gahyuuq gahyuuq
gahyuuq gahyuuq.

Гарна, Димитър СЕЛЕЦКИИ спечели съдържанието на турнира и също така и наградата за най-добър мачаник. Трето място беше спечелено от Георги ГЕОРГИЕВ, който също имаше награда за най-добър треньор.

үйлчилдэггүй улс орнуудад шүүх хуралдааныг мэтгэлцээний үндсэн дээр явуулдаг, шүүх хуралдаанд оролцогчид чөлөөтэй, эрх тэгш мэтгэлцэдгэ явдал байдгийг ч бид мэдэх билээ. Тэгэхээр мэтгэлцэх зарчмаасаа шүүн таслах ажиллагааг мэтгэлцээний үндсэн дээр явуулах чиг хандлага руушилжүүлсэн, өөрөөр хэлбэл “хатуу мэтгэлцэх” зарчмаас үзэл баримтлалын хувьд татгалзсан хууль болсон байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

4.Шүүн таслах ажиллагааг мэтгэлцээний үндсэн дээр явуулах зарчмын талаар анхаарах өөр нэг асуудал нь хэрэг бүртгэх, мөрден байцаах ажиллагааны тухай юм. Өнөөдөр манайд Хэрэг бүртгэлтэй, мөрден байцаалтын шатанд эруүгийн хэргийн нотлох баримтыг цуглуулах, бажижуулзах үүргийг төр дангараа өөр хэнтэй ч хуваалцахгүйгээр хэрэгжүүлж байгаа, өөрөөр хэлбэл хэрэг бүртгэх, мөрден байцаах ажиллагааны явцад ямар ч мэтгэлцээний тухай болон мэтгэлцээний үндсэн дээр явуулах тухай яриа огт байхгүй байгаа явдал юм. Харин гагцхүү хүний эрх, эрх чөлөөг хангах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааг хуулийн хүрээнд явуулах, хууль зөрчүүлэхгүй байцаах шаардлагын үүднээс өмгөөллийн болон эрх зүйн туслацааг Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчдод үзүүлж байгаа нь мэтгэлцээнтэй холбоогүй юм.

Хэрэг бүртгэх, мөрден байцаах ажиллагааг зөвхөн төр, түүнийг төвлөөлсөн байгууллага, албан тушаалтнууд эрхэлж байгаа тохиолдолд гэв гэнэтхэн шүүх хуралдааныг мэтгэлцэх үндсэн дээр явуулна гэдэг нь хир зэрэг оновчтой хувилбар байх юм бол гэсэн эргэлзээ байна. Хэргийн бодит үзүүн нь зөвхөн шүүх хуралдааны мэтгэлцээний эзцийн үр дүнд тодрох уу, эсхүл хэрэг бүртгэх, мөрден байцаах ажиллагааны бодит үр дүн үү гэдэг асуудал бас л үзэл баримтлалын шинжтэй асуудал юм. Миний хувьд хэрэг бүртгэлтэй, мөрден байцаалтын ажиллагааны явцад хэргийн бодит үр дүн ихэнх тохиолдолд тодордог гэдэгтэй санал нэг байна. Иймээс шүүн таслах ажиллагааг мэтгэлцүүлэн шүүсэн, эсхүл байцаан шүүсэн эсэхээс үл хамааран шүүх хуралдаан хуульд заасан үндэслэл журмынхаяа дагуу явагддаг шүүх, шүүгч прокурор, өмгөөлөгч болон бусад оролцогчдын оролцоотойгоор шүүхээс эзцийн шийдвэр гаргах нь мэдээжийн зүйл билээ.

Даяарчлалын эрин үед эрх зүйн булгүүдийн сонгодог хэлбэрүүдээс мэтгэлцээнийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзвэл сонгодог утгаар нь яллах өмгөөлөх талуудын чиг үүргийг түйлийн тодорхой болгох хуульчлан тогтоох, шүүхийн мэтгэлцээнд хөндлөнгийн шинжтэй байж хууль хэрэглэдэг болгох нь зүйтэй. Үндсэн хуулиараа сонгож авсан замаараа явна гэвэл мэтгэлцээний зарчмын болгон авсан үзэл баримтлалаасаа татгалзаж, шүүн таслах ажиллагааг тэгш эрх бүхий талуудын мэтгэлцээний үндсэн дээр явуулдаг байж ядлыг зарчмын хувьд биш, үйл ажиллагааны хувьд хүлээн зөвшөөрөх нь зүйтэй байна гэсэн саналтай байна.

தினம் நிலைகளைப் பற்றி பல்கலைக் கழகங்கள் முன்வரியில் பார்த்து அனுபவம் பெற விரும்புகிறது. பல்கலைக் கழகங்கள் முன்வரியில் பார்த்து அனுபவம் பெற விரும்புகிறது.

Изменение вида гигиенических мероприятий тесно связана с изменением технологии выращивания растений. Важнейшим фактором, определяющим вид гигиенических мероприятий, является характер выращивания растений. Наиболее распространенным видом выращивания являются тепличные выращивания. Важнейшим фактором, определяющим вид гигиенических мероприятий, является характер выращивания растений. Наиболее распространенным видом выращивания являются тепличные выращивания.

Geppa hoxnoodoohi nullyahhun mappahler rajaian nunge
wesparukinmachee rottbyy repuhn byc Geppa hoxnoodoohi nullyahhun mappahler rajaian nunge
tateborer deeb xyywah mapkakdec ekuunax xycamela byx xyywah
Geyyaynmarin geyt byt tow yahn vhyean otte mehet he txeayn hyihir
tacraax amkunurareah opohnox xek orrux Geyy
Geppa hoxnoodoohi nullyahhun mappahler rajaian nunge

ATHY-PIH A3UHN 3P3 ZJUH UHCNUMMYMRH 3AUXUPAN KHOI Chyprouk /FlexacphiH Bechnauh xWym 3JUH ux cgsyppuR

Xylym 3yñh tunkutax yxaahpi qonmop f.Cobd.
Yazylqasim nom.

1. **Introduction:** The study of the relationship between the properties of materials and their microstructure has been a major focus of research in recent years. This paper aims to review the current state of knowledge in this field, highlighting key findings and identifying areas for future research.

ГИХХОГОД ДАВГААСААНЫХ НИЧИҮҮЛӨН

BAPIH HATACAH XONBOOBI
YHACAH MUNHK HAHP

ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

аливаа хэлбэр, журмын дагуу уг үйл ажиллагааг эрхэлж болох боловч тухайн муж улсын Барын холбооны жилийн татварыг зайлшгүй төлөх үүрэгтэй байдаг.

Тодорхой хэрэг шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцох эсвэл нэг удаагийн ажил үйлчилгээ үзүүлэх хүснэгтэй гадаадын хуульч мэргэжилтэн нь тухайн шүүхэд өргөдөл гаргах журмаар хязгаарлагдмал эрхтэйгээр /хэрэг бүхэн дээр энэ журмыг баримтлах/ оролцож болох боловч тухайн улсын зохиц эрх бүхий өмгөөлөгчтэй хамтран оролцох шаардлага бас тавигддаг юм.

Энэхүү хязгаарлагдмал өмгөөллийн үйл ажиллагаа нь гадаадын хуульчийг тухайн улсын Барын холбооны гишүүн байхыг шаарддагтуй чөөр ямар нэг муж улсын шүүхийн шүүн таслах ажиллагаанд оролцох эрх олж авсан байхыг шаарддаг. Барын нэгдсэн холбоо нь энэ утгаараа тухайн муж улсын нутаг дэвсгэрийн хүрээнд шүүн таслах ажиллагаанд оролцох үйл ажиллагааг зохицуулдаг хаалттай систем юм.

Үндсэн элементууд нь:

1. Үндсэн хууль буюу веер хууль тогтоомжоор Дээд шүүхэд тухайн муж улсын Барын холбоонд пишүүнээр элсэх болон үйл ажиллагаанд нь хяналт тавих бүрэн эрх олгогдсон байх.

2. Шүүх нь Барын холбоонд элсэх стандартыг тогтоох үүрэг хариуцлагыг хүлээж түүгээрээ хэнийг "Өмгөөлөгч" буюу хууль зүйн үйл ажиллагаа явуулах эрх бүхий хүн гэх асуудал дээр хяналт тавих.

3. Шүүхээс шүүн таслах ажиллагаанд оролцоход баримтлах дүрэм, журам тогтоох,

4. Шүүх нь шүүхийн байгууллагын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах,

5. Шүүхээс өмгөөлөгчийн сахилгын дүрмийг батлан гаргаж, ёс зүйн болон мэргэжлийн стандартыг тогтоох,

6. Шүүх нь өмгөөлөгч, шүүгч нарын сахилгын хэргийг хэлэлцэн шийдвэрлэх,

7. Өмгөөлөгч бүр Барын нэгдсэн холбооны гишүүн байх.

Техас муж улсын хувьд түүхэн уламжлалтай нэг онцлог шинж байдаг бөгөөд энэ нь шүүгчээр ажиллах хэн боловч хамгийн доод шатны шүүхийн болон Ээ звийн шүүхийн өмгөөлөгчдийн холбооны гишүүн байх шаардлага юм.

Эрх мэдлийн тэнцвэртэй байдал

Өмгөөлөгчдийн мэргэжлийн түвшинг тодорхойлж, лиценз олгох системийг шүүхээс тогтоож хэрэгжүүлэхдээ төрөл бүрийн арга замыг хэрэглэж болдог. Түүнчлэн, Засгийн газар нь аливаа төрийн байгууллага, тэр ч байтугай шүүх эрх мэдлийн үйл ажиллагаанд шүүх эрх мэдэлтэй эрх мэдлээ хуваалцах тун дургүй байдаг. Тийм ч учраас шүүх эрх мэдэл веөө засаглалын нэн хүчтэй салбар болж бүрэлдэх хүртэл хууль тогтоогч нь /Үндсэн хуулиар хориглоогүй бол/ шүүхэд шүүн таслах үйл ажиллагаа явуулах журам, шүүн таслах ажиллагаанд оролцож зөвшөөрлийн лицензи олгох, түүнийг хасах шалгуур, шаардлагуудыг шүүхэд шууд тулган тогтоох

texac myk yrcpin myyx spx map3n

Barbararacc ym mawrtraethau amreiniannol yn Bedr-hirion oeddor sefyllfa ar ymddyngau hir traddodiadol oedd yng Nghymru. Gweler i'r drafodau'n ddilys i ddarparu ymddyngau hir traddodiadol i'r gogledd Cymru.

ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

нэгдсэн системийн ўйл ажиллагаа нь зохих ёсоор явагддаг, үнэнч шударга эрх зүйн системийг бурдуулэхэд чиглэгдэх ёстой билээ.

ТЕХАС МУЖ УЛСЫН БАР-ЫН ХУУЛЬ

Техас муж улсын одоогийн хучин төгөлдөр үйлчилж байгаа Бар-ын хууль нь Засгийн газрын хууль зүйн салбар дахь захиргааны агентлаг бөгөөд төрийн бус, олон нийтийн үүсгал санаачилгын байгууллага юм. Энэхүү хууль нь шүүх эрх мэдлийг байгууллагудаас Үндсэн хуулиар олгогдсон шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх ўйл ажиллагааг нь зохицуулахад чиглэгдэг. Дээд шүүх нь муж улсын Бар-ын холбооны ўйл ажиллагаанд ханалт тавих үүргэг хулаадгээ. /Tex. Gov't Code, 81.011/.

Мөн хууль нь муж улсын Бар-ын холбооны ўйл ажиллагаа нь хуульч мэргэжилтийээс олон нийтийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагaa зохих ёсоор биелүүлэх явдлыг хангахад ўйл ажиллагаа чиглэгдэх ёстойг тусгайлан зааж өгчээ. Энэ зорилтыг дараах байдлаар хуульчилжээ:

1. шуухээс шүүн таслах ўйл ажиллагааны чанарыг дээшлүүлэхэд чиглүүлэх;
2. олон нийтэд үзүүлэх эрх зүйн үйлмилгээний чанар ба үүнд хуульчдын гүйцэтгэх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх;
3. шүүн таслах ажиллагаанд оролцож буй хуульчдын шударга байдал, ур чадварыг дээшлүүлж, зохиц түвшинд байлагч, олон нийтийн итгэл найдвартыг хүлээх ёс зүйн хэмжээстэй байхад сурхаж;
4. муж улсын Бар-ын холбооны гишүүдийг мэргэжлийн зохих хэлбэрийн үйлчилгээгээр хангах;
5. орон нутгийн Бар-ын холбоодыг бүрэлдэн тогтох, ўйл ажиллагаанд нь дэмжлэг туслалцаа үзүүлэх;
6. шүүн таслах ўйл ажиллагаа явуулахад хамааралтай эрх зүйн шинжлэх ухаан, эрх зүйн шинэчлэл, Бар-ын холбоо олон нийтийн харилцааны асуудлаар чуулга, уулзалт, ярилцлага зохион байгуулах;
7. хуулийн б 6 дугаар дэд бүлэгт заасан асуудалтай холбогдолтой мэдээллийг /Tex. Govt Code, 81.012/ хэвлэн нийтлүүлэх асуудал зэрэг болно.

Муж улсын Бар-ын холбооны хуульд заасны дагуу Дээд шүүх нь олон жилийн түрш Муж улсын бар-ын холбооны дурэм, журмыг тогтоож ирсан. Үүнд: Мэргэжлийн ёс зүйн дурэм /өмгөөлөгчдийн/, Сахилгын шийтгэл хулээлгэх дурэм, ба Үндсэн хуульд заасан эрх хэмжээний дагуу Шүүгчдийн ёс зүйн дурэм. Муж улсын нэрийн өмнөөс хуульчдад лиценз олгох үүргээ Дээд шуухээс биелүүлэхэд нь туслалцаа үзүүлэх үүднээс хууль тогтоогч Хуульчдаас шалглалт авах зөвлөлийг бий болгосон. Энэ зөвлөл нь Дээд шуухээс тогтоосон мэргэшшийн шаардлага, шалгуурыг хангасан, Дээд шуухээс томилогдох 9 өмгөөлөгчдээс бүрдэнэ. /Tex. Gov. Code, 82.01/

Мөн хуулиар хуульчдаас шалглалт авах эрх хэмжээ, шалгальтын журам тогтоо эрхийг Дээд шүүхэд тусгайлан олгосон байдаг. /Tex. Gov. Code, 82.02/

Зохион байгуулалтай Барын системийн үр ашиг

Зохион байгуулалт бүхий Барын системийн үр ашиг нь өмгөөлөгчдийн дунд өрсөлдөөний өрнүүлж, хуульч мэргэжлээр ажиллахыг хүснэгчдэд хүлээнгэх итгэлийг бий болгодогт оршдог. Мен энэ нь хуульч мэргэжлийн нэр хүндийг өргөж, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэн мэргэжлээрээс ажиллаж чадсан тэр хүн л жинхэнэ хуульч байх шаардлагад тохирдог. Энэ нь үнэхээр хууль тогтоочийн адил хууль тогтоо, тайлбарлах, хууль тогтоогид зөвлөх чадвар бүхий практикийн хуулычны бий болгоход чиглэдэг. Барын нэгдсэн холбоо нь мэргэжлээрээс ажиллаж байгаа хуульчдад нэгдсэн шаардлага тавьж, гишүүд нь бүгд ёс зүйн ижил хэв хэмжээ, нэг мөр практикийг даган мөрдөж буйн баталгааг бий болгодог.

Энэ нь мэргэжлээрээс ажиллах, шүүн таслах ажиллагаанд оролцохын тулд Барын холбооны гишүүн байхыг шаарддагаар дамжин хэрэгжин. Итгэл хүлээгээгүй болон ёс зүйн дутагдал гаргасан гомдол гарсан үндэслэлээр Барын холбооны гишүүний эдлэх давуу эрхийг алдах, үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулах, орлогын эх үүсэергүй болох зэрэг үр дагавараа мен адил хэрэгждэг гэж хэлж болно. Техас муж улсын Барын нэгдсэн холбоо нь 1939 онд хууль тогтоогочос Муж Улсын Барын хуулийг батлан гаргаснаас хойш өнөөдөрийг хүртэл муж улсын шүүх эрх мэдлийн салбарын захирагааны агентлаг хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ нь Техас муж улсын Шүүхийн зөвлөл ба Шүүхийн захирагааны байгууллагын хамтарсан үүрэг юм.

МОНГОЛ УЛСЫН БАРЫН НЭГДСЭН ТОГТОЛЦОО

Монгол улсын хувьд Барын холбоо байгуулснаас гарах үр, ашиг нь Монгол Улс бүрэн чөлөөт өрсөлдөөнт зах зээл рүү шилжин орж байгаа, иргэд хооронд үүсих хэрэг, маргааны тоо улам бур өсөн нэмэгдэж байгаатай уядах болно. Хяналттай системтэй, социалист зах зээлийн эдийн застийн үед маргачг талауд нь үйлдвэрлэл, худалдааны зүйлийг өмчлөх эрхийг байдгасв үүдэн маргааныг төрөөс зохицуулах зэрэг нь маш бага юм. Үйлдвэрлэлийн хэрэгслэл төрийн хялтаас гарч хувийн эзэмшилд шилжих тэр хэрээр здгэр зүйлсийг хэрэглэж ашиглах талаарх маргаан зайлшгүй үүсэн гарч ирдэг. Үүнээс улдлан здгэр маргааны тайван замаар шийдвэрлэх механизмыг яаралтай бий болгох хэрэгцээ үүсдэг билээ. Шүүх, захирагааны журам, арбитр, зуучлалын байгууллага ба өмгөөлөг, тусгай сургалтанд хамрагдсан логик сэтгэлгээ сайтай хумуус эзрэг талуудын ашиг сонирхлыг хамгаалан маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хүмүүс зэрэг бүх арга, механизмууд шаадлагатай болно.

Энэ бүх асуудлыг өөрийн цаг үедээ шийдвэрлэхэд, АНУ-ын Үндсэн хуулийг боловсруулагчид ба дээр үеийн териин зүтгэлтнүүдийн дийлэнхи хэсэг нь хуульчид байснаараа АНУ азтай байсан гэж хэлж болно. АНУ-ыг үндэслэгч эцгүүд Үндсэн хуулийн зүрх нь чөлөөт зах зээл гэж үзсэн билээ. Энэхүү систем нь Америкийн үндэстний тогтвортой байдлын үндэс суурь болж үйлдвэрлэлийн хэрэгсэл ба өмчийг хувийн өмч гэж үзсэн энэ байр суурь ба гэрээний эрхийг Америкийн ард түмний эрх гэж хүлээн зөвшөөрсөн билээ. Үүнтэй ижил үзэл баримтлал нь 1992 онд Монгол Улс шинэ үндсэн хууль батлагдан гарснаар 70 жилийн турш ноёрхж байсан

коммунист системийн нэлвөн дор үүсч байгаагүй шинэ асуудлуудыг үүсгэн гаргаж байна.

Зах зээлийн эдийн засагт хуульчид хэрэгцээтэй байх тухай гурван үндэслэл

Орчин үеийн улс үндэстний хувьд шүүгч, териин захирагааны түшмэл, өмгөөлөгч ба гэмт хэрэгтнийг мөрдөн шалгахаас өөр бас хуульчдын үйлчилгээ шаардлагатай байна. Энэ нь:

1. Хувь этгээдийн гэрээ /байгуулах ба хэрэгжүүлэх/ Өмч ба үйлдвэрлэлийн бусад хэрэгслэлийг хувьд өмчлөх явдал есөн нэмэгдэхийн хэрээр зах зээлийн зах зээлийн зохицуултанд орж буй улс үндэстний хувьд хувь этгээдийн гэрээний эрх зүйн зохицуулалтыг бүрэлдүүлэн бий болгох шаардлагыг урган гардаг. Гэрээний олонхи төрлийг хуульчилж болох хэлний ч боловч хууль тогтоогоочиж төсөөлж бараахгүй олон төрлийн гэрээг иргэд байгуулж, үүний хамгаалах аргутыг сэдэгтэй уялдан шүүхийн шийдвэрийг даган энэ хууль тогтоомж нь байнга хөдлөн хөгжих байдаг. Энэ бол маргалдач талуудыг шүүхэд төлөөлж асуудлыг хуулийн хүрээ, рамканд оруулан шийдвэр гаргахад нь шүүгчдийг аргачлалаар хангах өмгөөлөгчийг үйл ажиллагаа билээ. Гэрээний хэрэглээс ийнхүү есөх нь хуульчдаас гэрээ байгуулах, гэрээ зөрчихеес хамгаалах, үр дагаврыг шалгах хянахад өмгөөлөгчийн хувьд туслалцаа үзүүлэх буюу шүүгчийн суудлаас шийдвэрлэх зэрэг үйлчилгээ үзүүлэхийг шаарддаг юм.
2. Хувиараа өмчлөх ба ашиглах, өмчлөх эрхийг шилжүүлэх. Үл хедлөх ба бусад эд хөрөнгө өмчлөх үйл явц өсөхтэй уялдан үүнийг ашиглах, өмчлөх эрхийг шилжүүлэхээс тухай хууль тогтоомж, түүний дотор үл хедлөх ба бусад эд хөрөнгийн бүртгэлийн системийн шаардлага гарч ирах багаад үүнд мөн хуульчдын үйлчилгээ хэрэгтэй билээ. Монгол Улсын 1992 оны Үндэсний хуулиар хувийн өмчийн энэ эрхийг эрхийг хангаж өгсөн хэдий ч хууль тогтоомж, шүүхийн үйл ажиллагаа нь энэ үзээ баримтлалыг бодитойгоор хэрэгжүүлэх нэн ялангуяа төрөөс зөвшөөрөл олгодог, өмчье худалдаа асуудал өөреөр хэлбэл териин өмчийг хянах, өмчлөх эрхээ хязгаарлах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлэх боломжийг үнэн бодитойгоор бурдуулах асуудал гарч ирдэг. Энэ бүх шинэ мэргэшилд зохих ёссоор бэлтгэгдсэн, уч чадвар эзэмшиж хуульч мэргэжилтэнгүйгээр хувийн өмчийн ямар ч систем оршин тогтолцоогүй байдаг. Эс тээвэр энэхүү систем нь эмх замбаараагүй байдлыг үүсгэн териин албан тушаалтуудын хээл хахуулийг хөхүүлэн хохирол үүсгэх нөхцөл байдал зайлшгүй үүсгэдэг.
3. Гэм хорын асуудлыг шийдвэрлэх нь. Чөлөөт зах зээлийн үр дун буюу түүнээс үүсэн гарах гуравдахь гол салбар нь санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл, мөн хууль бус үйлдлээс үүсэн гарах гэм хор учруулсан гарах хариуцлагын асуудлыг асуудлыг шийдвэрлэх ажиллагаа байдаг. Хяналтын тогтолцоотой эдийн засагт дээрх үйлдэл, эс үйлдлээс үүсэн гарах хариуцлагыг өрөнхийдөө эрүүгийн эрх зүйгээр шийдвэрлэдэг. Хувийн өмчийн үзэл

баримтлалууний дотор оюуны өмчийн эрх бий болсноор бусад этгээдийн гэм хор учруулах үйлдэл, эс үйлдлээс эрх чөлөөтэй байх, санаатай буюу болгоомжгүй үйлдэл, эс үйлдэл, мөн хууль бус үйлдлээс учирсан хохирлыг нэхэн төлүүлэх эрхийн онол маш түргэн бүрэлдэх үүсдэг. Дахин дурдахаад, үүнтэй уялдан гэм хорын маргаан, нэхэмжилэлийг маргааныг шалгах, зөвлөлгөө өгөх, төлөөлөх хуульч мэргэжилтний хэрэгцээ шаардлага маш түргэн есч ирдэг. Эдгээр маргааныг шийдвэрлэх териин тогтолцоог бурдуулэх нь амархан боловч энд зохих ёсоор сургалтанд хамрагдсан өмгөөлөгч, хуульч мэргэжилтний хэрэгцээ нь одоо оршин тогтох байгаа хүнд суртны механизмыд зайлшгүй хэрэгтэй билээ. Чөлөөт зах зээлийн системийн эдгээр үндсэн шаардлага нь зохих ёсоор сургагдсан хуульч мэргэжилтний хэрэгцээ шаадлагын үндэслэл нь болж байна. Үүнд: Гэрзэний эрх зүйн асуудал, өмчийн асуудал ба гэм хорын хариуцлага.

Хуулийг боловсронгуй болгох асуудал

Хамгийн наад зах нь дээр дурдсан эрх зүйн гурван гол салбар нь засгийн газар үүнийг хүсч байгаа эсэхээс үл шалтгаалан үүсэн хөгждэг. Засгийн газраас үүнийг зохицуулалт хийж болох боловч энэ нь эдийн засаг дахь хувьчлалын шууд үр дүнтэй шууд уялддаг билээ. Бэлтгэл бухий улс үндэстэн үүнийг чөлөөт зах зээлийг нийгмийг цэцэглэн хөгжүүлэх нэг хэрэгсэл болгон ашигладаг.

Хуульч мэргэжилтэн бол энд хууль эрх зүйн "усан үзмийн талбай дахь ажилтан" гэсэн уг. Тэд төрөөс үр суулгуулалтын тулд талбайд мөр гарган борлуулах ажил гүйцэтгэх шарны үүрэг гүйцэтгэнэ гэсэн уг. Гэхдээ хуульч мэргэжилтний ажлын үр дүн нь тэр захиргааны байгууллага ажилтан, шүүх, болон бусад байгууллагын заавар удирдамжкаас хамаарч болох боловч иргэдийн эрх, үүргийн шинэ үзэл баримтлалыг хөгжүүлэлгүйээр нийгмийн хөгжил ахин дэвшинэ гэж төсөөлөх аргагүй. Хуульч мэргэжилтэн нь энд чөлөөт зах зээлийн эдийн засагт энэ нийгэмд сургалт мэдлэгээр дамжуулан бизнесийн практикийг хөгжүүлэх, хувь этгээдийн эрх үүргийг таныж, хүлээн зөвшөөрөхдөд удирдан чиглүүлэгч нь болдог.

Бизнес эрхлэгч нь мөнгөтэй, бүтээлч санаачилгатай, үйлдвэрлэл удирдан явуулах, бараа, таваар бүтээн гаргах эрх мэдэлтэй байж болно, гэхдээ маргаан үүсн гарах тохиолдолд хуульч мэргэжилтэн нь үүнийг тайван замаар шийдвэрлэхэд удирдан чилгуулэх ёстой.

Ийнхүү зохион байгуулалттай Бар-нь зах зээлийн систем бүрэлдэн бий болж тогтоноход маш чухал нелөө бүхий хууль эрх системийг боловсронгуй болгох салшгүй хэсэг мөн. Бар-ын нэгдсэн холбоо нь зохион байгуулалттай барын системийн маш оновчтны хэлбэр болдог. Энэ нь хуульч мэргэжилтний ажиллуулах системийг бурдуулэн бий болгох, хөгжүүлэх механизмаар хангаж өгдөг. Бар-ын ямар ч холбоо нь практикийн хуульчдын дунд өрслөдөн бий болгож, мэргэжлээ дээшшуулжийг шаардах, үзүүч шударга байдлыг дээшшуулж шударга бус болон итэл алдах байдлыг цээрлүүлдэг. Бар-ын нэгдсэн холбооны үзэл баримтлал нь бүх шүүгч, өмгөөлөгч ба прокурорыг Бар-ын холбооны пишүүн байхыг шаардахаас гадна холбооны дүрэм, журам, ба ёс зүйн дүрэмд

ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

захирагдахыг шаарддаг. Энэ бүхэн нь хууль тогтоогчоос тависан зорилго бүхий хүчин чармайлтыг нэгдмэл, нягтралтай, зохионб байгуулалтанд оруулдаг билээ. Үүнээс өөр хэлбэрийн дурьн байгууллага байх болохыг угүйсгэхгүй хэдий ч энсхүү системтэй адилхан ажиллаж чаддагтүй билээ.

АНУ-ЫН ХОЛБООНЫ БАРЫН СИСТЕМ

Эдгээр тайлбар, саналуудыг Монголын хуульч мэргэжилтнийг нэгтгэн зохион байгуулахаар нэгдмэл Барын системийн хэрэгцээг тодрохойлох асуудлыг үүсгэх зорилготой гаргасан юм. Энд АНУ-ЫН Барын холбоонд байгаа асуудлуудыг бүтгдиг хөндөж чадаагүй хэдий ч АНУ болоод нэгдмэл үндэстэн биш хэдий ч шүүхийн нэгдсэн тогтолцоотой орнуудад адилхан тохиолдож болох асуудлуудыг тусгалаа.

Монгол улсад өмгөөлгчдийг мэргэжлийн хувьд удирдан зохион байгуулахаар байгууллага хэрэгцээ улам өвч байгаа нь харагдах байна. АНУ-ЫН холбооны шүүхийн систем нь 50 муж улсын шүүхийн системээр ялгагддагийн нэг адил хуульч мэргэжлээр ажиллах зөвшөөрөл олгох систем нь мөн муж бүрийн шүүхээс тогтоосон журмын дагуу явагддаг. Жишигэлбэл Техас муж улсын хойд дүүргийн шүүхээс олгосон зөвшөөрлийн дагуу зөвхөн тэр нутаг дэвсгэрийн хүрээнд хуульч мэргэжлээр ажиллахыг зөвшөөрдэг бол холбооны тав дахь тойргийн давж заалдах шатны шүүхээс олгосон зөвшөөрлийн дагуу тэр шүүхийн тойротг т л үйл ажиллагааг явуулахыг зөвшөөрдэг.

Гэхдээ энэ бүх зөвшөөрөл нь муж улсын дээд шатны шүүхэд шалгалт өгснөөр олгогддог. Тийм ч учраас АНУ-ЫН холбооны шүүх нь өөрийн гэсэн Барын нэгдсэн холбоо байхгүйн улмаас холбооны шүүхийн шатанд үйл ажиллагаа явуулахын тулд ямар нэг муж улсын газар нутаг дээр шүүн таслах ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан байхыг шаарддаг. Энэхүү шаардлага нь холбооны зохих шатны шүүхэд өмгөөлөх үйл ажиллагаанд оролцохын тулд тэр шүүхээс тавих шаардлагыг хангасны үндсэн дээр зөвшөөрөл авах шаардлагатай харилцан шутэлцэж холбооны засийн газрын зүгээс өмгөөлгчдийн үйл ажиллагаанд тавих хянналтын механизмыг бурдуулдаг юм. Олон муж улсуудад хуульч мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл ба лиценз авахын тулд Барын холбооны гишүүнчлэлийг шаарддаг. Энэхүү Барын холбооны гишүүнчлэлийг заавал шаарддаг практик нь холбооны шүүхээс өмгөөлгчдийн үйл ажиллагаанд хянант тавих боломжийг олгодог юм.

Дүгнэлт

Нэг үндастнээс бурдсан гэж хэлж болох бүтэцтэй, нэгдмэл ганц шүүхийн тогтолцоотой Монгол улсад хуульч мэргэжлээр ажиллах хүсэл сонирхолтой хэн бүхэн заавал нэгдэж түүнд харьяалагдаж байхыг шаардсан. Барын нэгдмэл тогтолцог бурдуулэх нь Монгол улсын иргэдийн эрх чөлөөг хадгалан хамгаалахад тус дэм болох хамгийн тэгс систем байх юм. Өнөөдөйн байдлаар Монгол Улс өмгөөлгчдийн үйл ажиллагааг зохицуулах нэгдсэн буюу зохион байгуулалттай тогтолцоо нь зах зээлийн өрсөлдөөнт нийгэмд маш чухал ач холбогдолтой гэдгийг анхаарах хэрэгтэй.

Зохион байгуулалтгүй тогтолцоо нь хүнд суртлтын систем, нэн ялангуяа засгийн газрын хууль зүйн асуудлын хүрээнд байх нь нь зохимжгүй. Хэрэв хүн өөрийн амьдралыг удирдан зохион байгуулах эрх чөлөөтэй бол мөн алдаа хийх эрх чөлөөг бас здлэх ёстой. Энэүү гэм буруугийн болгоомжгүй хэлбэр, гэрээний зерчил, хүсэн хулээж байсан зүйлээ буруугаар төсөөлөх зэргээс үүсэн гарах энэхүү салбарт л хуульч мэргэжилтний хэрэгцээ маш их байдаг. Хуульч мэргэжилтэн нь олон төрлийн үйлчилгээ үзүүлдэг бөгөөд тэд нар нэн ялангуяа маргаан үүсэхээс урьдчилан сэргийлэх асуудлыг урьдчилан харж энэхүү гарч болох асуудлыг тайван замаар шийдвэрлэх үүднээс туслаачаа үзүүлэхийн тулд ажилладаг. Эдгээр өмгөөлөгч, хуульчдыг үндэсний хэмжээнд зохион байгуулж стандарттай сургалт явуулах нь шүүхийн үйл ажиллагааг системтэй болгоход нэн чухал ач холбогдолтой байдаг.

Монгол улс нь өөрийн шүүхийн тогтолцоог хуульчдыг сургах, тэдэнд багшахаа болон хуульч мэргэжлээр ажиллах эрх олгох, системтэй болгох чадсанаар гарах үр дун нь маш тааламжтай бөгөөд хэрэгтэй байх болно. Шүүхийн систем нь “Хууль дээдлэх” зарчмыг даган мөрдсөнөөр иргэний үндэснээс эрх чөлөөг здлэх орчинг жинхэнээр бурдүүлэх юм. Ийм ч уураас албан ёсны Барын гишүүнчлэл, мэргэжлийн дээшлүүлэх сургалтанд жил бүр хамрагдах шаардлага бий болгон шүүгч, өмгөөлөгч нарын ёс зүйн хатуу хэм хэмжээтэй дүрэмтэй байх нь Монгол Улсад хууль дээдлэг ёсыг Засгийн газар болон иргэд нь хобулаа хүндэлдэг болгох маш чухал нелоөтэй зүйл болох билээ.

Ашигласан материал

- Техас муж улсын Барын хууль
- Техас муж улсын хуульчийн мэргэжлийн ёс зүйн дүрэм
- Техас муж улсын өмгөөлөгчийн сахилгын дүрэм
- Мэргэжлийн хорооны дүрэм
- Шүүгчийн ёс зүйн дүрэм

НОТАРИАТ ИРГЭНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛДАГ

Монголын Нотариатчдын танхмын
мэдээллийн албаны ажилтан П.Отгонжаргал

Монгол улсын шинэ үндсэн хуулийн хүрээнд 1997 оны 5 дугаар сард Монгол Улсын Нотариатын тухай хууль батлагдан гарч, 2002 онд эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийн дагуу Иргэний хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Нотариатын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль зэрэг шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай холбогдсон олон хуулиуд батлагдан 2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хэрэгжжик эхэлснээр нотариатч, нотариатчийн үүрэг гүйцэтгэгчийн эрх хэмжээ ажлын ачаалал, үйлчилгээний төрөл, хамрах хүрээ өргөжиж нотариатын байгууллагын ач холбогдол улам ихэсч байна.

Нотариатч нар үйл ажиллагаагаа уялдуулсан зохицуулах үүднээс 1997 оноос Төрийн бус байгууллага болох Нотариатчдын танхмын зохион байгуулан ажиллаад 7 жилийн нүүр үзэж байгаа бөгөөд энэ нь нотариатчдын удирдах дээд байгууллага юм. Иргэд, байгууллага аль нь ч Нотариатын байгууллага, нотариатчийн талаарх санаал, хүсслэл, гомдлоо дээрх байгууллагад гарган шийдвэрлүүлэх боломжтой.

Нотариатч бол төрөөс тогтоосон журмын дагуу нотариатын үйлдэл хийх эрх бүхий этгээд байdag. Нотариатчийн чиг үүрэг өнөөгийн нөхцөлд бие даасан шинжтэй болсон нь түүний оролцоотойгоор бурдуулсан баримт бичиг хүлээн зөвшөөрөгджэй, нотлох баримтын болон түүнийг гүйцэтгүүлэх хууль зүйн хүчин чадлыг бүрэн агуулж, нийтийн итгэл хүлээх болсонтой холбоотой юм.

Нотариатч нь бидний өнөөгийн амьдарч буй нийгэм дэх өмчийн харилцаанд голлох үүрэгтэй оролцод бөгөөд нотариатын үйлдэл хийх явцад гарз, хэлцлийн утга агуулга түүний улмаас үүсэх үр дагавар тэдгээр нь хууль тогтоомжтой нийцэж буй эсэхийг тайлбарлан таниуулж, иргэдийн хууль зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд тус дэхем болох ажлуудыг хийж, гүйцэтгэж байdag.

Тиймээс нотариат нь бичиг баримтад тавиедах нийтлэг шаардлага хангасан бичиг баримт гэдэг нь: Засваргүй, гаргацтай, баллаагүй, зохих гарын үсэг зурагдаж, тамга тэмдэг дарагдсан, тухайн бичиг баримтад шаардлагатай бусад материалын бүрэн бурдсан байхыг хэлнэ.

Бичиг баримтад тавигдах нийтлэг шаардлага хангасан бичиг баримт гэдэг нь: Засваргүй, гаргацтай, баллаагүй, зохих гарын үсэг зурагдаж, тамга тэмдэг дарагдсан, тухайн бичиг баримтад шаардлагатай бусад материалын бүрэн бурдсан байхыг хэлнэ.

Нотариатч байхгүй газар түүнийг орлон нотариатчийн үүрэг гүйцэтгэж ажиллах бөгөөд энэ нь дотоодод нотариатын үйл ажиллагааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр хавсрсан эрхэлж байгаа сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан, гадаадад Монгол улсын дипломат төлөөлгөчийн болон Консулын газрыг хэлнэ.

Монголын Нотариатчдын танхим нь Нотариатчдын танхимаас мэргжлийн өндөр түвшинд зохион байгуулдаг сонгон шалгаруулалтанд орж тэнцсэн, мэргжлийн хуульчдыг нэгтгэсэн гишүүддээс үйлчилдэг төрийн бус байгууллага юм.

Монголын Нотариатчдын танхим нь Улаанбаатар хотод байрладаг бөгөөд түүний салбар нь Монгол Улсын бүх аймаг, хотуудад үйл ажиллагаагаа явуулж байна. Энэөдөр Монголын Нотариатчдын Танхимын гишүүн нийт 149 нотариатч ажиллаж байгаагаас Улаанбаатар хотод 89 нотариатч, орон нутагт 60 нотариатч ажиллан байнгын үйл ажиллагаагаа эрхэлдэг.

Нотариатчдын танхимын эрх барих дээд байгууллага нь Нотариатчдын танхимын бүх гишүүдийн хурал юм. Уг хурлыг жилд нэг удаа зохион байгуулахын дараахаар бэлтгэлтэй ажлыг хангаж байна. Нотариатчдын танхимын хурлын чөлөөт цагт эрх барих дээд байгууллага нь Удирдах Зөвлөл нь 9 хүний бүрэлдэхүүнтэй.

Нотариатчдын танхимын гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлгэч хэрэгжүүлнэ. Нотариатчдын танхимын дэргэд байнгын ажиллагаатай дараахаар орон тооны бус зөвлөлүүдэд ажилладаг. Нотариатчийн тухай хууль, Нотариатчийн ёс зүйн хэм хэмжээ зөрсөн нотариатчид сахилгын шийтгэл ногдуулах асуудлыг хянан шийдвэрлэх буюу санал болгох эрх бүхий Сахилгын зөвлөл 5 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг,

Нотариатчийн тухай хууль, Нотариатчийн Хариуцлагын даатгалын сангийн ажиллах журмын биелэлтэнд хяналт тавьж, Хариуцлагын даатгалын сангийн шимтгэлийн орлогыг биелүүлэн, Нотариатчдын хариуцлагын даатгалын сангийн үйл ажиллагаагаа зохицуулах зорилго бүхий Хариуцлагын даатгалын зөвлөл сонгогдсон юм. Нотариатчдыг шаардлагатай мэдээлэл лавлагаа, гарын авлага, бусад материалыар хангаж, хууль тогтоомжийн, лавлагааны санг хөтөлбөр зорилго бүхий Мэдээллийн алба ажиллаж байна.

Монголын Нотариатчдын Танхимын дэргэд Нотариатчийн архивын ажиллаж бөгөөд Нийслэлийн нийт нотариатчдын 2002, 2003 оны материалын хадгалаагдаж, 2002 оноос өмнөх нотариатчдын архивын материалыг Нийслэлийн архивын газарт шилжүүлсэн бөгөөд лавлагаа хийгэхийг хувсэл тус газарт хандахыг зөвлөж байна. Нотариатчийн архивын материал нь Хууль хяналтын байгууллагын алч ч шатанд бичмэл нотлох баримт болж нотариатчдын хийсэн үйлдэл болон иргэд, байгууллага, ах ахуй нэгжийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах үнз цэнэ бүхий нотлох баримтууд байдаг юм.

Нотариатчдын танхим нь нотариатчдыг мэргжилт арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, нотариатч бэлтгэх, сургах, давтан сургах, тэдгээрийн эрх ашиг сонирхлыг төрийн болон төрийн бус байгууллагад төлөөлөх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тус дээмжлэг үзүүлэх, нотариатчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, нотариатч нь дор дурдсан бичиг баримтыг гарчлэх болон бусад эрх зүйн үйлдэл хийнэ.

1. Хэлцэл, гарээ, итгэмжлэл
2. Хуулийн этгээд үүсгэн байгуулах бичиг баримт
3. Өв залгамжлах эрх, гарээслэл

ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧИЛГЭЭ

4. Үл хедлех хөрөнгийн бүртгэлтэй холбогдох бичиг баримт
5. Гэр бүлийн гишүүдийн дундаа хамтран болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгөөс оногдох хувийн өмчлөх эрх
6. Бичиг баримтын хуулбарын үнэн зөв
7. Орчуулсан бичиг баримт
8. Бичиг баримтад зурсан гарын үсгийн үнэн зөв
9. Өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгох
10. Хууль тогтоомжид заасан бусад үйлдэл

Нэг. Гэрээ гарчлэх үйлдэл :

Гэрээнд оролцогч талууд хувсгал ямар ч гэрээг нотариатаар гэрчлүүлж болно. Үл хедлех эд хөрөнгетэй холбоотой бүх төрлийн гэрээг нотариатаар гэрчлүүлж, үл хедлех эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр хүчин төгөлдөр болдог.

2002 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн "Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулиар "Үл хедлех эд хөрөнгийг бусдад шилжүүлэхтэй холбогдсон аливаа хэлцэл болон өвлөх эрхтэй холбогдсон бичиг баримтыг зөвхөн тухайн эд хөрөнгө байгаа тойргийн нотариатч гэрчилнэ" гэж өөрчлөгдсөн бөгөөд үүнээс хойш дээрхи заалтыг баримтлан нотариатч нар дуурлаг хамааран гэрчилж байгаа. Харин бусад үл хедлех эд хөрөнгийг бусдад шилжүүлэхтэй холбогдсон аливаа хэлцэл болон өвлөх эрхтэй холбоотойгоос бусад баримт бичгийг гэрчлэхэд дуурэг хамаарахгүй юм.

Нотариатаар гэрчлэгдэх гэрээ нь :

- хуульд нийцсэн
- агуулга нь ойлгомжтой
- оролцогч талуудын эрх үүргийг тодорхой зааж егсен
- уг, үсгийн алдаагүй, засваргүй
- тамга дарж, гарын үсгээ зурсан
- хугацааг тодорхой заасан
- гарах үр дагаварыг тусгасан
- алданги, торгууль тооцох
- хариуцлага тооцох зэрэг шаардлагыг хангасан байна.

Нотариатч гэрээг гэрчлэхдээ уг гэрээ нь хуульд нийцж байгааг нягтлах төдийгүй үүнээс гарах үр дагаварыг талуудад тайлбарлах, хэлж өөхөн үүрэгтэй мөн уг гэрээг гэрчлэхэд шаардлагатай бүх бичиг баримтыг шалган нягталж нотариатын архивт үлдэх нэг хувь гэрээнд хавсаргаж авна.

ХУУЛЬЧДЫН ДУНДААС ТӨРСӨН АНХНЫ АКАДЕМИЧ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирал
Хууль зүйн шинжлэх ухааны доктор,
профессор, Академич
С.Нарангэрэл хариулж байна.

Уламжлал ёсоор манай уншигчдад Төвөөрийгөө товч танилцуулна уу?

- Могой жилтэй. МУИС-ийн хуулийн анги тэгсгээд сургуульдаа багшаар үлдэх, 10 жил ажиллаад Нийслэлийн прокурорын орлогч, Улсын өрөнхий прокурорын туслах багеед Шүүн таслах ажиллагаанд хяналт тавих хэлтсийн даргаар ажиллаж байгаад 1990 онд өөрийн хүснэгтээр эрдэм шинжилгээний ажилд шилжсон. Засгийн газрын дэргэдэх төрийн бодлого, нийгмийн асуудал судлах төвд эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Улсын Бага Хурлын дэргэдэх Төр, нийгэм судалын Академийн дэд захирлаар ажиллах байгаад Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсон. 1992 оны Үндсэн хуулиар байгуулагдсан анхны УИХ-д ажиллах аз жавшаан тохиолдож, дараа нь МУИС-даа үргэлжлүүлэн багшилж байна даа.

Таны авв хуульч хүн, хууль сахиулах байгууллагад дээд албан тушаалд ажиллаж байсан гэж дуулсан юм. Та энэ мэргэжлийг сонгоход авв тань нөлөөлсөн нь дамжигтгүй, ер нь удам дамжсан хуульч их олон байдаг болов уу? Нэрлэх ...

- Аав нь хуульч учраас үр хүүхдээдээ мэргэжлээ өвлүүлсэн тохиолдол цөөнгүй байдаг. Үүний тоочилж нэрлэн гэвэл маш урт жагсаалт гарах баа. Гэхдээ энэ асуудлыг чанарын хувьд өөрөөр хэлбэл мэргэжлийг нь нэр төртэй залгамжилж, хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан хувь нэмэрээр нь авч үзвэл миний авв Б.Содоловсурэн 1950-аад онд Москвад Ломоносовын нэрэмжит их сургууль тэгссэн тэр үеийнхээ өндөр боловсролтой, манай улсын анхны эрдэмтэн хуульчдын нэг, нэлээд олон ном бичсан, монголын хуульчдын бүхэл бутэн үеийн /1960, 1970-аад оны/ багш хүн байсан юм.

Энэ утгаар нь авч үзвэл миний хувьд ававынхаа бүх ажил үйлийг үргэлжлүүлж, түүний хийж бүтээсэн зүйлийг улам урагш ахиулсан гэж хэлэхэд намайг хүмүүс даруу бус авш авир гаргалаа гэхгүй байх ба.

Монголд ардчилал дөнгөж өрнөж эхэлж байсан үе санагдана. Тэр үед Та Улсын Ерөнхий прокурорын газарт ажиллаж байсан байхaa. "Чойномд тулгасан ял" гэж бэсрэг ном бичсэн билээ. Чойномыг дээд түвшиндээ ойлгоход Таны тэр ном ихээхэн хувь оруулсан нь мэдээж л дээ. Цаг төдийлөн "наашлаагүй" үед энэ ном гаргасныхаяа төлөө Та дээрээс лавтай "банга" хүртсэн байх даа гэж тухайн үед бодогдох байсан юм л даа?

ДУГААРЫН ЗОЧИН

- Дэлхийн "хүйтэн" дайн төгсгөлийн шатаандаа орж, ЗХУ болон түүний нөлөөнд байсан улс орнуудад ардчилсан хөдөлгөөн өрнөсөн 1980-аад сны суулчээр манай оронд хүний эрхийн асуудалтай холбогдсон хэд хэдэн хэргийн асуудал хурцаар босож ирсэн ѿе л дээ. Ер нь манай оронд явагдсан ардчилсан хөдөлгөөнийг эрчимжүүлэхэд яруу найрагч Р.Чойномын "хэрэг" чухал нөлөө узуулсан юм. Энэ үед би Улсын Ерөнхий прокурорын газрын шүүн таслах ажиллагаанд хяналт тавих халтсийн даргаар ажиллах байлаа. Миний хариуцсан прокурорын шүүхийн энэхүү хяналт тэр үед ямарч хэргийг татах хянаж, шаардлагатай бол Улсын Ерөнхий прокурорын эсэргүүлийн тесел бэлтгэж, тэр зөвшөөрөвлөв Улсын Дээд Шүүхийн бүгд хуралд оруулж хянан хэлэлцүүлдэг эрх хэмжээтэй байв.

Би 1988 онд Р.Чойномыг холбогдуулан дөрвөн жилийн хорих ял шийтгэсэн төрийн зэрэг онц аюултай гэмт хэргийн материалыг НАХЯ-ны архиваас татуулж уншиж судалсан. Тэр хэрэг улсын маш нууцын зэрэглэлд байлаа. Улсын Дээд Шүүхийн бүгд хуралд Ерөнхий прокурорын эсэргүүцэл бичүүлж, Р.Чойномын үйлдэлд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байх тул цагаатгах шаардлагатай юм гэж танилцуулахад тэр үеийн Улсын ерөнхий прокурор Р.Ж.Балжинням асан/- цаг нь болоогүй байна гээд цаараглж билээ.

Р.Чойномын хавтаст хэргийг уншижад өрөөсөө л яруу найраг, уран зохиол уншсан юм шиг маш их сонирхолтой байж билээ. Тэр үед "Канон" /хувилагч/ гэх зүйл байсангүй. Би олон хоног сууж Р.Чойномын хэргийн материалыг тэмдэглэж аваад номын сандaa хадгалихсан байв.

1990 онд эрдэм шинжилгээний ажилд шилжсэн үедээ ном болгон бичих, Монголын уран зохиол хэвлэлийн газар /Ерөнхий редактор нь ардын уран зохиолч Д.Пүрэвдорж гуй байсан/ 50 мянган хувь хэвлэж гаргасан. Энэ нь манай орны хувьд дэндүү олон шүү дээ. Борлогдох болов уу, яах бол гэж санаа илзээд зовниж байсан боловч бараг тэр дороо шахуу дуусаж билээ. Энэ ном манай улсад ардчилсан хөдөлгөөн ялахад чухал нөлөө үзүүлсан гэж зарим хүмүүс ярьдаг байсан шүү.

Японы монгол судлаач эрдэмтэн эл номыг Монгол улсад ардчилал зрийн цээнд хурсний баталгаа гэж Японы нэр хүнд бүхий олон уншигчидтай сэтгүүлд бүр 1993 онд бичсэн байна лээ.

Таныг хуульчид төдийгүй, олон түмэн сайн мэддэг. Та нийгэм, улс төрийн амьдралд ихээхэн нөлөөтэй хүн билээ. Харин эрдэм оюуны ажлын сэдэв чиглэл үншигчдад сонирхолтой байх болов уу гэсэн үүднээс асууж байна. Та хэдэн онд, хаана, ямар сэдвээр дэд эрдэмтэн, шинжлэх ухааны доктор хамгаалсан бэ?

- Энээс аспирантурт суралцаж 1988 онд Москвад "БНМАУ-ын эрүүгийн хууль тогтоомжийг боловсрунгуй болгох асуудал" сэдвээр хууль зүйн ухааны дэд эрдэмтний зэрэг, хожим нь "ХХ зууны Монгол Улсын эрүүгийн эрх зүйн үндсэн асуудал" сэдвээр хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг тус тус хамгаалсан.

Та хуульчдын дундаас тэрсен анхны академич. Энэ эрхэм алдарт хүргэхэд эрдэм оюуны мөн их "бартавт зам"-ыг тулсан байж таарна. Та мэргэжлийн онолын чиглэлээр олон ном туувисан. Энэ талаар уншигч олонготой сэтгэгдлээ хуваалцана уу?

- Эрдэм судлалын ажил оюуны хамгийн хүнд хучир үйл ажиллагаа.

Эрдэмтэн болоход эрдэм шинжилгээний ажилд дур сонирхолтой байх, судлагааны асар их материал цуглуулах, арга зүй зээмшиж, цөхрөлтгүй хөдөлмөрлөж, "чөмгөө таштал" суух гээд өөрөөс шалтгаалах зүйл гол боловч бусад хүчин зүйлийн налееч ч их байдаг. Аав эрдэмтэн байсан учраас түүний угзэр дуурналал, гэрийн хумуужил чухал налееч үзүүлсэн. Багш нар, эрдэмтэд ч их тус хүргэсэн дээ.

Академич Б.Ширэндэв гуай 1990-ээд оны эхээр – Танай хуулийн эрдэмтэд дандаа л эрүүгийн эрх зүй судлалруугаа хошуурах юм. Хууль зүйн шинжлэх ухааны нийтлэг онон чинь хоцрогдоод байгаа юм биш үү гэж маш чухал санаа надад өгсөн нь сэтгэл зурхний минь утг байнга явдаг. Миний багш доктор, профессор Г.Совдын дэмжилэг маш их дээ. Доктор, профессор Б.Чимид багш надад "суух цуцалтгүй ажиллах чадвар"-ыг нутагшуулсан хүн байгаа юм.

Хуучин тогтолцооны үед бичсан "БНМАУ-ын иргэний эрх, үүрэг" /1983/, "БНМАУ-ын засан хүмүүкуүлэх эрх зүйн үндсан асуудал" /1985/, "Эрх зүйн хүмүүжил" /1986/, "Гэмт хэрэг зүйчлэх шинжлэх ухааны үндэс" /1988/ зэрэг ном маань шинжлэх ухааны ач холбогдоо алдаагүй байна.

Улс орон маань хууль дээдлэх, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээс хойш "Англи-Монгол-Орос хууль зүйн толь" /1994/, "Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн ерөнхий анги" /1998/, "Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо" /2001/, "Амьд эрх зүй" /2002/, "Монгол Улсын эрх зүйн тогтолцооны удиртгал" /2003/ зэрэг ном бичлээ. Эдгэрээс "Монгол Улсын эрх зүйн тогтолцооны удиртгал" гэсэн ном маань англи, герман, орос, хятад хэлнээ орчуулагдаж байна.

Манай хуульчид, оюутан залуус хууль зүйн өртөнцийн шинэ бүтээлтэй танилцаж, мэдлэгээ байнга сэлбэж яваасай. Хууль зүйн салбарт хоцрогдол, мэдлэгүйдэлт ихээхэн газар авчээ. Энэ нь улмаар хүний эрх, эрх чөлөө, ардчилсан үнэт зүйлст хор хохирол учруулж байна.

Би мэргэжлийн бус учраас ялгаж ойлгох чадахгүй байх шиг. Нэг хэсэг хуулийн чиглэлээр төгссөн хүнийг эрх зүйч мэргэжилтэй, хуульч цолтой гээд байсан санагдана. Гэтэл гадаадад болохоор хуульч болох шалгур үзүүлэлт арай өөр байдаг гэсэн. Энэ талаар манай тогтсон ямар ойлголт байна вэ? Ер нь хуулийн сургууль төгссөн хүн бүр хуульч мөн үү?

- 1992 оноос өмнө хууль зүйн хувийн хэвлэлийн их, дээд сургууль гэж байсангүй. Иргэний чиглэлийн хуульчдын зөвхөн МУИС-д балтгэх хууль зүйн дээд боловсрол эзэмшиүүлж байв. Энэ үед төгсгөлтийн шалгалтыг улсаас авч, хуульч цол шууд олгодог байсан юм. Гэтэл сүүлийн жилүүдэд хувийн хууль зүйн сургуулиуд борооны дараахь меег шиг олширч, сургалтын чанар, мэргэжилтний бэлтгэл үнэхээр муудсан. Туршлагатай,

ДУГААРЫН ЗОЧИН

эрдэм мэдлэгтэй, чадвартай багшлах боловсон хүчингүй, дэнгэж сургууль төгсчөхийн дэргэдээ зааж чиглүүлэх, халааг нь нэр төртэй үргэлжлүүлэх, углэр дууриалал авах багшгүй хүмүүс хууль зүйн дээд боловсролын сургалт явуулна гэдэг хэрээс хэтэрсэн, ухаан санаанд багтамгүй асуудал юм шиг бодогдог.

Насаараа багшийн ажил хийсэн бид ч өөртөө хатуу шаардлага тавьж, толгой дээш таталгүй суухгүй бол хоцорчих гээд байна шүү дээ. УИХ-аас баталсан хуульчдыг сонгон шалгаруулах хуулиар манай орны хууль зүйн их, дээд сургууль төгсчэгчид эрх зүйн дээд боловсролтой хүмүүс болно. Харин тэд шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, өмгөөлөгч болохыг хувсвэл дахин сонгон шалгаруулалтыг давж гарах хэрэгтэй болжээ.

Та 1992-1996 онд Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллахдаа хэдэн хууль санаачлан батлуулсан. Тэр дотроос онцлон тэмдэглэж ямар ямар хуулийг нэрлэх вэ?

- "Захиргааны хариуцлагын тухай", "Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" ... гээд их олон хууль батлуулахад оролцжээ. Миний сонгогдон ажиллаж байсан шинэ Үндсэн хуулиар байгуулагдсан анхны УИХ ардчилсан тогтолцооны эрх зүйн үндсийг бурднуулжээд чухал үүрэг гүйцэтгэж, хамгийн их ачалалтай ажиллаж байсан. Эрүүгийн хуулийг Үндсэн хуульд нийцүүлэх зайлшгүй шаардлага үүдэж тэрхүү зарчмын шинжтэй томоохон нэмэлт өөрчлөлтийг дангаараа боловсруулан санаачилж, хууль сахиулах байгууллагуудтайгаа зөвшилцэн батлуулж явалаа.

1996 оны УИХ-ын сонгуульд Та "Ардчилсан холбоо" эвслээс нэр дэвшсэн Б.Далгэрмаад унласан. Сонгочид та хоёрыг аль аль нь УИХ-д зайлшгүй байх мэргэжлийн хуульчид, хүчтэй өрсөлдөгчид таарлаа. Ийм хоёр хүнийг нэг тойротг өрсөлдүүллээ гэж буруут нэр дэвшүүлсэн намд тохиж байсан. Хэдий тодорхой хугацаа өнгөрсөн ч нийгмийн сэтгэлд зүйд нэлэөлсөн чухал асуудалд Та тухайн үедээ хэрхэн хандсан бол ...

- Б.Далгэрмаа бид хоёрын хэн нэг нь УИХ-ын гишүүний ачааг үүрэх байсан. Монголын чадалтай хуульч эмэгтэйд улс төрийн тэмцэлд "ялагдах", дадаж сурсан багшлах, эрдэм судлалын ажлаа үргэлжлүүлэх боломж надад олдсонд би дотроо баярлаж явдаг. Одоо Б.Далгэрмаа экс гишүүн манай сургуулийн дохторант, би туүний эрдэм шинжилгээний удирдагч. Би Б.Далгэрмаад хосгүй сайхан зэж, авынгаа энх тунх байхад нь чи ганцхан хүслийг нь биелүүлж чадаагүй. Доктор болчихвол бурханы орноос аав, зэж чинь охиноороо бахархах болно гэж захиагд юм.

Та угийн өмгөөлөгч, бүр Монголын өмгөөлөгчдийн холбоог тэргүүлж байлаа. Томоохон хэрэг явдалд орооццолдсон олон хүмүүсийг өмгөөлж байсан. Өмгөөллийн ажил манайд ямар төвшинд байдаг вэ? Гаднаас ажиглаж байхад өмгөөлөгч нарт цагдаа, мөрдөнгийнхэн тийм ч таатай биш байдаг бололтой. Энэ талаар Таны сэтгэгдлийг сонсмоор байна?

- Мэтгэлцээний зарчмыг удирдлага болгодог шүүн таслах ажиллагаваны хөдлөгч хүч нь өмгөөлөгчид байх ёстой. Өмгөөлөгчид мэргэжлийн өндер ур чадвартай, ёс зүйн зарчимдаа үнзнич, үйлчлүүлэгчийнхээ хууль ёсны эрх ашигийг туштай хамгаалдаг байдал, шударга, хараат бус, гапцхуу хуульд захирагдаг шүүхийг буй болгоход үнэлж баршгүй тус дэхем үзүүлнэ. Сайн өмгөөлөгчдөөс шүүгч, прокурор, мөрдөн байцааг хэрэг асуудлыг шийдвэрлэхдээ их зүйл сурч мэдэж авдаг шүү дээ.

Та одоо МУИС-ийн Хууль зүйн сургуулийн захирлаар ажилладаг. Энэ сургуульд элсэхийг хүсэгчид улам л нэмэгдээд байх юм. Гэтэл хуульч мэргэжлийн хүн ажиллах орон тоо хязгаартай. Энэ нь хуульч болох гэсэндээ юу, эсвэл танай сургуулийн сургалт сайн байдгийнх уу?

- МУИС-ийн Хууль зүйн сургууль бол дээд боловсролтой хуульчдыг эх орондоо анх бэлтгэсэн түүхэн уламжлалтай бөгөөд манай улсын хууль зүйн дээд боловсрол, шинжлэх ухааны үндэсний хамгийн том хүчтэй төв мен. Манай сургуульд хамгийн нэртэй эрдэмтэд, судаачид ажилладаг. Хууль зүйн шинжлэх ухааны гол бутгэлүүд эндээс гардаг. Энэ сургуулийт удирдаж байгаа миний хувьд ажлын цагийн нэлээд хэсгийг хууль зүйн бусад сургуулиас шилжик манайд суралцах гэсэн хүснэгтийг шийдвэрлэхэд зориулдаг. Тэгэхээр манай сургалтын чанарт, сургуулийн нэр хүндэд байдаг байх ва. Хэрэв байр сав хангальтайсан бол бүгдийг нь гомдоохгүй юм сан гэж боддог.

Та хууль зүйн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлийн дарга сонгуулжтай. Энэ зөвлөлөөр эрдмийн зэрэг хамгаалж буй хумуусийн эрдмийн ажлын чанар /төвшин/ сайн гэж эрдэмтээс сонсож байсан юм. Эрдмийн томоохон энэ зөвлөлийг тэргүүлж буй хүний үгийг өөрөөс нь сонсох нь зөв байхаа?

- Манай орны хамгийн том нэр хүндтэй эрдэмтдээс бүрэлдсэн зөвлөлийг удирдах нь нэр хүндтэй бас хариуцлагатай ажил үйлс байдаг. Хууль зүйн эрдэм судпалын бүлд сайн бутгээл, чадварлаг судлаач төрүүлэхэд манай эрдмийн зөвлөлийн гишүүдийн хүчин чармайлт төвлөрдөг. Хууль зүйн чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл зөвхөн манай сургууль дээр байдаг. Эрдмийн зэрэг хүртчихээд түүнийхээ нэр төртэй эзэн нь болж явна гэдэг уг хүнээс л цаашдаа шалтгаалдаг.

Та нэг сонинд өгсөн ярилцлагадаа миний хамгийн үнэтэй юмны нэг нь “Миний хувийн номын сан” гэсэн байсан. Та яак тийм их ном цутгуулж чадсан болоо, тэгээд номын сангийнхаа тухай ярина уу?

- Үе дамжсан эрдэмтэн хуульчдын бүрдүүлсэн номын сан юм даа. Ер нь сайн номын сангийгээр чадалтай хуульч болж чадахгүй л дээ. Хуульч хүнд мэргэжлийн ном, зохиол, хууль тогтоомжоос гадна бусад шинжлэх ухааны мэдээлэл ч чухал хэрэгтэй болдог. Ер нь миний номын сан баялаг, ховор ном ч их бий дээ.

ШИНЭ НОМ, СОНИН, СЭТГҮҮЛ

ТАНД, ТАНАЙ БАЙГУУЛАГАД ЧУХАЛ ХЭРЭГЦЭЭТЭЙ ГАРЫН АВЛАГУУД

НОМ

- * МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД - 6
- * МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД - 8
- * МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД - 9
- * МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД - 10
- "ГАЗАР" Монгол Улсын хууль тогтоомжийн эмхтэгэл
- * МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛЬ, ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
- * МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХУУЛЬ, ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ
- * ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН ТАЙЛБАР
- * ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ (эмхтэгэл)
- * ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ
- * ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ БАЙГУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ
- * МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ
- * МОНГОЛ УЛСЫН ИРГЭНД ГАЗАР ӨМЧЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ /өврийн 10x14 см/
- * БИЗНЕСИЙН ЭРХ ЗҮЙ /гарын авлагал/
- * ШҮҮХИЙН МЭТГЭЛЦЭЭН /Д.Зүмбэрэлхам /
- * ӨМГӨӨЛӨГЧИЙН МЭТГЭЛЦЭХ ҮР ЧАДВАР /Д.Зүмбэрэлхам/
- * ОЛОН УЛСЫН АРИЛЖААНЫ АРБИТР /Д.Уянга/
- * ОЛОН УЛСЫН ЭРҮҮГИЙН ШҮҮХ
- * МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙ /С.Төмөр/
- * БҮХ ШАТНЫ ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ЭМХТГЭЛ
- * ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ, ТҮҮНЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, НИЙГМИЙН ДЭГ ЖУРАМ ХАНГАХ ТАЛААР ГАРГАСАН БАРИМТ БИНГИЙН ЭМХТГЭЛ
- * МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛЫН ЭМХТГЭЛ
- * МОНГОЛ УЛСЫН ХУУЛИУД /эмхтгэл/
- * SELECTED COMMERCIAL LAWS OF MONGOLIA
- * COMMERCIAL LAWS OF MONGOLIA

СОНИН СЭТГҮҮЛ

- "ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ" сэтгүүл
- "ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЕС" сэтгүүл
- "ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭ" сонин

Сэтгүүлийн нэгдсэн зөвлөл

Хаяг: Улаанбаатар – 46, Үндсэний архивын газрын 2065 тоот өрөө

Индекс – 14279

Утас: 322094, 315789, 315734

**Факс: 976-11-322094
976-11-315789**

**Хууль тогтоомж, шүүх эрх мэдлийн эрдэм шинжилгээ,
сургалт, мэдээлэл, сурталчилгааны үндэсний төв**